



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ*

* Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын "Verwaltungsgerichtsordnung (VwGO)" хуулийг шууд утгачлан монгол хэлнээ хөрвүүлбэл "Захиргааны хэргийн шүүхийн тухай хууль" хэмээн бууна. Орчуулагчдын зүгээс агуулгын хувьд орчуулах арга зүйг хэрэглэн "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль" хэмээн буулгасан болно.

Редактор:

Т.Мөнх-Эрдэнэ (LL.M), Нийслэл дэх Захиргааны
хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч

Англи хэлнээс орчуулсан:

Б.Дөлгөөн (Ph.D), Шүүхийн академийн судалгааны
төвийн дарга

Н.Хулан (LL.M), Шүүхийн академийн Захиргааны эрх
зүйн секторын эрхлэгч

М.Ананд Шүүхийн академийн судлаач

О.Тэнхлүүн (LL.M), Шүүхийн академийн судлаач

П.Чинунар (LL.M), Шүүхийн академийн судлаач

Л.Энхсайхан Шүүхийн академийн судлаач

Эх бэлтгэсэн:

Цаасны хэмжээ:

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн газар:

Д.Насанжаргал

B5 /176x250мм/

7

Хөх Монгол Принтинг ХХК

ТОВЬЁГ

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....	25
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ БА ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ.....	60
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАРДАЛ БА ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ.....	73
ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН БА ШИЛЖИЛТИЙН ЗААЛТУУД.....	79
НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГА	85
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БҮТЭЦ, ХЭЛЛЭГИЙН ОРЧУУЛГА	87

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ¹

- 1960.01.21 -

Нэгдүгээр бүлэг.

ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

Хоёрдугаар бүлэг.

ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Гуравдугаар бүлэг.

ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ

БА ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

Дөрөвдүгээр бүлэг.

ЗАРДАЛ БА ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ

Тавдугаар бүлэг.

ТӨГСГӨЛИЙН БА ШИЛЖИЛТИЙН ЗААЛТУУД

¹ Холбооны хууль зүй болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах яамны албан ёсны цахим хуудас: https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

Нэгдүгээр хэсэг. ШҮҮХ

§1

Захиргааны шүүн таслах эрх мэдлийг захиргааны байгууллагаас хараат бус, бие даасан шүүх хэрэгжүүлнэ.

§2

Муж улс бүр захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхтэй байх бөгөөд Холбооны захиргааны хэргийн шүүх Лейпциг хотод байрлана.

§3

(1) Хуулиар дараах харилцааг зохицуулна.

1. захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг байгуулах, татан буулгах,
2. шүүхийн байрлал өөрчлөх,
3. шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалал өөрчлөх,
4. хэд хэдэн захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамардаг шүүхийн ажил хуваарилалт,
- 4а) §52.2-ын 1, 2 эсхүл 5 дахь өгүүлбэрт заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөр захиргааны хэргийн шүүх эсхүл хэд хэдэн муж улсын захиргааны хэргийн шүүхэд хуваарилах,
5. анхан шатны шүүхийн танхим эсхүл давж заалдах шатны шүүхийн сенатыг бусад байршилд байгуулах,
6. харьяалал нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтаар тодорхойлогдохгүй тохиолдолд, 1, 2, 3, 4а дахь хэсгийн дагуу хийгдэж буй ажиллагааг өөр шүүхэд шилжүүлэх.

(2) Хэд хэдэн муж улс хамтарсан шүүх эсхүл хамтарсан шүүх бүрэлдэхүүн байгуулах, эсхүл мужийн хилийг даван шүүхийн тойргийг өргөтгөх талаар тохиролцож болно.

§4

Захиргааны хэргийн шүүхүүдэд Шүүхийн тухай хуулийн 2-р бүлгийн

заалтуудыг хэрэглэнэ. §99.2-т заасан шийдвэр гаргах шүүх бүрэлдэхүүний гишүүдийг болон орлогч 3 гишүүдийг Тэргүүлэгчид тус бүр 4 жилийн хугацаатай томилно. Гишүүд болон тэдний орлогчид нь бүх насаараа томилогдсон шүүгч байна.

§5

(1) Захиргааны хэргийн анхан шатны шүүх нь Ерөнхий шүүгч, даргалагч шүүгч болон шаардлагатай тооны бусад шүүгчдээс бүрдэнэ.

(2) Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд танхимуудыг байгуулна.

(3) Шүүгч дангаараа шийдвэр гаргахаас бусад тохиолдолд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн танхим нь гурван шүүгч, хоёр иргэдийн төлөөлөгч шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана. Аман хэлэлцүүлэг явуулахгүйгээр шүүхийн шийдвэр (§84) гаргах тохиолдолд иргэдийн төлөөлөгч оролцохгүй.

§6

(1) Дараах тохиолдолд танхим гишүүдийнхээ аль нэгэнд дангаар шийдвэрлэх эрх олгоно.

1. тус хэрэг үйл баримтын эсхүл хууль хэрэглээний хувьд онцгой ээдрээ төвөггүй байх,
2. тус хэрэг зарчмын ач холбогдолгүй байх.

Туршилтын хугацааны эхний жил дуусгавар болоогүй шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэж болохгүй.

(2) Хэрэв тухайн хэрэг өмнө нь танхимд амаар хэлэлцэгдсэн бол хэргийг дангаар шийдвэрлүүлэхээр шилжүүлэхийг хориглоно. Нөхцөлт, хэсэгчилсэн, эсвэл явцын шийдвэр гарсан бол уг хориг хамаарахгүй.

(3) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас тус хэрэг зарчмын ач холбогдолтой, үйл баримтын эсхүл хууль хэрэглээний хувьд ээдрээ төвөгтэй нөхцөл байдал үүсвэл оролцогч талуудын байр суурийг сонссоны дараа шүүгч уг хэргийг танхим руу буцааж болно. Энэ тохиолдолд шүүгч дангаар шийдвэрлэхээр дахин шилжүүлж болохгүй.

(4) 1 болон 3 дахь хэсэгт заасны дагуу гаргасан шийдвэр нь эцсийнх байна. Хэргийг шилжүүлээгүй нь давж заалдах үндэслэл болохгүй.

§7 болон §8 (хүчингүй болсонд тооцсон)

§9

(1) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь Ерөнхий шүүгч,

даргалагч шүүгч болон шаардлагатай тооны бусад шүүгчдээс бүрдэнэ.

(2) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд сенатуудыг байгуулна.

(3) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн сенат нь 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана; мужийн хууль тогтоомжид зааснаар сенат нь 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй, тэдгээрийн 2 нь иргэдийн төлөөлөгч шүүгч байж болно. §48.1-д заасан маргааны хувьд сенат нь 5 шүүгч, 2 иргэдийн төлөөлөгч шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргахаар зааж болно. 1 дэх өгүүлбэрийн 2 дахь хагас болон 2 дахь өгүүлбэр нь §99.2-т заасан тохиолдолд хамаарахгүй.

(4) Дараах тохиолдолд §48.1-ийн 3-15-д заасан маргааныг сенат дангаар шийдвэрлүүлэхээр өөрийн нэг гишүүнд шилжүүлж болно.

1. тус хэрэг үйл баримтын эсхүл хууль хэрэглээний хувьд онцгой ээдрээ төвөггүй байх,

2. тус хэрэг зарчмын ач холбогдолгүй байх.

§6.2-ын 4-т заасан зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

§10

(1) Холбооны захиргааны хэргийн шүүх нь Ерөнхий шүүгч, даргалагч шүүгч болон шаардлагатай тооны бусад шүүгчдээс бүрдэнэ.

(2) Холбооны захиргааны хэргийн шүүхэд сенатуудыг байгуулна.

(3) Холбооны захиргааны хэргийн шүүхийн сенат нь 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана. Аман хэлэлцүүлэг явуулаагүй бол 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэр гаргана.

(4) Дараах тохиолдолд §50.1-ийн 6-д заасан маргааныг сенат 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ;

1. тус хэрэг үйл баримтын эсхүл хууль хэрэглээний хувьд онцгой ээдрээ төвөггүй байх,

2. тус хэрэг зарчмын ач холбогдолгүй байх.

§6.2-ын 4-т заасан зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

§11

(1) Холбооны захиргааны хэргийн шүүхэд Их Сенатыг байгуулна.

(2) Аль нэг сенат хууль зүйн асуудлаар бусад сенатын эсхүл Их Сенатын шийдвэрийн эсрэг байр суурьтай байвал Их Сенат шийдвэр гаргана.

(3) Зөвхөн дараах тохиолдолд Их Сенатад хандах боломжтой; тухайн шийдвэрээс зөрүүтэй шийдвэр гаргах гэж буй бүрэлдэхүүн нь хэлэлцэж буй бүрэлдэхүүний хүсэлтийн дагуу, "өөрийн хууль зүйн байр суурийг хэвээр хадгалж байна" гэж мэдэгдсэн байх шаардлагатай. Хэрэв зөрүүтэй шийдвэр

гаргах гэж буй бүрэлдэхүүн ажлын хуваарилалтын өөрчлөлтийн улмаас тухайн хууль зүйн асуудлыг дахин авч хэлэлцэх боломжгүй болсон бол, ажлын хуваарилалтын дагуу харьяалал бүхий шүүх бүрэлдэхүүн нь түүний оронд оролцоно. Хүсэлт болон хариуг тухайн сенат нь бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ.

(4) Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзвэл тухайн асуудлыг Их Сенатад шилжүүлж болно.

(5) Их Сенат нь Ерөнхий шүүгчээс гадна, Ерөнхий шүүгч өөрөө ахалдаггүй давж заалдах сенат тус бүрийн нэг шүүгчээс бүрдэнэ. Хэрэв бусад сенатаас санал ирүүлсэн эсхүл зөрүүтэй шийдвэр гаргахаар байгаа бол тухайн сенатын нэг гишүүн Их сенатын бүрэлдэхүүнд орно. Ерөнхий шүүгчийн эзгүйд түүний харьяалагддаг сенатын нэг шүүгч орлоно.

(6) Гишүүд, орлогч гишүүдийг Тэргүүлэгчид нэг жилийн хугацаатай томилно. 5 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрт заасан өөр сенатын гишүүн, түүнийг орлогч гишүүнд мөн адил үйлчилнэ. Их Сенатыг Ерөнхий шүүгч, түүний эзгүйд хамгийн ахмад гишүүн даргална. Санал тэнцвэл шүүх хуралдаан даргалагч шийдвэрлэх эрхтэй.

(7) Их Сенат зөвхөн хууль зүйн асуудлаар шийдвэр гаргана. Их Сенат аман хэлэлцүүлэг явуулахгүйгээр шийдвэр гаргаж болно. Гаргасан шийдвэрийг танилцуулга хийсэн сенат заавал биелүүлэх үүрэгтэй.

§12

(1) Муж улсын хуулийн тодорхой асуудлыг эцэслэн шийдвэрлэх тохиолдолд §11-д заасныг хэрэглэнэ. Энэ тохиолдолд давж заалдах сенатууд хяналтын шатны сенатуудыг орлоно.

(2) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь зөвхөн хоёр давж заалдах шатны сенатаас бүрддэг бол Их Сенатыг Нэгдсэн Сенат орлоно.

(3) Муж улсын хуулиар Их Сенатын бүрэлдэхүүнийг өөрөөр тогтоож болно.

§13

Шүүх бүр тамгын газартай байх бөгөөд шаардлагатай тооны бичиг хэргийн ажилтантай байна.

§14

Бүх шатны шүүх болон захиргааны байгууллагууд нь захиргааны хэргийн шүүхүүдэд хууль зүйн болон захиргааны туслалцаа үзүүлнэ.

Хоёрдугаар хэсэг. ШҮҮГЧ

§15

- (1)§§16 болон 17-д өөрөөр заагаагүй бол шүүгчийг бүх насаар нь томилно.
- (2)(хүчингүй болсонд тооцсон)
- (3)Холбооны захиргааны хэргийн шүүхийн шүүгч 35 нас хүрсэн байна.

§ 16

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон анхан шатны шүүхүүдэд бусад шүүхийн бүх насаараа томилогдсон шүүгч эсхүл хууль зүйн их сургуулийн профессорыг хоёроос доошгүй жилийн хугацаатай гэхдээ үндсэн албан тушаалынх нь хугацаанаас илүүгүй хугацаагаар үндсэн бус шүүгчээр томилж болно.

§17

Захиргааны хэргийн шүүхүүдэд дараах шүүгчдийг томилж болно:

1. туршилтын хугацааны шүүгч,
2. томилолтын шүүгч,
3. хугацаат шүүгч.

Зүүлт тайлбар

§17.3: Үндсэн хуульд нийцсэн, Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр

2018.03.22 - 2 Үндсэн хуулийн шүүхэд гаргасан гомдлын дугаар 780/16 -

§18

Түр хугацааны хүний нөөцийн хэрэгцээг хангах зорилгоор шүүгчийн албан тушаал хаших болзол хангасан, бүх насаараа томилогдох төрийн жинхэнэ албан хаагчийг хоёроос доошгүй жил, үндсэн албан тушаалынх нь хугацаанаас илүүгүйгээр хугацаат шүүгчээр томилж болно. Германы шүүгчийн тухай хуулийн §15.1-ийн 1, 3 дахь өгүүлбэр болон §15.2-ыг хэрэглэнэ.

Зүүлт тайлбар

§18: Шийдвэрийн тогтоох хэсгийн томьёолол Үндсэн хуульд нийцсэн, Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр 2018.03.22 - 2 Үндсэн хуулийн шүүхэд гаргасан гомдлын дугаар 780/16 -

Гуравдугаар хэсэг. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ШҮҮГЧ

§19

Иргэдийн төлөөлөгч шүүгч нь аман хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах үйл явцад шүүгчийн адил тэгш эрхтэй оролцоно.

§20

Иргэдийн төлөөлөгч шүүгч нь 25 нас хүрсэн, тус шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалд оршин суудаг Герман улсын иргэн байна.

§21

(1) Дараах этгээд иргэдийн төлөөлөгч шүүгчээр оролцох эрхгүй.

1. шүүхийн шийдвэрийн дагуу төрийн албанд ажиллах эрхгүй болсон, эсхүл санаатай гэмт хэрэг үйлдэж 6 сараас дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн этгээд,
2. төрийн албан хаагчаар ажиллах эрхээ хасуулах гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдаж, шүүхийн шатанд хэргийг нь хэлэлцэж буй этгээд,
3. тухайн муж улсын хууль тогтоох байгууллагын сонгуульд санал өгөх эрхгүй этгээд.

(2) Санхүүгийн хямралд орсон этгээдийг иргэдийн төлөөлөгч шүүгчээр томилохгүй.

§22

Дараах этгээдийг иргэдийн төлөөлөгч шүүгчээр томилохгүй.

1. Бундестаг¹, Европын парламент, аль нэг муж улсын хууль тогтоох байгууллага, Холбооны эсхүл муж улсын засгийн газрын гишүүн,
2. шүүгч,
3. төрийн албан хаагч, төрийн албанд ажиллаж буй гэрээт ажилтан
4. цэргийн жинхэнэ болон гэрээт албан хаагч
- 4а. (хүчингүй болсонд тооцсон)
5. хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааг гуравдагч этгээдэд төлбөртэйгөөр үзүүлдэг өмгөөлөгч, нотариатч, ижил чиг үүрэг бүхий этгээд.

§23

(1) Дараах этгээд иргэдийн төлөөлөгч шүүгчээр томилогдохоос татгалзах эрхтэй.

¹ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Парламент.

1. санваартан, шашны байгууллагын ажилтан,
2. Эрүүгийн хэргийн шүүх болон бусад шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүгч,
3. Захиргааны хэргийн шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүгчээр хоёр удаа бүрэн эрхийн хугацаанд ажилласан этгээд,
4. эмч, сувилагч, эх баригч,
5. өөр эм зүйч ажилдуулдаггүй, эмийн сангийн эрхлэгч,
6. Нийгмийн халамжийн тухай хуулийн 6-р номд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн этгээд.

(2)Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд гаргасан хүсэлтэд үндэслэн иргэдийн төлөөлөгч шүүгчийн үүргээс чөлөөлж болно.

§24

(1)Дараах үндэслэлээр иргэдийн төлөөлөгч шүүгчийг үүргээс нь чөлөөлнө.

1. §§20-22-т заасан шаардлагыг хангахгүй болсон, томилж эсхүл томилох боломжгүй болсон,
2. албан үүргээ ноцтой зөрчсөн,
3. §23.1-д заасан үндэслэлээр татгалзсан,
4. албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах оюуны болон бие мах бодийн чадавхгүй болсон,
5. оршин суух газраа өөрчилсөн.

(2)Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд гаргасан хүсэлтэд үндэслэн цаашид иргэдийн төлөөлөгч шүүгчийн үүргээс нь чөлөөлж болно.

(3) §24.1-ийн 1, 2 болон 4-т заасан тохиолдолд анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн хүсэлтийн дагуу, мөн 1 дэх хэсгийн 3, 5 болон §24.2-т заасан тохиолдолд иргэдийн төлөөлөгч шүүгчийн хүсэлтийн дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн сенат шийдвэр гаргана. Иргэдийн төлөөлөгч шүүгчийн тайлбарыг сонсож танилцсаны дараа захирамж гаргана. Захирамжид давж заалдахгүй.

(4)Энэ зүйлийн §23.2-т заасан тохиолдолд 3 дахь хэсгийг хэрэглэнэ.

(5)§21.2-т заасан яллагдагчаар татагдсан этгээдийн, хэргийг хэрэгсэхгүй болгосон эсхүл цагаатгасан бол 3 дахь хэсэгт заасны дагуу гаргасан шийдвэрийг иргэдийн төлөөлөгч шүүгчийн хүсэлтэд үндэслэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн сенат хүчингүй болгоно.

§25

Иргэдийн төлөөлөгч шүүгчийг 5 жилийн хугацаагаар сонгоно.

§26

(1)Захиргааны хэргийн анхан шатны шүүх бүрт иргэдийн төлөөлөгч шүүгчийг сонгох хороо байгуулна.

(2)Хорооны шүүх хуралдаан даргалагчийн үүргийг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч гүйцэтгэх бөгөөд гишүүдээр нь муж улсын засгийн газраас томилсон төрийн албан хаагч мөн 7 иргэдийн төлөөлөгчөөс бүрдэнэ. Хорооны иргэдийн төлөөлөгч болон орлох төлөөлөгчдийг тухайн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тойргийн оршин суугчдаас тус муж улсын парламент, эсхүл парламентын томилсон хороо, эсхүл муж улсын хуулиар тогтоосон журмын дагуу сонгоно. Хорооны гишүүн нь иргэдийн төлөөлөгч шүүгчээр томилогдох шаардлагыг хангасан байна. Хорооны төрийн албан хаагчийг томилох эрхийг холбогдох журамд өөрчлөлт оруулах замаар 1 дэх өгүүлбэрт зааснаас өөрөөр зохицуулах эрхийг муж улсын засгийн газар эдэлнэ. Мөн тус эрхээ муж улсын захиргааны дээд байгууллагуудад шилжүүлж болно. §3.2-т заасан тохиолдолд төрийн албан хаагчийг томилох, иргэдийн төлөөлөгчдийг сонгох мужийг тухайн шүүхийн байршлаар тогтооно. Энэ тохиолдолд холбогдох муж тус бүр нэг төрийн албан хаагч, хоёроос доошгүй иргэдийн төлөөлөгчийг хороонд томилохоор зааж болно.

(3)Хороо нь даргалагч, төрийн албан хаагч ба 3 итгэмжит төлөөлөгч оролцсон тохиолдолд шийдвэр гаргах эрхтэй.

§27

Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай иргэдийн төлөөлөгч шүүгчийн тоог тухайн шүүхийн Ерөнхий шүүгч жилд дээд тал нь 12 удаа шүүх хуралд оролцохоор тооцож тогтооно.

§28

5 жил тутамд хот, дүүрэггүй хотууд нь иргэдийн төлөөлөгчид нэр дэвшигчийн жагсаалтыг гаргана. Хороо нь дүүрэг, дүүрэггүй хот тус бүр жагсаалтад оруулах иргэдийн тоог тогтоох бөгөөд §27-д заасан шаардлагатай шүүгчийн тоог 2 дахин дахин нэмэгдүүлнэ. Жагсаалтад нэр оруулах тухай шийдвэрийг тухайн аймаг, хотын төлөөллийн байгууллагын хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын, нийт гишүүдийн тэн хагсаас багагүй нь дэмжсэн байна. Төлөөллийн байгууллагын дотоод шийдвэр гаргах журамд энэ заалт нөлөөлөхгүй. Жагсаалтад нэр дэвшигчийн нэр, төрсөн газар, он сар өдөр, эрхэлж буй ажил мэргэжлийг дурдсан байна. Бэлтгэсэн жагсаалтыг харьяалах Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчид хүргүүлнэ.

§29

(1)Хороо нь шаардлагатай иргэдийн төлөөлөгч шүүгчийн тоог саналын жагсаалтаас гуравны хоёрын олонхын саналаар сонгоно.

(2)Иргэдийн төлөөлөгч шүүгч нь шинэ иргэдийн төлөөлөгч шүүгч томилогдох хүртэл үүргээ гүйцэтгэнэ.

§30

(1)Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тэргүүлэгчид тухайн жил эхлэхээс өмнө шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч шүүгчийг дуудах дарааллыг тогтооно.

(2)Урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл үүссэн үед шүүх хуралд оролцох иргэдийн төлөөлөгч шүүгчийг дуудах зорилгоор шүүхийн байртай ойр оршин суудаг иргэдийн төлөөлөгч шүүгчийн нөөц жагсаалтыг гаргаж болно.

§31

(хүчингүй болсонд тооцсон)

§32

Иргэдийн төлөөлөгч болон §26-д заасан хорооны гишүүн нь Шүүхийн цалин хөлс, нөхөн олговрын тухай хуульд заасан хэмжээгээр урамшуулал авна.

§33

(1)Шүүх хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр заасан цагт ирээгүй эсхүл бусад хэлбэрээр үүргээсээ зайлсхийсэн иргэдийн төлөөлөгч шүүгчид торгууль оногдуулж болно. Үүний зэрэгцээ түүний үйлдлээс үүдэн гарсан зардлыг нөхөн төлүүлж болно.

(2)Шийдвэрийг шүүх хуралдаан даргалагч гаргана. Хожим гаргасан тайлбар үндэслэл бүхий бол даргалагч торгууль ногдуулах шийдвэрийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцалж болно.

§34

Муж улсын хууль тогтоомжид захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч шүүгч оролцохоор заасан бол §§19-33-ыг хэрэглэнэ.

Дөрөвдүгээр хэсэг. НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

§35

(1)Холбооны Засгийн газар Холбооны захиргааны хэргийн шүүхэд холбооны ашиг сонирхлыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, Холбооны дотоод хэрэг, барилга, орон нутгийн хөгжлийн яамны дэргэд ажиллуулна. Холбооны захиргааны хэргийн шүүх дэх холбооны ашиг сонирхлын төлөөлөгч нь Холбооны захиргааны хэргийн шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд оролцоно. Энэ нь цэргийн хэрэг хянан шийдвэрлэдэг сенатад хамаарахгүй. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөгч Холбооны Засгийн газраас өгсөн чиглэлийг дагаж мөрдөнө.

(2)Холбооны захиргааны хэргийн шүүх нь холбооны ашиг сонирхлыг төлөөлөгчид мэдэгдэл хийх боломжийг олгоно.

§36

(1)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд муж улсын засгийн газраас баталсан журмын дагуу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж болно. Энэ тохиолдолд муж улс болон муж улсын захиргааны байгууллагыг ерөнхийд нь эсхүл тодорхой тохиолдолд төлөөлнө.

(2)§35.2-ыг хэрэглэнэ.

§37

(1)Холбооны захиргааны хэргийн шүүх дэх Холбооны ашиг сонирхлыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч болон түүний дээд албан тушаалтан нь шүүгчид тавих шаардлагыг хангасан байна.

(2)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүх дэх нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгч Германы Шүүгчийн тухай хуульд заасан шүүгчид тавих шаардлагыг хангасан байна. Энэ хуулийн §174-т заасанд нөлөөлөхгүй.

Тавдугаар хэсэг. ШҮҮХИЙН ЗАХИРГАА

§38

(1)Шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгч, төрийн албан хаагч, бусад шүүхийн ажилчдад албан үүргийн хяналт тавина.

(2)Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд албан үүргийн хяналт тавих дээд байгууллага нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч байна.

§39

Шүүхэд өөрийн шүүн таслах үндсэн үйл ажиллагаанаас бусад захиргааны ажил даалгахыг хориглоно.

Зургаадугаар хэсэг. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БОЛОН ХАРЬАЛАЛ

§40

(1)Захиргааны хэргийн шүүх нь Үндсэн хуулийн шүүхийн бус, мөн өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн бүх маргааныг хянан шийдвэрлэнэ. Муж улсын хууль тогтоомжоор зохицуулах нийтийн эрх зүйн маргааныг муж улсын хуулиар өөр шүүхэд шилжүүлж болно.

(2)Нийтийн ашиг сонирхлын төлөө иргэний эд хөрөнгийг хураасан, нөхөн төлбөр гаргуулах, захиргааны гэрээнд үндэслээгүй ч нийтийн эрх, ашиг зөрчигдсөнөөс үүссэн хохирлыг гаргуулах зэргээс үүдэлтэй нэхэмжлэлийг ердийн шүүх хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн §14.1-ийн 2 дахь өгүүлбэрт заасан нөхөн төлбөр болон үнийн дүнтэй холбоотой маргаанд хамаарахгүй. Төрийн албаны хуулийн тусгай зохицуулалт болон хууль бус захиргааны актыг хүчингүй болгосны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхтэй холбоотой зохицуулалтууд нь нэгэн адил үйлчилнэ.

§41 (хүчингүй болсонд тооцсон)

§42

(1)Захиргааны актыг хүчингүй болгуулах, татгалзсан эсвэл орхигдуулсан захиргааны актыг гаргах үүрэг хүлээлгэх нэхэмжлэл гаргаж болно.

(2)Хуульд өөрөөр заагаагүй бол нэхэмжлэгч нь захиргааны акт, татгалзал

болон эс үйлдэхүйн улмаас эрх нь зөрчигдсөн гэж үзвэл нэхэмжлэл гаргаж болно.

§43

(1) Эрх зүйн харилцаа байгаа болон байхгүйг тогтоолгох, эсхүл захиргааны акт илт хууль бус болохыг тогтоолгох нь яаралтай бөгөөд нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхолд нийцэж байвал тогтоох нэхэмжлэл гаргаж болно.

(2) Нэхэмжлэгч өөрийн эрхийг захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл, эсхүл даалгах нэхэмжлэлээр хамгаалж байсан, эсхүл хамгаалах боломжтой байсан тохиолдолд тогтоолгох нэхэмжлэл гаргахгүй. Захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэл үүнд хамаарахгүй.

§44

Нэхэмжлэгч нь хариуцагчид холбогдуулан харилцан хамаарал бүхий, нэг шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалтай хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагыг хамтад нь гаргаж болно.

§44a

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гаргах гомдлыг зөвхөн тухайн хэргийн үндсэн шийдвэрийн эсрэг хамт гаргаж болно. Уг гомдол нь хэрэгт оролцоогүй этгээдэд чиглэсэн эсвэл албадан биелүүлэгдэх боломжтой тохиолдолд энэ хязгаарлалт хамаарахгүй.

§45

Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бүх маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

§46

Дараах гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэнэ.

1. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол,
2. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн бусад шийдвэрт гаргасан гомдол.
3. (хүчингүй болсонд тооцсон)

§47

(1) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх харьяаллын хүрээнд гаргасан гомдлыг үндэслэн дараахыг хууль ёсны эсэхийг шийдвэрлэнэ.

1. Барилгын тухай хуулийн дагуу баталсан журам болон Барилгын тухай

- хуулийн §246.2-т үндэслэн гаргасан эрх зүйн акт
2. Муж улсын хуульд заасан бол муж улсын хуулиас доогуур эрэмбэлэгдсэн бусад эрх зүйн акт

(2)Захиргааны хэм хэмжээний акт, түүний хэрэглээний улмаас эрх нь зөрчигдсөн эсхүл ирээдүйд эрх нь зөрчигдөж болзошгүй гэж үзэж буй аливаа хувь хүн, хуулийн этгээд, түүнчлэн аливаа төрийн байгууллага эрх зүйн актыг нийтэлснээс хойш нэг жилийн дотор гомдол гаргаж болно. Гомдлыг хэм хэмжээний акт гаргасан нийтийн эрх зүйн байгууллага, санд гаргана. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь тухайн эрх зүйн актын үйлчлэлд хамаарах муж улс, бусад нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд заасан хугацаанд тайлбар өгөх боломжийг олгож болно. §65.1, 65.4 болон §66-г хэрэглэнэ.

(2а) (хүчингүй болсонд тооцсон)

(3)Хуульд тухайн эрх зүйн актыг муж улсын Үндсэн хуулийн шүүх хянахаар заасан бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь тухайн эрх зүйн акт муж улсын хуульд нийцэж буй эсэхийг хянахгүй.

(4)Эрх зүйн актыг хүчин төгөлдөр эсэхийг хянан шийдвэрлэх ажиллагаа Үндсэн хуулийн шүүхээр хянагдаж байгаа бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх тухайн хэрэг Үндсэн хуулийн шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно.

(5)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь магадлал гаргах бөгөөд аман хэлэлцүүлэг хийх шаардлагагүй гэж үзвэл захирамж гаргана. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх эрх зүйн актыг хүчин төгөлдөр бус гэж үзвэл түүнийг хүчингүй болсонд тооцно. Энэ тохиолдолд шийдвэрийг заавал биелүүлэх бөгөөд хариуцагч нь эрх зүйн актыг нийтэд мэдээлэхтэй адил журмаар шийдвэрийг хэвлэн нийтлэх үүрэгтэй. Шийдвэрийн хүчин төгөлдөр байдлын талаар §183-ыг хэрэглэнэ.

(6) Ноцтой хохирол үүсэхээс урьдчилан сэргийлэх эсхүл бусад чухал үндэслэл бүхий тохиолдолд нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл шүүх хүсэлтийн дагуу түдгэлзүүлэх захирамж гаргаж болно.

§48

(1)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх дараах хэрэг маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэнэ:

1. Цөмийн энергийн тухай хуулийн §7 болон §9а.3-т заасан барилга, байгууламжийг барих, ашиглах, бусад байдлаар эзэмших, өөрчлөх, ашиглалтаас гаргах, аюулгүй хаах, буулгах,

- 1а. Цөмийн энергийн тухай хуулийн §7е болон §7f-г үндэслэсэн нөхөн төлбөрийн хэмжээ болон түүнийг авах эрхтэй эсэх,
2. Цөмийн энергийн тухай хуулийн §7 (Цөмийн энергийн тухай хуулийн §9)-д заасан төрлийн байгууламжаас гадуур ашигласан цөмийн түлшийг боловсруулах, нөхөн сэргээх эсхүл Цөмийн энергийн тухай хуулийн §9.1-ийн 2 дахь өгүүлбэрт заасны дагуу цөмийн түлшийг улсын хамгаалалтаас гадуур хадгалах (Цөмийн энергийн тухай хуулийн §6) гэж зааснаас өөр байдлаар хадгалах, улсын мэдлийн хадгалалтаас гаргах,
3. 300 мегаваттаас дээш хүчин чадалтай хатуу, шингэн ба хийн түлш ашигладаг цахилгаан станц барих, ашиглах, өөрчлөх,
3а. Нийт 50 метрээс дээш өндөртэй далайн эрэг дээрх салхины эрчим хүчний байгууламж, мөн нутаг дэвсгэрийн тэнгис дэх салхины эрчим хүчний байгууламжийг барих, ашиглах, өөрчлөх,
3б. Дулаан, эрчим хүчний нэгдсэн хуульд заасны дагуу 50 мегаватт ба түүнээс дээш дулааны хүчин чадалтай дулаан, цахилгааны станц барих, ашиглах, өөрчлөх,
4. §50.1-ийн 6-д заасны дагуу Холбооны захиргааны шүүхийн харьяалалд хамаарахгүй бол Эрчим хүчний салбарын тухай хуулийн §43-ын дагуу төлөвлөгөө батлах журмыг хэрэгжүүлэх,
- 4а. §50.1-ийн 6-д заасны дагуу Холбооны захиргааны шүүхийн харьяалалд хамаарахгүй бол Далайн салхины эрчим хүчний тухай хуулийн §66.1-д заасны дагуу барилга байгууламж барих, ашиглах, өөрчлөх зөвшөөрлийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам,
5. Хог хаягдлын менежментийн тухай хуулийн §48-д заасны дагуу жилд 100,000 тонноос дээш хог хаягдлыг шатаах эсхүл дулаанаар задлах хүчин чадалтай (бодит хүчин чадал) суурин байгууламж болон хог хаягдлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр хугацаанд эсхүл байнгын хадгалах суурин байгууламжийг барих, ашиглах, журам,
6. Барилгын хамгаалалтын аюулгүйн талбайд нисэх онгоцны буудал барьж байгуулах, өргөтгөх, өөрчлөх эсхүл ашиглах,
7. Трамвай, соронзон төмөр зам, нийтийн эзэмшлийн төмөр зам барьж байгуулах эсхүл өөрчлөх мөн эргэлт хийх, чингэлэг байршуулах талбай барих, өөрчлөхөд шаардагдах зөвшөөрөл олгох журмыг батлах ажиллагаа,
8. Холбооны болон муж улсын засмал зам барьж байгуулах эсхүл өөрчлөх төлөвлөгөө батлах ажиллагаа,
9. Холбооны усан зам шинээр барьж байгуулах эсхүл өргөтгөх төлөвлөгөө батлах ажиллагаа,

10. Нийтийн эзэмшлийн далайн эргийн бүсийн хамгаалалт эсхүл үер, уснаас хамгаалах төлөвлөгөө батлах ажиллагаа,
11. Усны тухай хуулийн §68.1-д заасны дагуу эсхүл 1.350 тонноос дээш даацтай усан тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой боомтуудыг барих, өргөтгөх, өөрчлөхийг муж улсын хуулийн §9-д харшлахгүйгээр зөвшөөрөл олгох төлөвлөгөө батлах ажиллагаа,
12. Усны тухай хуулийн §68.1-д заасны дагуу 100 мегаваттаас дээш бодит хүчин чадалтай усан цахилгаан станцыг барьж байгуулах, өргөтгөх эсхүл өөрчлөх төлөвлөгөө батлах ажиллагаа,
- 12a. Нүүрсээр эрчим хүч үйлдвэрлэхийг зогсоох тухай хуулийн дагуу хүрэн нүүрсний ил уурхайнуудыг хаахтай холбогдуулан ус ашиглах,
- 12b. Нүүрсээр эрчим хүч үйлдвэрлэхийг зогсоох тухай хуулийн дагуу хүрэн нүүрсний ил уурхайнуудыг хаахтай холбогдуулан гол, ус, нуур, далайн эргийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө батлах ажиллагаа,
13. Холбооны Уул, уурхайн тухай хуульд заасны дагуу төлөвлөгөө батлах ажиллагаа,
14. Дараах төлөвлөгөөнд зөвшөөрөл олгох
 - a) Ашиглалтын ерөнхий төлөвлөгөө,
 - b) Ашиглалтын нарийвчилсан төлөвлөгөө,
 - c) Тусгайлсан төлөвлөгөө ба
 - d) Хаалт ба нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
 түүнчлэн - Нүүрсээр эрчим хүч үйлдвэрлэхийг зогсоох тухай хуулийн дагуу хүрэн нүүрсний ил уурхайнуудыг хаахтай холбогдуулан - газар чөлөөлөх шийдвэр ба
15. Хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн §65.1 болон 1-р хавсралтын 19.7-д заасан уурын эсхүл халуун усны шугам хоолой барьж байгуулах, ашиглах эсхүл өөрчлөх төлөвлөгөө батлах ажиллагаа.

1 дэх өгүүлбэр төлөвлөгөөг орлосон зөвшөөрөлтэй холбогдолтой маргаан тухайн төсөлд шаардлагатай - түүнчлэн төсөлтэй байршил, үйл ажиллагааны хувьд хамааралтай туслах байгууламжийн - зөвшөөрөлд мөн үйлчилнэ. 1 дэх өгүүлбэрт заасан тохиолдлуудтай холбон гаргасан эзэмших эрхийг түр хугацаанд шилжүүлэх шийдвэртэй холбоотой маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэж болох талаар муж улсууд хуулиар тогтоож болно.

(2)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь Холбоо, эвслийн тухай хуулийн §3.2-ын 1-д заасны дагуу муж улсын аль нэг дээд байгууллагаас гаргасан эвлэлдэн нэгдэхийг хориглосон шийдвэр мөн Холбоо, эвслийн

тухай хуулийн §8.2-ын 1 дэх өгүүлбэрт заасны дагуу гаргасан захирамжтай холбоотой нэхэмжлэлийг анхан шатны журмаар шийдвэрлэнэ.

(3) Шүүхийн тухай хуулийн хуулийн §21е-ийн 4-т зааснаас өөрөөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тэргүүлэгчид 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрийн 3-15-д заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан шүүх бүрэлдэхүүнийг Ажил хуваарилалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвээр хариуцуулж үлдээх шийдвэр гаргавал зохино.

Зүүлт тайлбар

§48.1-ийн 1 дэх өгүүлбэрийн Nr. 1a: 2018.07.10-ны хуулийн §2-т нэмэлт өөрчлөлт оруулсан, Холбооны хуулийн мэдээ I, 1122-тал 2018.07.11-нд нийтэлсэн ба I 1124-р талд 2018.07.04-нд хүчин төгөлдөр болсон; энэхүү хууль болон нийтэлсэнтэй холбогдолттой Холбооны Үндсэн хуулийн шүүхийн 2020.09.29-ний шийдвэрийг үзнэ үү. (1 BvR 1550/19)

§49

Холбооны захиргааны хэргийн шүүх дараах тохиолдолд маргааныг хянан шийдвэрлэнэ:

1. §132-т заасны дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол,
2. §134, §135-д заасны дагуу Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдол,
3. Энэ хуулийн §99.2, §133.1, Шүүхийн тухай хуулийн §17а.4-ийн 4 дэх өгүүлбэрт заасны дагуу гаргасан гомдол.

§50

(1) Холбооны захиргааны хэргийн шүүх дараах маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар эцэслэн шийдвэрлэнэ:

1. Холбоо болон муж улс хоорондын, эсхүл муж улс хоорондын үндсэн хуулийн бус шинж чанартай нийтийн эрх зүйн маргаан,
2. Холбооны тухай хуулийн §3.2-ын 2-т заасны дагуу Холбооны Дотоод хэрэг, Барилгын яамны сайдын гаргасан хоригт холбогдуулж, эсхүл Холбооны тухай хуулийн §8.2-ын 1-д заасны дагуу гаргасан захирамжид гаргасан нэхэмжлэл,
3. Оршин суух тухай хуулийн §58а-д заасны дагуу гаргасан албадан гаргах захирамжийн эсрэг маргаан, түүний хэрэгжилт, түүнчлэн энэ үндэслэлээр хилээр нэвтрэх, оршин суухыг хориглохтой холбоотой маргаан,
4. Холбооны тагнуулын газрын үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл,

5. Парламентын гишүүний тухай хуулийн §12.3а, тус хуулийн 11-р бүлэг дэх журам, Холбооны сайд нарын тухай хуулийн §6b, Парламентын Төрийн нарийн бичгийн даргын эрх зүйн байдлын тухай хуулийн §7 (Холбооны сайдын тухай хуулийн §6b зүйлтэй хамтатган)-д заасны дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ ба гаргасан шийдвэрийг эсэргүүцсэн нэхэмжлэл,
6. Төлөвлөгөө батлах ба зөвшөөрөл олгох ажиллагаатай холбогдолтой, Төмөр замын ерөнхий хууль, Холбооны усан замын тухай хууль, Эрчим хүчний шугамын өргөтгөлийн тухай хууль, Холбооны цахилгаан дамжуулах сүлжээг өргөтгөх шаардлагын төлөвлөгөөний тухай хууль, Эрчим хүчний салбарын тухай хуулийн §43e.4, Далай дээрх салхины эрчим хүчний тухай хуулийн §76.1 эсхүл Соронзон төмөр замын төлөвлөлтийн тухай хуульд заасан бүх маргаан. Холбооны засмал замын тухай хуулийн §17e.1-д заасан ажиллагаатай холбогдолтой бүх маргаан. Ус төрөгч, дериватыг импортлох зорилгоор шилжүүлэн ачилтын терминал барьж байгуулахтай холбогдолтой бүх маргаан. Шингэрүүлсэн хийн дэд бүтцийн өргөтгөлийг эрчимжүүлэх тухай хуулиар харьяалуулсан ажиллагаа,
7. Эрчим хүчний аюулгүй байдлын тухай хуульд холбогдох журмын хүрээнд гарсан маргаан,

(2)§1.6-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад §48.3-ыг хэрэглэнэ.

(3)Холбооны захиргааны хэргийн шүүх маргааныг §1.1-д заасны дагуу үндсэн хуулийн шинжтэй гэж үзвэл, уг асуудлыг шийдвэрлүүлэхээр Холбооны Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлнэ.

§51

(1)Холбооны тухай хуулийн §5.2-т заасны дагуу салбар холбоог хориглохын оронд холбоог бүхэлд нь хориглохоор бол холбоог бүхэлд нь хориглосон шийдвэрт гаргасан нэхэмжлэлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг холбоонд тавьсан хоригийн эсрэг шийдвэр гарах хүртэл түр түдгэлзүүлнэ.

(2)Холбооны захиргааны хэргийн шүүхээс 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргасан тохиолдолд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхүүд заавал биелүүлнэ.

(3)Холбооны захиргааны хэргийн шүүх нь §50.1-ийн 2-т заасны дагуу холбооноос гаргасан нэхэмжлэлийн талаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд мэдэгдэнэ.

§52

Нутаг дэвсгэрийн харьяалалд дараах зүйл хамаарна:

1. Үл хөдлөх хөрөнгө эсхүл орон нутгийн эрх, эрх зүйн харилцаатай холбогдолтой маргааныг тухайн эд хөрөнгө байршиж буй газрын харьяалагдах захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэнэ.
2. Холбооны эрх бүхий байгууллага эсхүл Холбооны шууд харьяаллын нийтийн эрх зүйн этгээд (албан газар, сан)-гийн гаргасан захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн хувьд тухайн захиргааны байгууллагууд оршин байгаа дүүргийн холбогдох Захиргааны хэргийн анхан шатны шүүх 1 ба 4 дэх хэсгийн дагуу шийдвэрлэнэ. 1 дэх өгүүлбэр нь даалгах /үүрэг хүлээлгэх/ нэхэмжлэл гаргахад мөн адил үйлчилнэ. Цагаачлалын тухай хуулийн дагуу үүсгэсэн маргааныг тухайн гадаадын иргэн тус хуульд заасны дагуу оршин суувал зохих газрын холбогдох Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэнэ. Үүний дагуу нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоох боломжгүй бол 3 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлно. Гадаадын иргэний оршин суух гэж байгаа муж улс Орогнолын тухай хуулийн §83.3-ыг хэрэглэсэн тохиолдолд муж улсын захиргааны хэргийн шүүх Орогнолын тухай хуулийн дагуу харьяалан шийдвэрлэх эрхтэй. ХБНГУ-ын гадаад дахь дипломат болон консулын төлөөлөгчийн газрын харьяалалд хамаарах нутаг дэвсгэрт, тэр дундаа визний асуудлаар Холбооны Засгийн газрын эсрэг нэхэмжлэл гаргах тохиолдолд эдгээрийг Холбооны Засгийн газар байрладаг дүүргийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэнэ.
3. 1, 4 дэх хэсэгт заасны дагуу хүчингүй болгохоос бусад тохиолдолд тухайн захиргааны актыг гаргасан дүүргийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд харьяалагдана. Тухайн актыг хэд хэдэн дүүрэгт хамаарах эрх бүхий байгууллага эсхүл хэд хэд муж улс эсхүл нийт муж улсын хамтарсан эрх бүхий байгууллагаас гаргасан бол гомдол гаргагч өөрийн оршин суугаа газрын хамаарах дүүргийн захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана. Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүсэд тухайн эрх бүхий байгууллага байхгүй бол 5 дахь хэсэгт заасны дагуу харьяаллыг тогтооно. Муж улсаас их, дээд сургуульд суралцах эрхийг олгох, төрийн байгууллагаас гаргасан захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн асуудлыг тухайн төрийн байгууллага байршдаг дүүргийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэнэ. Энэ нь 1, 2 4 дэх өгүүлбэрт заасан даалгах нэхэмжлэлд мөн үйлчилнэ.
4. Одоо эсхүл өмнө нь ажиллаж байсан төрийн албан хаагч, шүүгч,

цэргийн жинхэнэ алба эсхүл дүйцүүлэн хаахтай холбоотой харилцаанаас үүдсэн бүх нэхэмжлэл, ийм эрх зүйн харилцаа үүссэн эсэхтэй холбогдсон маргааныг нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн ажил, үүргээ хэрэгжүүлж байгаа газрын дүүрэгт хамаарах Захиргааны хэргийн шүүх, байхгүй бол тэдгээрийн оршин суугаа газрын Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэнэ. Нэхэмжлэгч хариуцагч нь ажил, үүрэгтэй холбоотой оршин суух газар байхгүй эсхүл актыг анхлан гаргасан байгууллагын дүүрэгт оршин суудаггүй бол тус байгууллагын байршдаг дүүргийн шүүх шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн §131-д хамаарах этгээдийн эрх зүйн харилцааг зохицуулах тухай хуулийн §79-д заасны дагуу гаргасан нэхэмжлэлд 1, 2 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ.

5. Бусад тохиолдолд хариуцагчийн байрладаг, оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа дүүргийн эсхүл өмнө нь оршин сууж байсан дүүргийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд харьяалагдана.

§53

(1) Дараах тохиолдолд дээд шатны шүүх захиргааны шүүхийн харьяаллыг тодорхойлно:

1. шүүх хэрэг хянан шийдвэрлэх эрхээ хэрэгжүүлэхэд эрх зүйн болон бодитой саад учирсан бол,
2. шүүх хооронд тойргийн заагаас үүдэн тухайн эрх зүйн маргааныг аль шүүх харьяалан шийдвэрлэх нь тодорхойгүй бол,
3. шүүхийн харьяаллыг §52-т заасны дагуу тогтоох ба хэд хэдэн шүүхэд хамаарч байгаа бол,
4. хуулиар хэд хэдэн шүүхийн харьяалалд хамаарч байгаа бол,
5. хэд хэдэн шүүх харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй гэж мэдэгдсэн бол.

(2) §52-т заасны дагуу нутаг дэвсгэрийн харьяалал тогтоогдоогүй бол Холбооны захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх эрх бүхий шүүхийг тогтооно.

(3) Маргааны аль ч тал хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн дээд шатны шүүх эсхүл Холбооны захиргааны хэргийн шүүхэд давж заалдаж болно. Тус шүүх аман хэлэлцүүлэг хийлгүйгээр шийдвэр гаргаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Долоодугаар хэсэг. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРМУУД

§54

(1) Шүүхийн албан тушаалтныг татгалзан гаргахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §§41-49-ийг хэрэглэнэ.

(2) Өмнөх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон шүүгч эсхүл иргэдийн төлөөлөгч шүүгч хэрэгт оролцохоос татгалзана.

(3) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §42-т заасан шүүгч нэг талыг баримтлах эргэлзээтэй гэх үндэслэлд шүүгч болон иргэдийн төлөөлөгч шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдтэй хамааралтай байх үндэслэл хамаарна.

§55

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, дэг сахиулах, шүүхийн хэл, зөвлөлдөх санал хураахад Шүүхийн тухай хуулийн §169, §§171а-198-р зүйлийг хэрэглэнэ.

§55а

(1) Урьдчилсан мэдүүлэг, түүний хавсралт, талуудын бичгээр гаргасан өргөдөл, мэдүүлэг мөн гуравдагч этгээдийн бичгээр гаргавал зохих мэдээлэл, мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, орчуулга, мэдүүлэг, тайлбарыг 2-б дахь хэсэгт заасны дагуу цахим баримт хэлбэрээр шүүхэд гаргаж болно.

(2) Шүүх цахим баримтыг боловсруулах боломжтой байх ёстой. Холбооны Засгийн газар Бундесратын зөвшөөрлөөр 4 дэх хэсгийн 1, 4, 5-д заасны дагуу цахим шуудан эзэмшигчийн мэдээллийг цахимаар найдвартай дамжуулах, боловсруулах техникийн тогтолцооны журмыг гаргана.

(3) Цахим баримт бичиг нь хариуцаж буй этгээдийн цахим гарын үсгээр баталгаажсан байх эсхүл гарын үсгээ зурж баталгаат сувгаар ирүүлсэн байх ёстой. Урьдчилсан мэдүүлгийн хавсралтад 1 дэх өгүүлбэр үл хамаарна. Хэргийн оролцогч эсхүл гуравдагч этгээд бичгээр гаргавал зохих хүсэлт, тайлбарыг цахим хэлбэрээр гаргахаар бол гарын үсэг зурсан хүсэлт, тайлбарыг цахим баримтын хэлбэрт шилжүүлж итгэмжлэгдсэн төлөөлөгч, хууль ёсны төлөөлөгч эсхүл туслахаараа дамжуулан 1 дэх өгүүлбэрт заасны дагуу ирүүлж болно.

(4) Баталгаат дамжуулах сувгууд гэж:

1. илгээгч мэдээллийг илгэхдээ De-Mail тухай хуулийн §4.1-ийн 2 дахь

- өгүүлбэрт заасны дагуу бүртгэгдсэн ба тус хуулийн §5.5-д заасны дагуу бүртгэлийг баталгаажуулсан De-Mail цахим шуудангийн хүлээн авах болон илгээх үйлчилгээ,
2. Холбооны хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §31a, §31b-д заасны дагуу хуульчдын тусгай цахим шуудангийн дамжуулах суваг эсхүл хуулийн дагуу үүсгэсэн холбогдох цахим шуудан болон шүүхийн цахим дотоод цахим шуудан,
 3. таньж тогтоох ажиллагаанд үндэслэн тогтоосон нийтийн эрх зүйн эрх бүхий байгууллага, хуулийн этгээдийн цахим шуудан болон шүүхийн цахим шуудангийн хоорондын дамжуулах суваг,
 4. таньж тогтоох ажиллагаанд үндэслэн тогтоосон хувь хүн, хуулийн этгээдийн эсхүл бусад холбоо, эвслийн цахим шуудан болон шүүхийн цахим шуудангийн хоорондын дамжуулах суваг,
 5. цахим хандалтын тухай хуулийн §2.5-д заасны дагуу таньж тогтоох ажиллагаанд үндэслэн тогтоосон хэрэглэгчийн цахим шууданд бүртгүүлсэн данс болон шүүхийн цахим шуудангийн үйлчилгээ,
 6. Бундестратын зөвшөөрлөөр Холбооны Засгийн газрын хууль ёсны шийдвэрээр байгуулагдсан, үнэн зөв, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг баталгаажуулсан бусад улс даяар дамжуулах бусад сувгууд.

3-5-д заасан дамжуулах сувгийн талаар 2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрт заасан хуульд заасан журмаар зохицуулна.

(5)Цахим баримт бичгийг шүүхийн зориулалтын хүлээн авах тоног төхөөрөмжид хадгалмагц хүлээн авсанд тооцно. Хүлээн авсан цагийг баталгаажуулсан тухай хариуг илгээгчид автоматаар илгээнэ. Энэ тохиолдолд энэ хуулийн хэргийн бусад этгээдэд зориулан хуулбарыг хавсаргах тухай заалт үл хамаарна.

(6)Цахим баримт бичгийг шүүх хүлээн авах боломжгүй бол энэ тухай болон баримт бичгийг хүлээн аваагүйд тооцсон тухайгаа илгээгчид нэн даруй мэдэгдэнэ. Илгээгч нь шүүх хүлээн авах боломжтой хэлбэрээр цаг алдалгүй илгээсэн, агуулга нь анх ирүүлсэн баримт бичигтэй ижил болохыг нотолсон тохиолдолд уг баримт бичгийг өмнө нь шүүхэд ирүүлсэн цаг мөчид хүлээн авсанд тооцно.

(7)Шүүгч, шүүхийн захиргааны ажилтан гарын үсэг зурахаар журамд заасан бол хариуцаж буй этгээдүүд баримт бичгийн төгсгөлд нэрээ бичиж, шаардлага хангасан цахим гарын үсгээр баталгаажуулсан тохиолдолд цахим баримт бичиг гэж тооцно. §55b.6-ын 4 дэх өгүүлбэрт заасны дагуу гараар зурсан гарын үсэг бүхий баримт бичгийг цахим баримт бичигт шилжүүлэх журмыг хангасан гэж үзнэ.

§55b

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цахим хэлбэрээр хадгалж болно. Холбооны Засгийн газар болон муж улсын засгийн газар нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цахим хэлбэрээр хадгалах хугацааг хавтаст хэргийг нийтэд ил тод нээлттэй мэдээлэх онцгой нөхцөлийг захиргааны зохицуулалтын журмаар тогтооно. Журамд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цахим хэлбэрээр үүсгэх, хөтлөх, хадгалахад тавигдах зохион байгуулалт, техникийн шаардлагыг зааж өгнө. Муж улсын засгийн газрууд энэ эрх мэдлийг муж улсын захиргааны хэргийн харьяаллын дээд байгууллагад шилжүүлж болно. Цахим хавтаст хэргийн материалыг зөвхөн тодорхой шүүх эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглахаар хязгаарлаж болно. Энэ тохиолдолд цахим хэлбэрээр хадгалагдаж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу журмаар тогтоож болно. Холбооны Засгийн газар тухайн журмыг гаргахдаа Бундесратаас зөвшөөрөл авах шаардлагагүй.

(1a) 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цахим хэлбэрээр хадгална. Холбооны Засгийн газар болон муж улсын засгийн газар нь өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим хавтаст хэргийг үүсгэх, хөтлөх, хадгалахад тавигдах зохион байгуулалт, техникийн орчин үеийн шаардлагыг журмаар тогтооно. Холбооны засгийн газар болон муж улсын засгийн газар нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цаасан хэлбэрээр үүсгэсэн тохиолдолд цаасан хэлбэрээр үргэлжлүүлэн хадгалахыг журмаар тогтоож болно. Муж улсын засгийн газрууд 2, 3 дугаар өгүүлбэрт заасан эрх мэдлийг муж улсын захиргааны хэргийн харьяаллын дээд байгууллагад шилжүүлж болно. Холбооны Засгийн газрын тухайн журмыг гаргахдаа Бундесратаас зөвшөөрөл авах шаардлагагүй.

(1b) 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс өмнө цаасан хэлбэрээр үүсгэсэн хавтаст хэргийг тодорхой өдрөөс эсхүл үйл явдлаас эхлэн цахим хэлбэрээр хадгалах талаар Холбооны Засгийн газар болон муж улсын засгийн газар өөрийн эрх мэдлийн хүрээнд журмаар тогтоож болно. Цаашид үргэлжлүүлэн цахим хэлбэрээр хадгалахыг зөвхөн тодорхой шүүх эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хязгаарлаж болно. Энэ тохиолдолд цахим хэлбэрээр хадгалагдаж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг нийтэд ил тод нээлттэй мэдээлэх онцгой нөхцөлийг захиргааны зохицуулалтын дагуу журмаар тогтоож болно. Холбооны Засгийн газар тухайн журмыг гаргахдаа Бундесратаас зөвшөөрөл авах шаардлагагүй. Энэхүү эрх мэдлийг Холбооны эрх бүхий дээд байгууллага эсхүл муж улсын захиргааны хэргийн харьяаллын дээд байгууллагад шилжүүлж болно.

(2)Хэрэв хавтаст хэргийг цаасан хэлбэрээр хөтөлж байгаа бол цахим баримт бичгийг хэвлэж хавсаргана. Хавсаргах баримт бичгийг хэвлэх боломжгүй эсхүл хэт их бол цахим хэлбэрээр нь үлдээж болно. Энэ тохиолдолд файлыг удаан хугацаагаар хадгалах бөгөөд байршлыг нь хавтаст хэрэгт тэмдэглэнэ.

(3)Хэрэв цахим баримт бичгийг баталгаат сувгаар дамжуулсан бол хавтаст хэрэгт энэ тухай тэмдэглэнэ.

(4)Хэрэв цахим баримт бичиг нь цахим гарын үсгээр баталгаажсан ч баталгаат сувгаар дамжуулагдаагүй тохиолдолд хэвлээд дараах тэмдэглэлийг үйлдэнэ,

1. баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг шалгасан үр дүн,
2. цахим гарын үсгийн эзэн хэн болохыг шалгалтаар тогтоосон тухай,
3. цахим гарын үсгийг хэдэн цагт оруулсан тухай шалгалтын үр дүн.

(5)2 дахь хэсэгт заасны дагуу дамжуулсан цахим баримт бичгийг 6 сарын дараа устгаж болно.

(6)Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цахим хэлбэрт хадгалж байгаа тохиолдолд цаасан баримт бичиг болон бусад материалыг техникийн боломжийн хүрээнд эх баримтыг орлуулахуйц байдлаар цахим баримт бичгийн хэлбэрт оруулна. Цахим баримт бичиг нь тухайн баримт бичиг, бусад материалтай дүрс, агуулгын хувьд нийцсэн байна. Цахим баримт бичгийг дамжуулах үйл явц болон дүрс, агуулгын нийцлийг баримтжуулсан нотлох баримтыг хавсаргана. Хариуцсан этгээдийн гарын үсэгтэй шүүхийн баримт бичгийг дамжуулах тохиолдолд дамжуулсан нотлох баримт нь шүүхийн захиргааны ажилтны баталгаат цахим гарын үсэгтэй байх ёстой. Буцааж өгөх үүрэггүй бол цаасан баримт бичиг болон бусад материалыг дамжуулснаас хойш 6 сарын дараа устгаж болно.

(7)Холбооны Засгийн газар нь Бундесратын зөвшөөрлөөр цахим баримт бичгийг дамжуулахад дагаж мөрдөх стандартыг журмаар тогтоож болно.

§55c Маягтууд; Журам батлан гаргах

Холбооны Хууль зүйн болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах яам нь Бундесратын зөвшөөрлөөр тогтоосон хууль тогтоомжийн дагуу цахим маягт нэвтрүүлж болно. Хууль тогтоомжид заасан цахим маягтад агуулагдсан мэдээллийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь машинд уншигдахуйц хэлбэрээр дамжуулахыг тогтоож болно. Маягтыг тухайн эрх зүйн актад заасан цахим харилцааны платформоор ашиглах боломжтой байхаар бэлтгэнэ. Эрх зүйн актаар хэрэглэгчийг таних ажиллагааг §55a.3-д зааснаас өөрөөр, Иргэний үнэмлэхийн тухай хууль (Personalausweisgesetz)-ийн §18, eID картын тухай хууль (eID-Karte-Gesetz)-ийн §12, эсхүл Гадаадын иргэний эрх зүйн байдлын

тухай хууль (Aufenthaltsgesetz)-ийн §78.5-д заасны дагуу цахим үнэмлэхийг ашиглан явуулж болохыг тогтоож болно.

§55d Хуульчид, байгууллагууд болон төлөөлөх эрх бүхий этгээдийн цахим хэлбэрээр ашиглах үүрэг

Бичгээр гаргах мэдэгдлийн төсөл болон түүний хавсралтууд, мөн бичгээр гаргах шаардлагатай хүсэлт, тайлбар, мэдэгдлийг хэрэв хуульч, төрийн байгууллага, эсхүл нийтийн эрх зүйн хуулийн этгээд (үүнд тэдний нийтийн үүргийг биелүүлэх зорилгоор байгуулсан нэгдэл, холбоод орно) гаргаж байгаа бол тэдгээрийг цахим баримт (цахим баримт бичиг) хэлбэрээр илгээх ёстой. Энэ хуулийн § 55a.4-ийн 1, 2-т заасан найдвартай цахим суваг ашиглах боломж төлөөлөх эрх бүхий этгээдэд байгаа бол мөн адил хамаарна. Хэрэв техникийн шалтгааны улмаас цахим хэлбэрээр илгээх боломж түр хугацаанд байхгүй бол бичгээр илгээж болно. Гэхдээ бичгээр илгээснээс хойш шалтгааны нотлох ёстой бөгөөд шаардсан тохиолдолд тухайн баримтыг хожим цахим хэлбэрээр дахин ирүүлэх үүрэгтэй.

§56

(1)Хугацаа тогтоосон захирамж, шийдвэр, түүнчлэн албан ёсны хугацаа тогтоосон мэдэгдэх хуудсыг зөвхөн мэдэгдсэний дараа албан ёсоор хүргүүлнэ.

(2)Хүргүүлэх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (Zivilprozessordnung) дагуу шүүх албан ёсоор гүйцэтгэнэ.

(3)ХБНГУ-д амьдардаггүй хүний хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилно.

§56a

(1)Хэрэв ижил мэдэгдлийг тавь ба түүнээс дээш этгээдэд хүргэх шаардлагатай бол шүүх олон нийтэд зарлан мэдэгдэх замаар дараагийн ажиллагааг захирамж гарган шийдвэрлэж болно. Захирамжид аль өдөр тутмын сонинд мэдэгдлийг нийтлэхийг заавал тодорхойлох бөгөөд энд тухайн шийдвэрийн нөлөөлөл бүхий газар нутагт түгээгддэг өдөр тутмын сониныг сонгох ёстой. Захирамжийг холбогдох этгээдүүдэд хүргүүлнэ. Холбогдох этгээдүүдэд мэдэгдлийг цаашид ямар хэрэгслээр зарлах, мөн бичиг баримтыг хэдийд хүргүүлсэнд тооцох тухай мэдээлэл өгнө. Захирамжид гомдол гаргах боломжгүй. Шүүх аливаа үед уг захирамжийг хэдийд ч хүчингүй болгож болно. Харин эхний өгүүлбэрт заасан нөхцөл хангагдаагүй, эсхүл цаашид хангагдахгүй болсон бол заавал хүчингүй болгоно.

(2)Олон нийтэд зарлан мэдэгдэх ажиллагааг шүүхийн самбарт байрлуулах, шүүхийн олон нийтэд нээлттэй цахим мэдээллийн системд байрлуулах, мөн Холбооны албан ёсны сонин болон 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт заасан

захирамжийг өдөр тутмын сонинд нийтлэх замаар явагдана. Мөн шүүхийн зар мэдээний зориулалтаар тогтоосон мэдээлэл, харилцаа холбооны системд нийтэлнэ. Шийдвэрийг олон нийтэд нийтлэх ба түүнд холбогдох давж заалдах журмын мэдээллийг нийтэлнэ. Нийтлэх ёстой бичиг баримтыг нийтлэхийн оронд тухайн баримтыг хаанаас үзэж болох талаар заасан мэдэгдлийг нийтэлж болно. Харин хугацаа болон мэдэгдэх хуудсыг бүхэлд нь бүрэн эхээр нь олон нийтэд зарлах ёстой.

(3) Холбооны албан ёсны сонинд нийтэлснээс хойш хоёр долоо хоног өнгөрсний дараа баримт бичгийг хүргүүлсэнд тооцох бөгөөд үүнийг нийтлэл бүрд заавал тусгана. Шийдвэрийг олон нийтэд зарласны дараа холбогдох этгээд бичгээр хүсэлт гарган хуулбарыг авах боломжтой бөгөөд үүнийг мөн нийтлэлд заавал тусгана.

§57

(1) Хуульд өөрөөр заагаагүй бол шийдвэрийг гардуулснаар эсхүл гардуулах шаардлагагүй бол шийдвэрийг нийтэлснээр эсхүл уншиж танилцуулснаар хугацаа тоолж эхэлнэ.

(2) Хугацаа тоолоход Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн §222, §224.2, §224.3, §225 болон §226-д заасан зохицуулалт үйлчилнэ.

§58

(1) Давж заалдах гомдол гаргах эцсийн хугацааг зөвхөн холбогдох тал давж заалдах гомдол гаргах тухайгаа захиргааны байгууллага, шүүхэд бичгээр, эсхүл цахимаар газар, дуусах хугацааг мэдэгдсэнээр тоолж эхэлнэ.

(2) Мэдэгдлийг хүргүүлээгүй эсхүл алдаатай бол давж заалдах гомдлыг шийдвэрийг гардуулсан, нийтэлсэн болон зарласан өдрөөс хойш 1 жилийн дотор гаргаж болно. Харин нэг жилийн хугацаа дуусахаас өмнө давагдашгүй хүчин зүйлийн улмаас гомдол гаргах боломжгүйд хүрсэн, бичгээр эсхүл цахимаар гомдол гаргах боломжгүй гэж мэдэгдсэн тохиолдолд энэ нь хамаарахгүй. Давагдашгүй хүчин зүйл бий болсон тохиолдолд §60.2-ыг хэрэглэнэ.

§59 (хүчингүй болсон)

§60

(1) Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуульд заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтэд үндэслэн өмнөх эрх зүйн байдлыг сэргээнэ.

(2) Хугацааг сэргээснээс хойш хоёр долоо хоногийн дотор өргөдөл гаргах бөгөөд, хэрэв давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авахаас татгалзсан, эсхүл гомдолд хариу өгөх хугацааг хэтрүүлсэн бол нэг сарын дотор

гаргана. Өргөдөл гаргахдаа эсхүл өргөдлийг хянан шийдвэрлэх ажиллагааны үед өргөдлийн үндэслэлийг баримтаар нотолсон байна. Өргөдөл гаргах хугацаанд захиргааны эс үйлдэхүйг нөхөн гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд өргөдөл шаардалгүйгээр эрх зүйн байдал сэргээхийг зөвшөөрч болно.

(3) Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хүсэлт гаргах боломжгүй байснаас бусад тохиолдолд хугацаа хэтэрснээс хойш нэг жил өнгөрмөгц хүсэлтийг хүлээн авахаас татгалзана.

(4) Эрх зүйн байдлыг сэргээх хүсэлтийг тухайн ажиллагааг хийх эрх бүхий шүүх шийдвэрлэнэ.

(5) Сэргээсэн шийдвэр нь эцсийнх байна.

§61

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах этгээд оролцоно

1. хувь хүн ба хуулийн этгээд,
2. хуулиар эрх нь олгогдсон бол холбоо,
3. муж улсын хууль тогтоомжид заасан бол эрх бүхий байгууллага.

§62

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах этгээд оролцох эрхтэй

1. Иргэний хуулийн дагуу эрх зүйн чадамжтай этгээд,
2. Иргэний болон нийтийн эрх зүйн зохицуулалтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн чадамжтай гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд иргэний хуулиар эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд,

(2) Иргэний хуулийн §1825 дугаар зүйлд заасан асран хамгаалагчийн зөвшөөрөл тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тохиолдолд асран хамгаалалтад байгаа этгээд нь зөвхөн Иргэний хуульд заасан журмын дагуу асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр, эсхүл эрх зүйн чадамжтай гэж хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болно.

(3) Холбоо, төрийн байгууллагыг хууль ёсны төлөөлөгч, төлөөлөн удирдах зөвлөл төлөөлнө.

(4) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §§53-58-ыг хэрэглэнэ.

§63

Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид

1. нэхэмжлэгч,
2. хариуцагч,
3. гуравдагч этгээд (§65),

4. Холбооны Захиргааны хэргийн шүүхэд Холбооны ашиг сонирхлыг төлөөлөх этгээд эсхүл оролцох эрхтэй тохиолдолд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөгч.

§64

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §59-63-т нэгтгэсэн хэрэг хянан шийдвэрлэх тухай зохицуулалтыг хэрэглэнэ.

§65

(1) Хэргийг эцэслэн шийдвэрлээгүй, мөн дээд шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа тохиолдлуудад тухайн шийдвэрээр холбогдох этгээдүүдийг шүүх өөрийн санаачилгаар, эсхүл шүүхэд хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдийн хүсэлтийн дагуу албан ёсоор дуудан ирүүлж болно.

(2) Маргаан бүхий эрх зүйн харилцаанд гуравдагч этгээдүүд оролцсон бөгөөд тэдгээрт шийдвэрийг нэгэн адил хүлээлгэх шаардлагатай бол мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж болно.

(3) 2 дахь хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавь болон түүнээс дээш тооны этгээдийг дуудан ирүүлэх шаардлагатай бол зөвхөн тодорхой хугацаанд хүсэлт гаргасан хүмүүсийг оролцуулахаар шүүх захирамж гаргаж болно. Захирамжид гомдол гаргахгүй. Захирамжийг Холбооны Улсын албан ёсны сэтгүүлд нийтэлнэ. Мөн шүүхийн шийдвэр нөлөөлөл үзүүлэх магадлалтай газар нутгийн өдөр тутмын сонинд нийтлүүлнэ. Түүнчлэн шүүхээс албан ёсны мэдээлэл нийтлэхэд ашигладаг мэдээлэл, харилцаа холбооны системд нийтэлж болно. Эцсийн хугацаа Холбооны Улсын сонинд нийтлэгдсэнээс хойш дор хаяж гурван сар байна. Өдөр тутмын сонинд нийтлэхдээ хугацаа дуусах өдрийг тодорхой зааж өгнө. Хугацааг хэтрүүлсэн тохиолдолд эрх зүйн байдлыг сэргээхэд §60-ыг хэрэглэнэ. Шийдвэр тодорхой этгээдүүдэд илэрхий нөлөөлөх тохиолдолд хүсэлт гаргасан эсэхээс үл харгалзан шүүхээс дуудан ирүүлнэ.

(4) Мэдэгдэх захирамжийг хамаарал бүхий бүх этгээдэд хүргүүлнэ. Ингэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал, дуудан ирүүлж буй үндэслэлийг тусгана. Мэдэгдэх захирамжид гомдол гаргахгүй.

§66

Оролцогч талын хүсэлтийн хүрээнээс хэтрүүлэлгүйгээр гуравдагч этгээд бие даан нэхэмжлэл гаргах, өмгөөлүүлэх эрхүүдийг бие даан хэрэгжүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх эрхийг эдэлнэ. Шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудагдсан тохиолдолд нотолгоог үгүйсгэсэн хүсэлт гаргах боломжтой.

§67

(1) Оролцогч талууд нь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцож болно.

(2) Оролцогч талууд нь шүүгчээр ажиллах шаардлагыг хангасан хуульчийг эсхүл Европын Холбооны гишүүн улс, Европын Эдийн Засгийн Бүсийн гэрээний бусад улс, болон Швейцарь Улсын төрийн өмчийн болон магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд хуулийн чиглэлээр багшилдаг багшийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг хүсэж болно. Үүний зэрэгцээ, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр зөвхөн дараах этгээдүүд ажиллах эрхтэй:

1. Оролцогч талуудын ажилтнууд, эсхүл хамаарал бүхий компанийн ажилтан (Компанийн тухай хуулийн (гер. Aktiengesetz) §15); эрх бүхий байгууллага болон нийтийн эрх зүйн этгээдүүд, мөн тэдгээрийн нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан нэгдлүүд; түүнчлэн хуульд заасан бусад эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, түүний дотор тэдгээрийн нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан нэгдлүүдийн ажилтан;
2. Гэр бүлийн насанд хүрсэн гишүүд (Татварын ерөнхий хуулийн §15, Хамтран амьдрагчийн тухай хуулийн §11), шүүгчээр ажиллах шаардлагыг хангасан этгээдүүд, мөн төлөөлөл нь төлбөртэй үйл ажиллагаатай холбоогүй бол хамтран оролцогч;
3. Татварын зөвлөх, татварын төлөөлөгч, аудитор, тангараг өргөсөн нягтлан бодогч, Татварын зөвлөгөө өгөх тухай хуулийн §3а, §3с-д заасан бүрэн эрхийнх нь хүрээнд Татварын зөвлөгөө өгөх тухай хуулийн §3а-д заасан хүмүүс, холбоод, түүнчлэн Татварын зөвлөгөө өгөх тухай хуулийн §3d болон 3е-д заасан татварын асуудлаар өөрийн эрх мэдлийн хүрээнд хязгаарлагдмал мэргэжлийн тусламж үзүүлэх эрхтэй этгээд, түүнчлэн Татварын зөвлөгөө өгөх тухай хуулийн §3-ын 1 дэх хэсгийн 2 ба 3-т хамаарах хуулийн этгээдүүд нь тус хуулийн §3-ын 2 дахь хэсгийн хүрээнд татварын асуудлаар үйл ажиллагаа явуулж буй этгээдүүдээр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа бол;
- 3а. Татварын зөвлөхүүд, татварын итгэмжлэгдсэн төлөөлөгчид, аудиторууд болон тангараг өргөсөн нягтлан бодогчид, Татварын зөвлөгөө өгөх тухай хуулийн §3а болон §3с-д заасан этгээдүүд нь тус хуулийн §3а-д заасан бүрэн эрхийн хүрээнд; мөн §3d болон 3е-д заасны дагуу татварын асуудлаар хязгаарлагдмал мэргэжлийн туслалцаа үзүүлэх эрх бүхий этгээдүүд нь бүрэн эрхийн хүрээнд; түүнчлэн Татварын зөвлөхийн тухай хуулийн §3.1-ийн 2 болон 3-т заасан хуулийн этгээдүүд нь тус хуулийн §3.2-т заасан этгээдүүдээр

дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд, COVID-19 цар тахлын үр дагаврыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй төрийн тусламжийн хөтөлбөрүүдийн хүрээнд дээр дурдсан этгээдүүдийг гуравдагч этгээдийн хянан шалгагчаар оролцуулахыг зөвшөөрсөн бол, уг үүргийнхээ хүрээнд оролцож байгаа;

4. Гишүүдээ төлөөлж хөдөө аж ахуйн салбарын мэргэжлийн холбоод;
5. Ажил олгогчдын холбоо болон үйлдвэрчний эвлэл, мөн эдгээрийн гишүүдийн төлөө, эсвэл ижил чиг баримжаатай бусад холбоо, нэгдэл болон тэдгээрийн гишүүдийн төлөө байгуулагдсан нэгдэл, холбоод;
6. Үндсэн дүрмийн дагуу дайны хохирогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамтран төлөөлөх, зөвлөгөө өгөх зорилго бүхий үйл ажиллагааны цар хүрээ, гишүүдийнхээ шинж чанарыг харгалзан шүүх хуралдаанд зохих түвшний төлөөлөл үзүүлэх чадамжтай холбоод;
7. 5 ба 6 дахь хэсэгт заасан байгууллагуудын эдийн засгийн өмчлөлд хамаардаг хуулийн этгээд нь зөвхөн тухайн байгууллага болон түүний гишүүд, эсхүл ижил чиг үүрэгтэй бусад холбоо, нэгдэл болон тэдгээрийн гишүүдэд дүрмийнхээ дагуу хууль зүйн зөвлөгөө өгөх, шүүхэд төлөөлөх үйл ажиллагаа явуулах, мөн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд уг байгууллага нь бүрэн хариуцлага хүлээдэг бол.

Хувь хүн бус этгээдүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн байгууллага болон төлөөлөгчөөрөө дамжуулан оролцоно.

(3) Шүүх нь 2 дахь хэсэгт заасны дагуу төлөөлөх эрхгүй итгэмжлэгдсэн төлөөлөгчийг гомдол гаргах эрхгүйгээр татгалзах захирамж гаргана. Төлөөлөх эрхгүй итгэмжлэгдсэн төлөөлөгчийг татгалзан гаргах хүртэл хийсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс ажиллагаа, тус төлөөлөгчид хүргүүлэх илгээмж, мэдээлэл нь хүчинтэйд тооцогдоно. Хэрэв 2 дахь хэсгийн 2-ын 1 болон 2-т заасан итгэмжлэгдсэн төлөөлөгч нь маргаан болон баримтыг зохих ёсоор тайлбарлаж чадахгүй бол шүүх нь түүнийг цаашид төлөөлөхийг маргахгүй захирамжаар хориглож болно.

(4) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаанаас бусад тохиолдолд Холбооны Захиргааны анхан шатны хэргийн шүүх болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд оролцогч талууд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан төлөөлүүлэх шаардлагатай. Энэ журам нь мөн Захиргааны хэргийн анхан шатны болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх процессын актуудад мөн хамаарна. Зөвхөн 2 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасан этгээд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох эрхтэй. Захиргааны төв байгууллага, нийтийн эрх зүйн этгээд, түүнчлэн тэдний нийтийн эрх зүйн чиг

үүргээ биелүүлэх зорилгоор байгуулагдсан нэгдлүүд нь шүүгчээр ажиллах шаардлагыг хангасан ажилтнуудаараа, эсхүл бусад эрх бүхий байгууллага, нийтийн эрх зүйн этгээд, түүнчлэн тэдний нийтийн үүргийг биелүүлэх зорилгоор байгуулсан нэгдлүүдийн шүүгчээр ажиллах шаардлагыг хангасан ажилтнаар төлөөлүүлж болно. Холбооны Улсын Захиргааны хэргийн шүүхэд 2 дахь хэсгийн 2-ын 5-д заасан байгууллага, түүнчлэн 2 дахь хэсгийн 2-ын 7-д заасны дагуу байгуулсан хуулийн этгээдүүдийг Холбооны захиргааны шүүхэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг зөвшөөрсөн. Үүнд зөвхөн §52.4-т заасан эрх зүйн харилцаанд, хүний нөөцийн төлөөлөлд, Хөдөлмөрийн шүүхийн тухай хуулийн §5-д заасан ажилтнуудын одоогийн болон өмнөх хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудал (үүнд шалгалттай холбоотой маргаан багтана) хамаарах тохиолдолд төлөөлөх эрхтэй байна. Тав дахь өгүүлбэрт заасан итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүгчээр ажиллах шаардлагыг хангасан этгээд байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2 дахь хэсгийн 2-ын 3-7-д заасан этгээд, байгууллага итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллахыг зөвшөөрнө. 3, 5 болон 7 дахь өгүүлбэрт заасан эрх бүхий оролцогч өөрийгөө төлөөлж болно.

(5) Шүүгч өөрийн харьяалагдах шүүх дээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллахыг хориглоно. Иргэдийн төлөөлөгч, 2 дахь хэсгийн 2-ын өгүүлбэрийн 1-д зааснаас бусад тохиолдолд, өөрийн харьяалагдах шүүх бүрэлдэхүүний хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг хориглоно. Энэ тохиолдолд 3 дахь хэсгийн 1 болон 2 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ.

(6) Итгэмжлэлийг бичгээр үйлдэж шүүхийн хавтаст хэрэгт хавсаргана. Итгэмжлэлийг нөхөн хүргүүлж болох бөгөөд шүүхээс эцсийн хугацаа тогтоож болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч дутагдалтай байгааг шүүхийн аль ч шатанд мэдэгдэж болно. Төлөөлөгч нь өмгөөлөгч биш бол шүүх уг асуудлыг өөрийн санаачилгаар харгалзан үзнэ. Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдсон бол шүүхийн бичиг баримт, мэдэгдлийг түүнд илгээнэ.

(7) Оролцогчид шүүх хуралдаанд эрх зүйн тодорхой мэдлэгтэй бие төлөөлөгчийн хамт оролцож болно. Бие төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох эрх бүхий этгээд байж болно. Шүүх тухайн нөхцөл байдалд нийцүүлэн шаардлагатай гэж үзвэл бусад этгээдийг бие төлөөлөгчөөр авч болно. 3 дахь хэсгийн 1 болон 3 дахь өгүүлбэр болон 5 дахь хэсгийг хэрэглэнэ. Оролцогч нэн даруй няцаасан, эсхүл залруулга хийхээс бусад тохиолдолд бие төлөөлөгчийн хэлсэн зүйлийг оролцогч хэлсэнд тооцно.

§67a

(1) Нэгдмэл ашиг сонирхолтой 20-оос дээш тооны этгээд эрх зүйн маргаанд оролцож байгаа бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдоогүй ба энэ нь

эрх зүйн маргааныг хууль ёсны дагуу шийдвэрлэхэд саад учруулахаар бол, шүүх зохих хугацааны дотор тэдгээр этгээдүүдийг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилохыг захирамжаар даалгаж болно. Заасан хугацаанд тухайн этгээдүүдийг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилоогүй тохиолдолд шүүх захирамжаар төлөөлөгчийг томилох шийдвэр гаргаж болно. Оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдолтой процесс ажиллагаанд зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, эсхүл түүний орлогчоор дамжуулан оролцож болно. 1 болон 2 дахь өгүүлбэрт заасан захирамжуудад гомдол гаргах боломжгүй.

(2) Итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл төлөөлүүлж буй этгээд итгэмжлэлийг хүчингүй болгуулах тухай мэдэгдлийг шүүхэд бичгээр болон шүүхийн захиргааны ажилтны тэмдэглэлд оруулмагц төлөөлөх итгэмжлэл хүчингүй болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч энэхүү мэдэгдлийг зөвхөн нийт төлөөлүүлж буй этгээдийн нэрийн өмнөөс бүгдэд нь гаргаж болно. Төлөөлүүлж буй этгээд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс татгалзсан мэдэгдлийг хийснээр төлөөлөх итгэмжлэл нь зөвхөн өөр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдсоныг мэдэгдсэн тохиолдолд дуусгавар болно.

Наймдугаар хэсэг. ХҮЧИНГҮЙ БОЛГУУЛАХ, ҮҮРЭГ ХҮЛЭЭЛГЭХ НЭХЭМЖЛЭЛТЭЙ ХОЛБОГДОЛТОЙ ТУСГАЙ ЗААЛТУУД

§68

(1) Захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахаас өмнө уг захиргааны акт хууль болон зорилгодоо нийцэж буй эсэхийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хянан шалгана. Харин дараах тохиолдолд урьдчилсан хяналт шаардагдахгүй:

1. Хуульд хянан шалгахаар зааснаас бусад тохиолдолд захиргааны актыг Холбооны төрийн дээд байгууллага эсхүл муж улсын төрийн дээд байгууллагаас гаргасан;
2. Шийдвэрийг өөрчлүүлэх мэдэгдэл эсхүл эсэргүүцлийн гомдлоор анх удаа гомдол үүсгэж байгаа бол.

(2) Тодорхой захиргааны акт гаргуулах хүсэлтийг хангахаас татгалзсан тохиолдолд даалгах нэхэмжлэлд 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

§69

Гомдол гаргаснаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа эхэлнэ.

§70

(1) Захиргааны акт гарсан тухай гомдол гаргагчид мэдэгдсэнээс хойш нэг сарын дотор гомдлыг бичгээр, Захиргааны байгууллагын үйл ажиллагааны тухай хуулийн §3а.2-т заасны дагуу цахим хэлбэрээр, мөн Захиргааны байгууллагын үйл ажиллагааны тухай хуулийн §3а.3-т болон Цахим хандалтын тухай хуулийн §9а.5-д заасны дагуу бичмэл хэлбэрийг орлохуйц хэлбэрээр, эсхүл захиргааны актыг гаргасан байгууллагад тэмдэглэл хөтлүүлэх замаар гаргана. Гомдлыг хянах чиг үүрэг бүхий байгууллагад гомдол гаргах тохиолдолд мөн заасан хугацаанд гаргах ёстой.

(2) §58, §60.1-4-ийг хэрэглэнэ.

§71 Сонсгол

Захиргааны актад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад захиргааны актыг цуцлах, эсхүл өөрчлөх тохиолдолд энэ талаар холбогдох этгээдэд мэдэгдэх эсхүл шийдвэр гарахаас өмнө байр суурийг сонсоно.

§72

Гомдлыг үндэслэлтэй гэж эрх бүхий байгууллага үзвэл захиргааны актыг залруулах арга хэмжээ авч, зардлыг шийдвэрлэнэ.

§73

(1) Эрх бүхий байгууллага гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд гомдлыг хянасан тухай шийдвэрт эсэргүүцэл гаргана. Үүнийг дараах этгээдүүд гаргана:

1. хуульд өөрөөр заагаагүй бол дээд шатны байгууллага;
2. хэрэв дээд шатны байгууллага нь Холбооны эсхүл муж улсын дээд шатны байгууллага бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллага;
3. хуульд өөрөөр заагаагүй бол нутгийн өөрөө удирдах ёсны эрх бүхий захиргааны байгууллага.

1 дэх хэсгийн 2-т зааснаас өөрөөр захиргааны актыг гаргасан эрх бүхий байгууллага нь гомдлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй байхыг хуульд тусгайлан заах боломжтой.

(2) 1 дэх хэсэгт урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын оронд хороо, эсхүл зөвлөл оролцвол тухайн заалтууд хэвээр үйлчилнэ. 1 дэх хэсгийн 1-д зааснаас үл хамааран, хороо эсхүл зөвлөлийг тухайн захиргааны актыг гаргасан байгууллагын хүрээнд байгуулж болно.

(3) Гомдол гаргахдаа гомдлыг хянасан тухай захиргааны актын үндэслэлийг зааж, давж заалдах гомдол гаргах талаарх мэдэгдлийг тусган хүргүүлнэ. Хүргэхдээ захиргааны акт хүргүүлэх тухай хуульд заасан журмын

дагуу гүйцэтгэнэ. Мөн гомдолд зардлыг хэн хариуцах талаар тусгана.

§74

(1) Гомдлыг хянасан тухай шийдвэрийг хүргүүлснээс хойш 1 сарын дотор хүчингүй болгуулах нэхэмжлэлийг гаргана. Хэрвээ §68-д заасны дагуу урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн байхыг шаардагдахгүй бол захиргааны актыг нийтэд зарласнаас хойш нэг сарын дотор нэхэмжлэл гаргана.

(2) Захиргааны акт гаргуулах хүсэлтийг хангахаас татгалзсан тохиолдолд даалгах нэхэмжлэлд 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

§75

Тодорхой захиргааны акт гаргуулах хүсэлт, эсхүл гомдлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зохих хугацаанд шийдвэрлээгүй бол §68-д заасныг үл харгалзан нэхэмжлэл гаргахыг зөвшөөрнө. Гэхдээ хэргийн онцгой нөхцөл байдлын улмаас их хугацаа шаардлагатайгаас бусад тохиолдолд гомдол гаргасан, эсхүл тодорхой захиргааны акт гаргуулах хүсэлт гаргаснаас хойш 3 сарын хугацаанд нэхэмжлэл гаргах боломжгүй. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гомдлыг шийдвэрлээгүй, эсхүл хүсэлтийн дагуу захиргааны акт гаргаагүй бол шүүх хугацаа тогтоон хэргийг түдгэлзүүлнэ. Шүүхээс тогтоосон хугацаанд гомдлыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохих захиргааны актыг гаргасан бол хэргийг шийдвэрлэсэн гэж үзнэ.

§76 (хүчингүй болсонд тооцсон)

§77

(1) Гомдол, гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Холбооны бусад хуулийн зохицуулалтыг энэ бүлгийн зохицуулалтаар орлуулан хэрэглэнэ.

(2) Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнөх нөхцөл болгон тогтоосон гомдол, эсхүл гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх муж улсын хуулийн зохицуулалтыг мөн адил энэ бүлгийн зохицуулалтаар орлуулан хэрэглэнэ.

§78

(1) Нэхэмжлэлийг дараах этгээдийн эсрэг гаргана:

1. Тухайн захиргааны актыг гаргасан, эсхүл эс үйлдэхүй гаргасан Холбооны болон муж улсад харьяалагдах байгууллага. Эрх бүхий этгээдийг дурдсан бол хариуцагчийг илэрхийлсэнд тооцно;
2. Муж улсын хуульд тусгайлан заасан бол маргаан бүхий захиргааны

актыг гаргасан, эсхүл зохих актыг гаргаагүй (эс үйлдэхүй) байгууллагын эсрэг.

(2) Хэрэв гомдлыг хянаж гарсан шийдвэрт нь эхний удаа гомдол гаргаж буй бол (§68.1, (§68.1-ийн 2 дахь дахь өгүүлбэр болон 2-т), 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага нь гомдлыг хянан шийдвэрлэх байгууллага байна.

§79

(1) Хүчингүй болгуулах нэхэмжлэлийн маргааны агуулга нь дараах зүйл байж болно:

1. Гомдлын дагуу хэлбэр төдий өөрчлөгдсөн анхны захиргааны акт;
2. Хэрэв анх удаа гомдол гаргаж байгаа бол залруулах шийдвэр эсвэл урьдчилан шийдвэрлэх журмаар гомдлыг хянасан шийдвэр нь маргааны зүйл болно.

(2) Гомдлыг хянасан тухай шийдвэр нь анхны захиргааны актаас гадна нэмэлт хохирол агуулж байгаа тохиолдолд тухайн шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаж болно. Нэмэлт хохирол гэж тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал журмыг зөрчсөнтэй холбоотой байж болох бөгөөд хохирол нь гомдлыг хянасан тухай шийдвэрийн үндэслэл болсон байхыг хэлнэ. Үүний дагуу §78.2-ыг хэрэглэнэ.

§80

(1) Гомдол болон хүчингүй болгуулах нэхэмжлэл нь түдгэлзүүлэх хүчин чадалтай байна. Энэ нь эрх зүйн байдлыг өөрчлөх, тогтоох захиргааны акт болон давхар үйлчлэл бүхий захиргааны актад (§80а) мөн адил хамаарна.

(2) Зөвхөн дараах тохиолдолд түдгэлзүүлэхгүй:

1. нийтэд хамааралтай хураамж, зардал төлөхийг шаардах,
2. цагдаагийн албан хаагчийн хойшлуулах боломжгүй тушаал болон арга хэмжээний үед,
3. Холбооны хууль эсхүл муж улсын хуулиар тусгайлан заасан тохиолдолд, ялангуяа хөрөнгө оруулалт, ажлын байр бий болгохтой холбогдолтой захиргааны актад гуравдагч этгээдээс гаргасан гомдол, нэхэмжлэлд,
- 3а. Холбооны зам, тээврийн болон үүрэн холбооны сүлжээний төсөлд зөвшөөрөл олгохтой холбогдолтой, 3-т заагаагүй захиргааны актад гуравдагч этгээдээс гаргасан гомдол, нэхэмжлэлд,
4. захиргааны актыг гаргасан эсхүл маргааныг хянан шийдвэрлэх байгууллага нь нийтийн ашиг сонирхол буюу холбогдох этгээдийн давамгайл эрх, ашиг сонирхлын үндэслэн нэн даруй биелүүлэхийг онцгойлон заасан тохиолдолд.

Мөн муж улсууд нь Холбооны хуулийн дагуу гүйцэтгэсэн захиргааны албадан хэрэгжүүлэх арга хэмжээний эсрэг гаргасан гомдол, эсэргүүцэл нь түдгэлзүүлэх нөлөөгүй байхаар хуульчлан тогтоож болно.

(3) 2 дахь хэсгийн 4-т хамаарах тохиолдолд захиргааны актыг даруй биелүүлэх онцгой ашиг сонирхлыг бичгээр тайлбарлах ёстой. Захиргааны байгууллага яаралтай арга хэмжээ авах шаардлагатай үед, ялангуяа амь нас, эрүүл мэнд эсхүл өмч хөрөнгөд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлж, нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах үүднээс онцгой арга хэмжээ авч байгаа бөгөөд хэрэгжилтийг хойшлуулах нь үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөлд тусгай үндэслэл шаардагдахгүй.

(4) Холбооны хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол 2 дахь хэсэгт заасан тохиолдлуудад захиргааны актыг гаргасан, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь биелэлтийг түдгэлзүүлж болно. Нийтэд хамааралтай хураамж, зардалтай холбогдолтой албадан гүйцэтгэх ажиллагааг, баталгаа гаргасан тохиолдолд, түдгэлзүүлэх боломжтой. Захиргааны акт нь хуульд нийцсэн эсэхэд ноцтой эргэлзээ байгаа, эсхүл олон нийтийн ашиг сонирхол байгаагаас бусдаар биелэлт нь хураамж, зардал төлөгчид хүндрэл учруулахуйц байвал нийтийн хураамж, зардал төлүүлэх ажиллагааг түдгэлзүүлж болно.

(5) Хүсэлтийн дагуу үндсэн маргааныг хянан шийдвэрлэх шүүх нь 2 дахь хэсгийн 1-3-т хамаарах тохиолдолд түдгэлзүүлэх шийдвэрийг бүрэн эсхүл хэсэгчлэн тогтоож, 2 дахь хэсгийн 4-т заасан тохиолдолд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн сэргээж болно. Мөн энэхүү хүсэлтийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахын өмнө гаргах боломжтой. Шийдвэр гаргах үед захиргааны акт аль хэдийн хэрэгжсэн бол шүүх хэрэгжилтийг цуцлах шийдвэр гаргаж болно. Баталгаа гаргах, эсхүл бусад нөхцөлтэйгөөр түдгэлзүүлсэн байсныг сэргээж болно. Мөн тодорхой хугацаагаар хязгаарлаж болно.

(6) 2 дахь хэсгийн 1-д заасан тохиолдолд, 5 дахь хэсгийн дагуу шүүхэд хүсэлт гаргахыг зөвхөн эрх бүхий байгууллага хэрэгжилтийг түдгэлзүүлэх хүсэлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хангахаас татгалзсан тохиолдолд зөвшөөрнө. Энэ нь дараах тохиолдолд хамаарахгүй:

1. эрх бүхий байгууллага хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр боломжит хугацаанд хүсэлтийн талаар шийдвэр гаргаагүй,
2. албадан гүйцэтгэхээр яаралтай хүлээгдэж байгаа бол.

(7) Хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх 5 дахь хэсэгт заасан хүсэлтийн талаарх захирамжийг хэдийд ч өөрчилж, эсхүл хүчингүй болгож болно. Оролцогч бүр өөрчлөгдсөн нөхцөл байдал, эсхүл анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрөөс үл шалтгаалсан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас өөрчлөлт оруулах, цуцлуулах хүсэлт гаргаж болно.

(8) Яаралтай тохиолдолд шүүх хуралдаан даргалагч дангаар шийдвэр

гаргаж болно.

§80a

(1)Хэрэв гуравдагч этгээдээс өөр этгээдийн хувьд эерэг нөлөөлөл бүхий захиргааны актад гомдол гаргавал эрх бүхий байгууллага дараах арга хэмжээ авч болно:

1. эерэг нөлөөлөлтэй талын хүсэлтээр §80.2-ийн 4-т заасны дагуу нэн даруй биелүүлэх шийдвэр гаргах,
2. гуравдагч этгээдийн хүсэлтээр §80-н 4 дэх хэсэгт заасны дагуу биелэлтийг түдгэлзүүлж, гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нэн даруй үйлчлэх түр хугацааны арга хэмжээ авч болно.

(2)Гуравдагч этгээдэд давуу байдал үүсгэсэн захиргааны актад холбогдох этгээд гомдол гаргавал, гуравдагч этгээдийн хүсэлтээр §80.2-ийн 4-т заасны дагуу эрх бүхий байгууллага нэн даруй биелүүлэхийг даалгаж болно.

(3)Шүүх хүсэлтийн дагуу 1 болон 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлж болно. §80-н 5-8 дахь хэсгийг хэрэглэнэ.

§80b

(1)Гомдол болон хүчингүй болгуулах нэхэмжлэлийн дагуу хийгдсэн түдгэлзүүлсэн захирамж нь гомдол гаргах боломжгүйг зарласнаар, эсхүл анхан шатны шүүх хүчингүй болгуулах нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, тухайн шийдвэрт давж заалдах хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш 3 сарын дараа дуусгавар болно. Үүнд эрх бүхий байгууллага уг актын биелэлтийг шүүхийн эцсийн шийдвэр хүртэл түдгэлзүүлснээс бусдаар захиргааны актын биелэлтийг эрх бүхий байгууллага түдгэлзүүлсэн, эсхүл шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлснийг сэргээсэн, тогтоосон тохиолдлууд мөн хамаарна.

(2) Давж заалдах шатны шүүх хүсэлтийн дагуу түдгэлзүүлэх захирамжийг үргэлжлүүлэх шийдвэр гаргаж болно.

(3)§80-н 5-8 дахь хэсэг болон §80a-г хэрэглэнэ.

§80c

(1)§48.1-ийн 3-15, §50.1-ийн 6-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түдгэлзүүлэх нөлөө тогтоох, эсхүл сэргээхтэй холбоотой харилцаанд §§80, 80a-с гадна энэ зүйлийн 2-4 дэх хэсгийг нэмэлтээр хэрэглэнэ. Харин §48.1-ийн 6-д дурдсан нисэх буудал болон хязгаарлагдмал аюулгүйн бүс бүхий том болон жижиг онгоцны буудал барьж байгуулах, мөн §48.1-ийн 13-т дурдсан хүрэн нүүрсний ил уурхайн зураг төлөвлөгөө батлах

ажиллагаа зэрэг нь энэ хэсэгт хамаарахгүй.

(2)Шүүх нь маргаантай захиргааны актад зөрчил байгаа нь тогтоогдсон ч ойрын хугацаанд засагдах нь илэрхий байвал тухайн зөрчлийг харгалзахгүй байж болно. Дараах зөрчлүүд үүнд хамаарна:

1. журам, эсхүл хэлбэрийн шаардлагыг зөрчсөн,
2. төлөвлөгөө батлах болон төлөвлөгөө батлуулах ажиллагааны хүрээнд дүгнэлт гаргахад гаргасан алдаа.

Алдаа дутагдлыг залруулах хугацааг шүүх тогтооно. Хэрэв хугацаа дуусгавар болоход зөрчлийг залруулаагүй бол §80.7-г хэрэглэнэ. Энэ зүйлийн 1 дэх өгүүлбэр нь Хүрээлэн буй орчны эрх зүйн нэхэмжлэлийн тухай хуулийн §4.1-д заасан процессын алдаанд хамаарахгүй.

(3)Шүүх биелэлтийн үр өгөөж, үр дагаврыг тэнцвэржүүлэх хүрээнд захиргааны актыг түдгэлзүүлэх эсхүл сэргээх шийдвэр гаргах бол залруулшгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Шүүх түдгэлзүүлэх эсхүл сэргээх шийдвэр гаргахдаа захиргааны актаас давуу байдал хүртэж буй этгээдээс баталгаа гаргуулж болно.

(4)Хэрэв тухайн асуудлыг тэнцвэрийг хангах хүрээнд Холбооны хуулиар олон нийтийн эрх ашигт онцгой ач холбогдолтой гэж үзвэл шүүх нь биелэлтийн үр дагаврыг дүгнэж, ач холбогдлыг тусгайлан авч үзэх ёстой.

Есдүгээр хэсэг.

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

§81

(1)Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргана. Мөн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн захиргааны ажилтны тэмдэглэлд тусгуулах хэлбэрээр гаргаж болно.

(2)§55a.5-ийн 3 дахь өгүүлбэрт заасны дагуу хэргийн бусад оролцогчдод зориулсан нэхэмжлэл болон бусад баримт бичгийн хуулбар хувийг хавсаргана.

§82

(1)Нэхэмжлэлд нэхэмжлэгч, хариуцагч болон маргааны гол агуулгыг тусгана. Түүнчлэн тодорхой шаардлагыг тусгасан байна. Нэхэмжлэлийн үндэслэлийг гаргахад шаардлагатай үйл баримт, нотлох баримтуудыг тусгах бөгөөд эс зөвшөөрсөн захиргааны актын эх хувь, хуулбар болон гомдлыг хянасан тухай шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

(2)Нэхэмжлэл эдгээр шаардлагыг хангаагүй бол шүүх хуралдаан даргалагч, эсхүл Шүүхийн тухай хуулийн §21g-д зааснаар хэргийг хариуцсан шүүгч (илтгэгч шүүгч) нэхэмжлэгчээс шаардлагатай нэмэлт мэдээллийг

тодорхой хугацаанд өгөхийг шаардана. 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасан шаардлагуудын аль нэг нь хангагдаагүй бол тэрээр нэхэмжлэгчид тодорхой хугацаа тогтоож болно. Энэ хугацааг сунгах боломжгүй. Өмнөх эрх зүйн байдлыг нөхөн сэргээхэд §60-г хэрэглэнэ.

§83

Үйл баримтын болон нутаг дэвсгэрийн харьяаллыг Шүүхийн тухай хуулийн §17-17b-д заасны дагуу тогтооно. Шүүхийн тухай хуулийн §17a-ын 2 болон 3 дахь хэсгийн дагуу гаргасан шийдвэрт гомдол гаргахгүй.

§84

(1)Тус хэрэг үйл баримт, эрх зүйн хувьд ээдрээ төвөггүй, түүнчлэн хэргийн бодит байдал тодорхой байгаа тохиолдолд шүүх аман хэлэлцүүлэг хийлгүйгээр товч шийдвэр гаргаж болно. Шийдвэр гаргахаас өмнө оролцогчдын байр суурийг сонсоно. Шийдвэрийн талаар ерөнхий зохицуулалтыг хэрэглэнэ.

(2)Шүүхийн хураангуй шийдвэр хүргэгдсэнээс хойш нэг сарын дотор оролцогчид дараах эрх эдэлнэ:

1. зөвшөөрөгдсөн бол давж заалдах гомдол гаргах (§124a),
2. давж заалдах гомдол гаргах хүсэлт, эсхүл аман хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргах, хэрвээ уг хүсэлтүүдийг хамтад нь гаргасан бол аман хэлэлцүүлгийг зайлшгүй хийнэ,
3. зөвшөөрөгдсөн бол зөвхөн хуульд заасан үндэслэлээр давж заалдах гомдол гаргах,
4. хуульд заасан үндэслэлээр гаргасан давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзсан бол үүнд гомдол гаргах эсхүл аман хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргах, хэрвээ уг хүсэлтүүдийг хамтад нь гаргасан бол аман хэлэлцүүлгийг зайлшгүй хийнэ,
5. хэрэв давж заалдах боломжгүй бол аман хэлэлцүүлэг явуулахыг хүсэх.

(3)Шүүхийн товч шийдвэр нь шүүхийн шийдвэрийн адил үйлчлэлтэйд тооцогдоно. Аман хэлэлцүүлэг явуулах хүсэлтийг зохих хугацаанд гаргасан бол шийдвэр эцсийн байдлаар гараагүйд тооцно.

(4)Хэрэв аман хэлэлцүүлэг явагдсан тохиолдолд товч шийдвэрт дурдсан үндэслэл өөрчлөгдөөгүй бол тэмдэглэл хийн шийдвэртээ тусгаж, үндэслэх хэсгийг дахин оруулахгүй байж болно.

§85

Шүүх хуралдаан даргалагч нь нэхэмжлэлийг хариуцагчид гардуулахыг даалгана. Гардуулахтай зэрэгцэн хариуцагчаас бичгээр тайлбар өгөхийг

шаардах бөгөөд §81.1-ийн 2 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ. Үүнд эцсийн хугацаа тогтоож болно.

§86

(1) Шүүх нь чиг үүргийн дагуу нөхцөл байдлыг судлах үүрэг хүлээх бөгөөд оролцогч талуудыг сонсох ёстой. Шүүх нь талуудын гаргасан нотлох баримт, үүнтэй холбогдолтой хүсэлтүүдээр хязгаарлагдахгүй.

(2) Аман хэлэлцүүлгийн явцад гаргасан нотлох баримт гаргуулах хүсэлтээс зөвхөн үндэслэл бүхий шүүхийн захирамжаар татгалзана.

(3) Шүүх хуралдаан даргалагч нь хэлбэрийн алдааг залруулах, тодорхой бус хүсэлтүүдийг тайлбарлуулах, хэрэг хянан шийдвэрлэхэд шаардлагатай хүсэлтүүдийг гаргуулах, үйл баримттай холбогдолтой дутуу мэдээллийг нэмж оруулах, мөн нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэхэд шаардлагатай бүх чухал тайлбаруудыг гаргуулахад чиглэн ажиллах үүрэгтэй.

(4) Оролцогч талууд нь аман хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангах зорилгоор бичгээр тайлбар гаргаж өгнө. Шүүх хуралдаан даргалагч тодорхой хугацаа зааж, тэдгээрийг гаргахыг шаардаж болно. Бичгээр гаргасан тайлбаруудыг оролцогч талуудад албан ёсоор хүргүүлнэ.

(5) Бичгээр гаргасан тайлбарт дурдсан гэрчилгээ, эсхүл цахим баримт бичгийн хуулбарыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хавсаргах ёстой. Бусад оролцогчдод тухайн гэрчилгээ, баримт бичиг нь аль хэдийн мэдэгдэж байгаа, эсхүл овор хэмжээ ихтэй бол нарийвчилсан тэмдэглэл хийлгэн, шүүх дээр танилцах боломжтойг дурдахад хангалттай.

§86a (хүчингүй болсонд тооцсон)

§87

(1) Шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч нь аман хэлэлцүүлэг эхлэхээс өмнө эрх зүйн маргааныг аль болох тухайн хэлэлцүүлгээр шийдвэрлэж дуусгахад шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй. Тэрээр дараах арга хэмжээ авч болно:

1. хэрэг хянан шийдвэрлэх нөхцөл байдал болон маргаантай асуудлыг хэлэлцэх, мөн хэрэг маргааныг эв зүйгээр зохицуулах зорилгоор оролцогч талуудыг урьж, эвлэрлийн гэрээг баталгаажуулах,
2. оролцогч талуудад тэдний урьдчилан бэлтгэсэн баримт бичгүүдэд нэмэлт материал ирүүлэхийг болон тайлбарлахыг, гэрчилгээ гаргаж өгөхийг, цахим баримт бичгүүдийг илгээх, мөн шүүхэд гаргаж өгвөл зохих бусад зүйлсийг танилцуулахыг үүрэг болгох, ялангуяа тодруулах шаардлагатай зарим асуудлын талаар тайлбар өгөх хугацааг тогтоож

болно,

3. мэдээлэл цуглуулах,
4. гэрчилгээ гаргуулах, цахим баримт бичиг илээхийг үүрэг болгох,
5. оролцогчийг биечлэн хүрэлцэн ирэхийг үүрэг болгох, ингэхдээ §95-г хэрэглэнэ,
6. аман хэлэлцүүлэгт гэрч, шинжээчийг дуудах.
7. (хүчингүй болсонд тооцсон)

(2) Аливаа захирамжийг оролцогч талуудад мэдэгдэнэ.

(3) Даргалагч шүүгч эсвэл илтгэгч нотлох баримтыг тус тусад нь авч болно. Үүнийг зөвхөн шүүхийн өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд л хийж болох бөгөөд шүүх нотлох баримтын хэрэгт хамааралтай байдлыг эцэслэн тогтоохгүйгээр нотлох баримтыг зохих ёсоор үнэлэх боломжтой гэж эхнээс нь үзэж болно.

§ 87a

(1) Хэрэв шийдвэрийг бэлтгэл ажиллагааны явцад гаргасан бол даргалагч шүүгч дараах зүйлийг шийдвэрлэнэ:

1. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, зогсоох тухай;
2. нэхэмжлэлийг буцаан татах, гаргасан нэхэмжлэлээс татгалзах, эсхүл хууль зүйн туслалцаа хүссэн өргөдөл зэрэг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд;
3. хууль зүйн туслалцаа хүссэн өргөдөл зэрэг үндсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шийдвэрлэх тохиолдолд;
4. маргаантай үнийн дүнгийн тухай;
5. зардлын тухай;
6. талуудыг нэгтгэх тухай.

(2) Талуудын зөвшөөрлөөр даргалагч шүүгч танхим эсвэл сенатын оронд шийдвэр гаргаж болно.

(3) Хэрэв илтгэгчийг томилсон бол илтгэгч нь даргалагч шүүгчийн оронд шийдвэрлэнэ.

§87b

(1) Шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ач холбогдол өгсөн эсхүл өгөөгүй, үүнээс үүдэн эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн гомдлын дагуу нэхэмжлэгчид үйл баримтыг мэдэгдэх хугацааг тогтоож болно. 1 дэх өгүүлбэрт заасны дагуу хугацаа тогтоохдоо энэ хуулийн §82.2-ын 2 дахь өгүүлбэрт заасан хугацаатай нэгтгэж болно.

(2) Шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч оролцогч талуудад

тодорхой хугацаа тогтоон, дараах үүргийг оногдуулж болно

1. нотлох баримт мэдүүлэх эсхүл нотлох баримт гаргах арга хэлбэрийг тодорхойлох,
2. оролцогч тал үүрэг хүлээсэн бол гэрчилгээ эсхүл бусад хөдлөх эд хөрөнгө, цахим баримт бичиг шилжүүлэх.

(3) 1, 2 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон хугацаанаас хойш гаргасан тайлбар, нотлох баримтыг хэрэгсэхгүйд тооцож нэмэлт хэлэлцүүлэг мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүйгээр дараах шийдвэрийг гаргаж болно

1. шүүхийн дотоод итгэл үнэмшилд тулгуурлан нотлох баримтад тооцох тохиолдолд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явц хойшлоход хүргэх,
2. оролцогч тал хугацаа хэтрүүлсэн үндэслэлээ нотолж чадаагүй,
3. оролцогч талд хугацаа хэтрүүлсний үр дагаврын талаар мэдэгдсэн.

Шүүх шаардсан тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаанаа нотлох үүрэгтэй. Тухайн хэргийн нөхцөл байдлыг оролцогч тал хамтын оролцоогүйгээр тогтоох боломжтой тохиолдолд 1 дэх өгүүлбэр үйлчлэхгүй.

(4) 3 дэх хэсэгт зааснаас өөрөөр §48.1-ийн 3-15, 50.1-ийн 6-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 1, 2 дахь хэсэгт тогтоосон хугацаанаас хойш гаргасан тайлбар, нотлох баримтыг шүүх хүлээн авахаас татгалзаж цаашид нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүйгээр шийдвэр гаргана.

1. оролцогч тал хугацаа хэтрүүлсэн үндэслэлээ нотолж чадаагүй
 2. оролцогч талд хугацаа хэтрүүлсний үр дагаврын талаар мэдэгдсэн.
- 3 дахь хэсгийн 2 ба 3 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ.

§87с

(1) §48.1-ийн 3-15, §50.1-ийн 6-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэн тэргүүнд явуулна. Үүнд дараах ажиллагаа хамаарна.

1. §47.1-ийн 1-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, хэрэв тухайн хэрэг нь §48.1-ийн 3, 3а, 3б эсхүл 5-д дурдсан төсөлтэй холбогдох газар ашиглалтын төлөвлөлт, эсхүл тогтоолын агуулгатай бол
2. §47.1-ийн 2-т заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, хэрэв тухайн хэрэг нь салхины эрчим хүч ашиглах бүс нутгийг тогтоосон нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг хамарч байвал

Нийтийн ашиг сонирхолд онцгой ач холбогдолтой гэж Холбооны хуулиар зохицуулсан бол тухайн төсөлтэй холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэн тэргүүнд явуулна. §48.1-ийн 6-д заасан хязгаарлагдмал аюулгүйн бүс бүхий том болон жижиг онгоцны буудал барьж байгуулах болон §48.1-ийн 13-т заасан хүрэн нүүрсний ил уурхайн төлөвлөгөө батлах ажиллагаанд 1 дэх өгүүлбэр хамаарахгүй.

(2) 1 дэх хэсэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохистой гэж

үзвэл шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч хэргийн нөхцөл байдлыг хэлэлцэж, эвлэрүүлэх зорилгоор хэргийн оролцогчдыг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ. Уулзалтын явцад эвлэрээгүй бол шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч хэргийн оролцогч талуудтай цаашдын ажиллагааны явц болон аман хэлэлцүүлгийн боломжит товыг хэлэлцэнэ.

§88

Шүүх зөвхөн нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэр гаргах боловч нэхэмжлэлийн үг хэллэг, томъёололд хязгаарлагдахгүй.

§89

(1)Сөрөг нэхэмжлэлийн шаардлага нь нэхэмжлэлийн шаардлага эсхүл нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэхэд ашигласан хамгаалалтын арга хэрэгсэлтэй холбоотой бол нэхэмжлэл гаргасан шүүхэд сөрөг нэхэмжлэл гаргах боломжтой. §52.1-д заасны дагуу сөрөг нэхэмжлэл өөр шүүхэд харьяалагдах нөхцөлд энэ зохицуулалт үйлчлэхгүй.

(2)Хүчингүй болгуулах, даалгах /үүрэг хүлээлгэх/ нэхэмжлэлд сөрөг нэхэмжлэл гаргахгүй.

§90

Нэхэмжлэл гаргаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлнэ. Шүүхийн тухай хуулийн 17-р бүлгээс хойш хэсэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэх хугацаа уртассан бол уг хугацаа дууссаны дараа тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхэлнэ.

§91

(1)Оролцогч талууд зөвшөөрсөн эсхүл нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх нь хэрэг маргааныг шийдвэрлэхэд тустай гэж шүүх үзвэл нэхэмжлэлийн шаардлагыг өөрчилж болно.

(2)Хэргийн оролцогчоос өөрчлөгдсөн нэхэмжлэлийн шаардлагын талаар бичгээр эсхүл аман хэлэлцүүлгийн явцад эсэргүүцэл гаргаагүй бол нэхэмжлэлийн шаардлага өөрчилснийг зөвшөөрсөнд тооцно.

(3)Нэхэмжлэлд өөрчлөлт оруулахгүй эсхүл оруулахыг зөвшөөрөөгүй шийдвэрт дангаар гомдол гаргахгүй.

§92

(1)Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзаж болно. Аман хэлэлцүүлгийн явцад хариуцагч зөвшөөрсөн, хэрэв нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн оролцож байгаа бол

оролцогч тал зөвшөөрсөн тохиолдолд нэхэмжлэлээс татгалзсан тухай хүсэлт гаргаж болно. Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хүргүүлснээс хойш хоёр долоо хоногийн дотор гомдол гаргаагүй бол зөвшөөрсөнд тооцож шүүх энэ талаарх үр дагаврыг зааж өгнө.

(2)Шүүх шаардлага хүргүүлсэн боловч нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хоёр сараас дээш хугацаагаар оролцоогүй бол нэхэмжлэлээс татгалзсанд тооцно. 1 дэх хэсгийн 2, 3 дахь өгүүлбэр үйлчилнэ. Нэхэмжлэгчид 1 дэх өгүүлбэр болон энэ хуулийн §155.2-т заасан үр дагаврын талаар анхааруулна. Нэхэмжлэлээс татгалзсанд тооцсоныг шүүхийн шийдвэрээр тогтооно.

(3)Нэхэмжлэлээс татгалзсан эсхүл татгалзсанд тооцсон бол шүүх шийдвэр гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгаж, энэ хуулийн дагуу үүсэх үр дагаврын талаар мэдэгдэнэ. Уг шийдвэрт гомдол гаргахгүй.

§93

Шүүх адил маргаан бүхий хэд хэдэн хэргийг нэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгтгэж эсхүл эргүүлэн тусгаарлах шийдвэр гаргаж болно. Шүүхийн шийдвэрээр нэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гаргасан нэхэмжлэлийг хэд хэдэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгаарлаж болно.

§93а

(1)Захиргааны байгууллагын үйл ажиллагаа хуульд нийцэх эсэхийг тогтоох нь 20-оос дээш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох бол шүүх нэг эсхүл хэд хэдэн тохиромжтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа урьдчилан явуулж (жишиг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа) бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Холбогдох оролцогч талын байр суурийг урьдчилан сонсоно. Уг шийдвэрт гомдол гаргахгүй.

(2)Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудад гарсан шийдвэрүүд хуулийн хүчин төгөлдөр болсон бол шүүх хуулийн хүчин төгөлдөр болсон жишиг хэргүүдтэй харьцуулж үйл баримтын эсхүл эрх зүйн хувьд ээдрээ төвөггүй, түүнчлэн хэргийн бодит байдал тодорхой байгаа гэж санал нэгтэй үзсэн тохиолдолд оролцогч талуудын байр суурийг сонссоны дараа түдгэлзүүлсэн хэрэг маргааныг шийдвэрлэнэ. Шүүх жишиг хэрэгт авагдсан нотлох баримтыг ашиглаж болно; мөн шүүх гэрчээс дахин мэдүүлэг авах, тухайн эсхүл өөр шинжээчээр дахин дүгнэлт гаргуулахыг үүрэг болгож болно. Жишиг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйл баримтыг нотолсон баримтыг үнэлсэн бөгөөд шийдвэр гаргахад нөлөөлөхүйц шинээр гаргасан нотлох баримт нь хэрэг маргаан шийдвэрлэх явцыг удаашруулж болзошгүй гэж шүүх өөрийн итгэл

үнэмшлээр үзэж байгаа бол энэхүү үйл баримттай холбоотой нотлох баримтыг хүлээн авахаас татгалзаж болно. Татгалзсан шийдвэрийг 1 дэх өгүүлбэрт заасны дагуу зохицуулна. Шүүхийн шийдвэр гарсан бол оролцогч талууд 1 дэх өгүүлбэрт заасны дагуу гарсан шийдвэрийн эсрэг давж заалдах гомдол гаргах эрхтэй. Оролцогч талуудад давж заалдах гомдол гаргах эрхтэйг мэдэгдэнэ.

§94

Хэрэг маргаан нь хянан шийдвэрлэх гэж буй өөр хэрэг маргаан эсхүл захиргааны байгууллагын шийдвэрээс бүхэлдээ болон хэсэгчлэн хамаарч байгаа бол шүүх тухайн хэрэг маргаан шийдвэрлэгдэх эсхүл захиргааны байгууллагаас шийдвэр гарах хүртэл түдгэлзүүлнэ.

§95

(1)Шүүх хэргийн оролцогч талыг биечлэн ирэхийг даалгаж болно. Биечлэн ирсэн гэж энэ хуулийн §102а.2-ын 1 дэх өгүүлбэрт заасны дагуу дүрс, дууны дамжуулалтаар оролцсоныг биечлэн ирсэнд тооцно. Хэрэв оролцогч тал шүүх хуралдаанд ирээгүй бол түүнд гэрчийн нэгэн адил торгох шийтгэл оногдуулах тухай анхааруулна. Өөрийн буруугаас ирээгүй тохиолдолд шүүх торгох шийтгэл оногдуулах шийдвэр гаргаж торгуулийн хэмжээг тогтооно. Торгох шийтгэл оногдуулах болон анхааруулах арга хэмжээг давтан авч болно.

(2)Оролцогч тал нь хуулийн этгээд, холбоо эсхүл эвсэл бол хууль, дүрэмд заасан итгэмжлэгдсэн төлөөлөгчид анхааруулж, торгох шийтгэл оногдуулна.

(3)Нийтийн эрх зүйн хуулийн этгээд эсхүл эрх бүхий байгууллагыг аман хэлэлцүүлэгт оролцуулахаар бол хууль эрх зүйн болон хэргийн талаар хангалттай мэдээлэлтэй төрийн албан хаагч эсхүл ажилтан томилохыг үүрэг болгож болох бөгөөд тэрээр итгэмжлэлээ бичгээр авч ирнэ.

§96

(1)Шүүх аман хэлэлцүүлгийн явцад нотлох баримт гаргаж болно. Шүүх нотлох баримтыг нарийвчлан шалгах, гэрч, шинжээч, хэргийн оролцогчдоос асуулт асууж, хэрэг цугларсан баримттай танилцаж болно.

(2)Тодорхой тохиолдолд аман хэлэлцүүлгээс өмнө шүүгчдийн дундаас нэгийг нотлох баримт цуглуулахаар эсхүл нотлох баримтын тухай асуултыг тодорхойлох, өөр шүүхэд нотлох баримт шинжлүүлэх тухай хүсэлт гаргуулахаар томилж, үүрэг болгоно.

§97

Нотлох баримт цуглуулах ажиллагааг оролцогч талуудад урьдчилан мэдэгдэж, оролцох боломжийг олгоно. Оролцогч тал нь гэрч, шинжээчдэд

хэрэг маргаантай холбоотой асуулт тавьж болно. Асуултыг эсэргүүцсэн тохиолдолд шүүх шийдвэрлэнэ.

§98

Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нотлох баримт цуглуулахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §§358-444 болон §§450-494-т заасан зохицуулалтуудыг хэрэглэнэ.

§99

(1)Захиргааны эрх бүхий байгууллагууд гэрчилгээ, бичиг баримт гаргаж өгөх, цахим бичиг баримтыг дамжуулах, лавлагаа гаргаж өгөх үүрэгтэй. Хэрэв эрх бүхий байгууллагууд бичиг баримтыг цахимаар хөтөлдөг бол тэдгээрийг технологийн боломжит хэлбэрээр хайлт хийх боломжтой байдлаар гаргаж өгнө. Хэрэв эдгээр гэрчилгээ, бичиг баримт, цахим бичиг баримт эсхүл лавлагааны агуулгыг ил болгох нь Холбооны эсхүл муж улсын ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх эсхүл хууль болон агуулгын хувьд нууцлалтай бол хяналт тавих дээд шатны захиргааны байгууллагаас эдгээр гэрчилгээ, бичиг баримтыг гаргаж өгөх, цахим бичиг баримтыг дамжуулах болон лавлагаа гаргаж өгөхөөс татгалзаж болно.

(2)Оролцогч талын хүсэлтийн дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх аман хэлэлцүүлэг хийлгүйгээр тухайн гэрчилгээ эсхүл бичиг баримт гаргаж өгөхгүй байх, цахим бичиг баримтыг дамжуулахгүй байх эсхүл лавлагаа гаргаж өгөхөөс татгалзах нь хуульд нийцэж буй эсэхийг тогтоож шийдвэр гаргана. Холбооны хяналт тавих дээд шатны байгууллага гэрчилгээ, бичиг баримт, цахим бичиг баримт, лавлагааг гаргаж өгөх, дамжуулах нь Холбооны эрх ашигт сөргөөр нөлөөлнө гэх үндэслэлээр гаргаж өгөхөөс татгалзвал Холбооны захиргааны хэргийн шүүх шийдэх бөгөөд §50-д заасны дагууүндсэнхэрэгмаргааныгхянаншийдвэрлэхажиллагаамөнадилХолбооны захиргааны хэргийн шүүхэд хамаарна. Хүсэлтийг үндсэн хэрэг маргааныг харьяалах эрх бүхий шүүхэд гаргана. Тухайн шүүх нь хүсэлт болон үндсэн хэрэг маргааны хавтаст хэргийг §189-д заасны дагуу холбогдох харьяаллын шүүхэд шилжүүлнэ. Хяналт тавих эрх бүхий дээд шатны байгууллага нь 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн дагуу гаргаж өгөхөөс татгалзсан гэрчилгээ эсхүл бичиг баримтыг тухайн шүүх бүрэлдэхүүний хүсэлтийн дагуу гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус байгууллагыг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бичиг баримтын нууцын тухай зохицуулалтыг дагаж мөрдөнө. Эдгээрийг хангах боломжгүй эсхүл холбогдох хяналт тавих дээд шатны эрх бүхий байгууллага нууцлалын болон аюулгүй байдлын тусгай нөхцөлийг үндэслэн

гэрчилгээ, бичиг баримтыг гаргаж өгөх эсхүл цахим бичиг баримт дамжуулах боломжгүй тохиолдолд тухайн хяналтын байгууллагаас заасан өрөө, тасалгаанд танилцах боломжийг шүүхэд олгосноор 5 дахь өгүүлбэрт заасан гэрчилгээ, бичиг баримтыг гаргаж өгөх эсхүл цахим бичиг баримт дамжуулах шаардлага биелэгдэнэ. §100-ын 5 дахь өгүүлбэрт заасны дагуу гаргаж өгсөн бичиг баримт, цахим бичиг баримт болон 8 дахь өгүүлбэрт заасан үндэслэлд үйлчлэхгүй. Шүүгч нь нууц хадгалах үүрэгтэй; шийдвэрийн үндэслэлд нууцад хамаарах гэрчилгээ, бичиг баримт, цахим бичиг баримт болон лавлагааны агуулгыг тусгахгүй. Шүүгч бус этгээдэд хувийн нууцыг хамгаалах тухай журам үйлчилнэ. Холбооны захиргааны хэргийн шүүх шийдвэр гаргаагүй тохиолдолд, давж заалдах гомдол гаргах замаар шийдвэрийг эсэргүүцэж болно. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг Холбооны захиргааны хэргийн шүүх шийдвэрлэнэ. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд 4 болон 11 дэх өгүүлбэр үйлчилнэ.

§100

(1)Оролцогч талууд шүүхийн бичиг баримт болон шүүхэд гаргаж өгсөн бичиг баримттай танилцаж болно. Оролцогч талууд шүүхийн ажлын албаар дамжуулан өөрийн зардлаар гэрчлүүлсэн хуулбар, хэсэгчлэн бичсэн хувилбар, цахим бичиг баримтын хэвлэсэн хуулбар болон гэрчлүүлээгүй хуулбарыг гаргуулж авах эрхтэй.

(2)Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цахимаар хөтлөх тохиолдолд хэргийн агуулгад баталгаат сувгаар хандах эсхүл дамжуулах боломжоор хангана. Тусгайлсан хүсэлтийг үндэслэн албан тасалгаанд хавтаст хэрэгтэй танилцах боломж олгоно. Хууль ёсны, үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд хавтаст хэргээс хэсэгчлэн хэвлэж эсхүл агуулгыг нь багтаасан дунд хэмжээний өгөгдлийг гаргаж өгнө. 1 дэх өгүүлбэрт заасан аргаар хавтаст хэрэгтэй танилцуулах боломжгүй бол хүсэлт гаргахгүйгээр 2, 3 дахь өгүүлбэрт заасан хэлбэрээр танилцах боломжийг олгоно. 3 дахь өгүүлбэрт заасан хүсэлтэд шүүх хуралдаан даргалагч шийдвэр гаргах бөгөөд энэхүү шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй. Үүнд §87а.3 үйлчилнэ.

(3)Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хавтаст хэргийг цаасан хэлбэрээр хөтлөх тохиолдолд албан тасалгааны хүрээнд хавтаст хэрэгтэй танилцах боломж олгоно. Хориглох бодит шалтгаан байхгүй бол хэргийн агуулгыг баталгаат сувгаар татаж авах эсхүл дамжуулахыг зөвшөөрнө. Шүүх хуралдаан даргалагчийн итгэл үнэмшлээр §67.2-ын 1, 2 дахь өгүүлбэр болон 3-6-д заасны дагуу эрх бүхий этгээдэд хавтаст хэргийг хувийн орон байр эсхүл ажлын байр руу авч явахыг зөвшөөрч болно. §87а.3 үйлчилнэ.

(4)Тогтоол, шийдвэр, шүүхийн захирамжийн төсөл, тэдгээрийг бэлтгэх

болон санал хураалттай холбоотой бичиг баримттай 1-3 дэх хэсэгт заасны дагуу танилцахыг хориглоно.

§101

(1)Хуульд өөрөөр заагаагүй бол шүүх аман хэлэлцүүлэгт үндэслэн шийдвэр гаргана. Аман хэлэлцүүлгийг аль болох богино хугацаанд эхлүүлнэ.

(2)Оролцогч талууд зөвшөөрсөн тохиолдолд шүүх аман хэлэлцүүлэг явуулахгүйгээр шийдвэр гаргаж болно.

(3)Хуульд өөрөөр заагаагүй бол шүүхийн шийдвэрээс бусад шийдвэрийг шүүх аман хэлэлцүүлэг хийлгүйгээр гаргаж болно.

§102

(1)Аман хэлэлцүүлгийн тов зарлагдсан тохиолдолд оролцогч талуудыг хамгийн багадаа хоёр долоо хоногийн өмнө, Холбооны захиргааны хэргийн шүүхийн хувьд хамгийн багадаа дөрвөн долоо хоногийн өмнө шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ. Яаралтай тохиолдолд шүүх хуралдаан даргалагч уг хугацааг богиносгож болно.

(2) Оролцогч талууд ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг явуулж, шийдвэр гаргаж болохыг шүүхийн мэдэгдэх хуудсанд тусгана.

(3)Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэн бол захиргааны хэргийн шүүх өөрийн шүүхийн байрнаас өөр газар хуралдаж болно.

(4)Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §227.3-ын 1 дэх өгүүлбэр хамаарахгүй.

§102a

(1)Аман хэлэлцүүлгийг зохих тохиолдолд, хангалттай нөөцтэй гэж үзвэл видео хурлын хэлбэрээр явуулж болно. Аман хэлэлцүүлгийн нэг буюу түүнээс дээш тооны оролцогч тал дүрс, дуу дамжуулах хэрэгслээр оролцож байгаа бол видео хурал гэж үзнэ. Энэ хэсгийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч тал гэдэгт хэргийн оролцогч талууд, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон гуравдагч этгээдүүд хамаарна.

(2)Шүүх 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрт заасан урьдчилсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талын хүсэлтээр эсхүл өөрийн чиг үүргийн дагуу нэг оролцогч, хэд хэдэн оролцогч эсхүл бүх оролцогчид дүрс, дуу дамжуулах хэрэгслээр оролцох зөвшөөрөл олгож болно. Дүрс, дуу дамжуулах хэрэгслээр оролцох хүсэлтээс татгалзсан тохиолдолд товч үндэслэлтэй тайлбарлах үүрэгтэй.

(3)Шүүх хүсэлтийн дагуу эсхүл өөрийн чиг үүргийн дагуу гэрч, шинжээч эсхүл оролцогчоос дүрс, дуу дамжуулах хэрэгсэл ашиглан мэдүүлэг авахыг

зөвшөөрч болно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч тал, гэрч болон шинжээч хүсэлт гаргах эрхтэй. Үүнд 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

(4)Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талуудад болон гуравдагч этгээдэд бичлэг хийж, дамжуулахыг хориглоно. Үүнийг аман хэлэлцүүлгийн эхэнд тэдэнд сануулна. Шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §160а.3-т заасны дагуу хэлэлцүүлгийн дүрс, дуу дамжуулалтыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хийж болно. Дуу, дүрс дамжуулалт эхлэх болон дуусах тухай шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талуудад, мөн 3 дахь хэсгийн заасан тохиолдолд гэрчүүд болон шинжээчдэд мэдэгдэх үүрэгтэй.

(5)Энэ зүйлийн дагуу гаргасан шийдвэрт гомдол гаргахгүй.

(6)Аман хэлэлцүүлэгт 1-5 дахь хэсэгт заасан зохицуулалт үйлчилнэ (§87.1-ийн 2 дахь өгүүлбэрийн 1 болон §87с.2-ын 1 дэх өгүүлбэр).

§103

(1)Аман хэлэлцүүлгийг шүүх хуралдаан даргалагч нээж, удирдана.

(2)Хэрэг хэлэлцэж эхэлмэгц шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч хэргийн үндсэн агуулгыг танилцуулна.

(3)Үүний дараа хэргийн оролцогчдод үг хэлэх болон хүсэлтийнхээ үндэслэлийг танилцуулна.

§104

(1)Шүүх хуралдаан даргалагч нь оролцогчидтой, хэрэг маргааныг бүрэн бодитойгоор тогтоож, хуулийн дагуу явуулна.

(2)Шүүх хуралдаан даргалагч хүсэлт гаргасан шүүгч бүрт асуулт асуух зөвшөөрөл олгоно. Хэрэв оролцогч талаас асуултыг эсэргүүцвэл шүүх шийдвэрлэнэ.

(3)Хэрэг маргааныг хянан хэлэлцэж дууссаны дараа шүүх хуралдаан даргалагч аман хэлэлцүүлэг хаасныг мэдэгдэнэ. Шүүх дахин аман хэлэлцүүлгийг нээх тухай шийдвэр гаргаж болно.

§105

Хуралдааны тэмдэглэлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §§159-165-ыг хамаарна.

§106

Хэрэг маргааныг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шийдвэрлэхийн тулд оролцогч талууд шүүхийн эсхүл шүүхээс томилогдсон эсхүл хүсэлтийн дагуу хуваарилагдсан шүүгчийн тэмдэглэлд тэмдэглүүлэн эвлэрлийн гэрээ

байгуулж, маргааны зүйлийг захиран зарцуулах эрхтэй. Оролцогч талууд шүүх, шүүх хуралдааны даргалагч, илтгэгч шүүгчийн бичгээр гаргасан санал эсхүл аман хэлэлцүүлгийн үед тэмдэглэгдсэн саналыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шүүх эвлэрлийг баталж болно.

Аравдугаар хэсэг. **ШҮҮХИЙН ШИЙДВЭР БА БУСАД ШИЙДВЭРҮҮД**

§107

Хуульд өөрөөр заагаагүй бол нэхэмжлэлийг шүүхийн шийдвэрээр шийдвэрлэнэ.

§108

(1) Шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийт үр дүнд үндэслэн дотоод итгэл үнэмшлийн дагуу шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэрт шүүгчийн итгэл үнэмшилд хүргэсэн үндэслэлийг тусгасан байна.

(2) Шүүхийн шийдвэр нь зөвхөн оролцогч талуудын тайлбар хийх боломжтой баримт, нотлох баримтад тулгуурлана.

§109

Нэхэмжлэлийг хүлээн авах боломжтой эсэхийг шүүхийн явцын шийдвэрээр урьдчилан шийдвэрлэж болно.

§110

Хэрэг маргааны зүйлийн нэг хэсгийг шийдвэрлэх боломжтой бол шүүх хэсэгчилсэн шийдвэр гаргаж болно.

§111

Даалгах нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл ба үнийн дүн маргаантай бол шүүхийн явцын шийдвэрээр тухайн асуудлыг урьдчилан шийдвэрлэж болно. Нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй гэж үзсэн бол үнийн дүнгийн асуудлыг хэлэлцэхээр шүүх шийдвэрлэж болно.

§112

Шүүхийн шийдвэрийг зөвхөн шүүх хуралдаанд оролцсон шүүгчид болон иргэдийн төлөөлөгч шүүгч гаргана.

§113

(1)Захиргааны акт хууль бус бөгөөд нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн тохиолдолд шүүх уг захиргааны актыг болон үүнтэй холбогдолтой гарсан байж болзошгүй бусад шийдвэрийг хүчингүй болгоно. Хэрэв захиргааны акт биелэгдсэн бол хүсэлтийн дагуу шүүх захиргааны байгууллагад захиргааны актын биелэлтийг буцаахыг зааж өгч болно. Зөвхөн эрх бүхий захиргааны байгууллага үүнийг хэрэгжүүлэх боломжтой буюу уг шийдвэр биелэх боломжтой тохиолдолд зөвшөөрөгдөнө. Үүнээс өмнө захиргааны актыг эргүүлэн татсан эсхүл өөр аргаар шийдвэрлэсэн бол хүсэлтэд үндэслэн тухайн акт нь нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж байсныг тогтоох буюу шүүхээс хууль бус болохыг тогтоосон шийдвэр гаргана.

(2)Нэхэмжлэгч нь захиргааны актад заасан мөнгөн дүн эсхүл түүнд холбогдох захиргааны актад өөрчлөлт оруулахыг шаардсан бол шүүх уг дүнг өөрчилж тогтоох эсхүл захиргааны актыг өөрчлөх боломжтой. Хэрэв тогтоосон эсхүл тогтоох дүнг тооцоолох нь багагүй ажиллагаа шаардах бол хууль зөрчихдөө харгалзан эсхүл харгалзаагүй үйл баримт, эрх зүйн харилцааг дурдаж захиргааны актыг өөрчлөх үндэслэлийг заах бөгөөд захиргааны байгууллага шүүхийн шийдвэрийг үндэслэн мөнгөн дүнг тооцоолох бололцоот байдлаар хангана. Эрх бүхий захиргааны байгууллага хэргийн оролцогчид шинэчилсэн дүнг даруй мэдэгдэх ёстой бөгөөд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц захиргааны актыг шинэчилсэн агуулгаар дахин нийтэлнэ.

(3)Шүүх нэмэлт тодруулга шаардлагатай гэж үзвэл, эцсийн шийдвэр гаргахгүйгээр захиргааны акт болон гомдлыг хүчингүй болгож шийдвэрлэнэ. Энэ нь шаардлагатай шалгах ажиллагаа их, цар хүрээ өргөн, оролцогч талуудын ашиг сонирхолд нийцэж буй эсэхийг харгалзан хүчингүй болгох нь зохистой гэж тооцогдох тохиолдолд явагдана. Нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүх шинэ захиргааны акт гаргах хүртэл түр зохицуулалт хийж болно. Тухайлбал, баталгаа гаргуулах эсхүл баталгааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн үлдээх эсхүл эхний байдлаар гүйцэтгэлийг буцаах шаардлагагүйг зааж болно. Энэ шийдвэрийг ямар ч үед өөрчлөх эсхүл хүчингүй болгох боломжтой. 1 дэх өгүүлбэрийн дагуу гаргах шийдвэрийг шүүх эрх бүхий байгууллагын актыг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор гаргана.

(4)Захиргааны актыг хүчингүй болгохын зэрэгцээ төлбөрийн гүйцэтгэл шаардах боломжтой бол тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд тус гүйцэтгэлийг даалгаж болно.

(5)Захиргааны актыг гаргахаас татгалзах эсхүл гаргахгүй байх эс үйлдэхүй нь хууль бус бөгөөд үүний улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн бол хэргийг шийдвэрлэхэд бэлэн болсон үед шүүх тухайн захиргааны байгууллагад холбогдох акт гаргахыг даалгана. Бусад тохиолдолд шүүх хууль зүйн хүрээнд нэхэмжлэгчид энэ талаар хариу өгч, мэдэгдэхийг үүрэг болгоно.

§114

Захиргааны байгууллага сонгох боломжийн хүрээнд өөрийн итгэл үнэмшлээр шийдвэр гаргах эрхтэй тохиолдолд захиргааны байгууллагын үйлдэл, эс үйлдэхүй хуулиар тогтоосон цар хүрээнээс хэтэрсэн эсэх, сонгох боломжоо зорилгодоо нийцээгүй байдлаар ашигласан эсэхийг шүүх хянан шалгана. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хэлэлцэж буй захиргааны актад холбогдуулан эрх бүхий захиргааны байгууллагаас нэмэлт тайлбарыг хийж болно.

§115

§79.1.2 болон 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан эсэргүүцэл нь хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй холбогдох бол §113 болон §114-ийг хэрэглэнэ.

§116

(1) Аман хэлэлцүүлэг болсон тохиолдолд шүүхийн шийдвэрийг шүүх хуралдаан хаасан өдөр уншиж танилцуулах бөгөөд онцгой тохиолдолд шүүхийн шийдвэрийг хоёр долоо хоногоос ихгүй хугацаанд танилцуулах талаар зарлана. Шүүхийн шийдвэрийг оролцогч талуудад хүргүүлнэ. Шүүх хуралдаан даргалагч нь шүүхийн шийдвэр танилцуулах үеэр оролцогч тал, тэдний төлөөлөгч болон өмгөөлөгчид дуу, дүрсний дамжуулалттай оролцохыг зөвшөөрч болно.

(2) Шүүхийн шийдвэрийг албан ёсоор танилцуулахын оронд хүргүүлж болно; энэ тохиолдолд аман хэлэлцүүлэг дууссанаас хойш хоёр долоо хоногийн дотор шүүхийн шийдвэрийг бүртгэлийн газарт хүргүүлнэ.

(3) Шүүх аман хэлэлцүүлэг хийлгүйгээр шийдвэрлэх тохиолдолд шийдвэрийг оролцогч талд хүргүүлнэ.

§117

(1) Шүүхийн шийдвэрийг “Ард түмний нэрийн өмнөөс” гаргана. Шүүхийн шийдвэрийг бичгээр үйлдэж, шийдвэр гаргахад оролцсон шүүгч нар гарын үсэг зурна. Хэрэв шүүгч гарын үсэг зурах боломжгүй бол энэ тухай шалтгааныг шүүх хуралдаан даргалагч эсхүл түүнийг боломжгүй тохиолдолд хамгийн ахмад шүүгч шүүхийн шийдвэрт үндэслэлийг тусгана. Иргэдийн төлөөлөгч шүүгчийг гарын үсэг зурахыг шаардахгүй.

(2) Шүүхийн шийдвэр дараах хэсгээс бүрдэнэ

1. оролцогч тал, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид ба итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн овог, нэр, мэргэжил, оршин суух хаяг болон тэдгээрийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь эрх зүйн байдал,
2. шүүхийн нэр болон шийдвэр гаргахад оролцсон шүүх бүрэлдэхүүний

нэрс,

3. тогтоох хэсэг,
4. тодорхойлох хэсэг,
5. үндэслэх хэсэг,
6. давж заалдах буюу хяналтын журмаар гаргах гомдлын мэдээлэл.

(3)Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн агуулга, хэргийн бодит байдал, хэрэг маргааны үндсэн агуулгыг товч хэлбэрээр тусгаж, гаргасан хүсэлтүүдийг тэмдэглэсэн байна. Нарийвчилсан мэдээллийг бичмэл бичиг баримт, тэмдэглэл болон бусад материалаас авах боломжтой талаар эш татаж заана.

(4)Шүүхийн шийдвэр бичгээр бэлэн болоогүй тохиолдолд уншиж танилцуулснаас хойш хоёр долоо хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэж шүүхийн захиргаанд бүртгүүлнэ. Хэрэв хүргүүлэх боломжгүй онцгой нөхцөлд хэргийн үйл баримт, үндэслэх хэсэг болон давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргах мэдээллийг тусгаагүй шүүхийн шийдвэрийг шүүгч нарын гарын үсэгтэйгээр шүүхийн захиргаанд бүртгүүлнэ; дараа нь тодорхойлох, үндэслэх хэсэг болон давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргах мэдээлэлд шүүгч нар гарын үсгээ тусгайлан зурж шүүхийн захиргаанд даруй бүртгүүлнэ.

(5)Шүүхийн шийдвэрийн үндэслэл захиргааны актын үндэслэлийг агуулагдсан эсхүл эсэргүүцсэн үндэслэлийг баримтлан шийдвэр гаргасан бол шийдвэрийн үндэслэлийг тайлбарлахаас татгалзаж болно.

(6)Шүүхийн захиргааны ажилтан шийдвэр дээрх хүргүүлсэн өдөр болон §116.1-ийн 1 дэх өгүүлбэрт заасан тохиолдолд уншиж танилцуулсан өдрийг тэмдэглэж, гарын үсэг зуран бүртгэх үүрэгтэй. Хэрэв бичиг баримт цахимаар хадгалагдаж байгаа бол шүүхийн захиргааны ажилтан баримт бичигт тусгай тэмдэглэл хийж бүртгэнэ. Уг баримт бичиг нь шүүхийн шийдвэрийн нэг бүрдэл хэсэг болно.

§118

(1)Шүүхийн шийдвэр дэх үг, үсэг, тооны илэрхий алдааг шүүх хэдийд ч засаж болно.

(2)Урьдчилсан аман хэлэлцүүлэг хийлгүйгээр алдааг засах шийдвэр гаргаж болно. Засах тухай шийдвэрийг шүүхийн шийдвэр болон бусад хуулбаруудад тэмдэглэнэ. Хэрэв шүүхийн шийдвэрийн төсөл цахим хэлбэрт байгаа бол захирамжийг мөн цахим хэлбэрт оруулж, шүүхийн шийдвэрийн нэг бүрдэл хэсэг болно.

§119

(1)Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт алдаа эсхүл хоёрдмол утга

санаа илэрвэл шийдвэр гарснаас хойш хоёр долоо хоногийн дотор залруулга хийх хүсэлт гаргаж болно.

(2)Шүүх нотлох баримт шинжлэх ажиллагаа явуулахгүйгээр захирамж гаргана. Захирамж нь эцсийн шийдвэр байна. Шүүх шийдвэр гаргахад зөвхөн шүүх хуралдаанд оролцсон шүүгч оролцоно. Хэрэв шүүгч оролцох боломжгүй бөгөөд санал тэнцсэн тохиолдолд шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ. Залруулга оруулах тухай захирамжийг шүүхийн шийдвэр болон хуулбаруудад тэмдэглэнэ. Хэрэв шүүхийн шийдвэрийн төсөл нь цахим хэлбэрт байгаа бол захирамжийн төслийг мөн адил цахим хэлбэрт оруулж шүүхийн шийдвэрийн нэг хэсэг байдлаар холбоно.

§120

(1)Хэрэв тодорхойлох хэсэгт заасан оролцогч талуудын гаргасан хүсэлт эсхүл зардлын асуудал тогтоох хэсэгт бүрэн эсхүл хэсэгчлэн тусгагдаагүй тохиолдолд хүсэлтийн дагуу шүүх нэмэлт шийдвэр гарган нөхөн шийдвэрлэнэ.

(2)Шүүхийн шийдвэр гарснаас хойш хоёр долоо хоногийн дотор хүсэлт гаргана.

(3)Аман хэлэлцүүлгээр зөвхөн шийдвэрлэгдээгүй үлдсэн маргааны хэсгийг хэлэлцэнэ. Шүүхийн шийдвэрийн нэмэлт хэсэг нь зөвхөн нэмэлт хүсэлт эсхүл зардлыг шийдвэрлэх зорилготой бөгөөд аман хэлэлцүүлэг хийх нь хэрэгт ач холбогдолгүй бол аман хэлэлцүүлэг хийхгүй байж болно.

§121

Хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бол тухайн шүүхийн эцсийн шийдвэрийг дараах этгээдүүд биелүүлнэ

1. оролцогч тал болон тэдгээрийн эрх залгамжлагчид
2. §65.3-т заасан шүүхэд дуудах хуудас болон товлосон хугацаанд ирээгүй этгээдүүд

§122

(1)Шүүхийн шийдвэрт §88, §108.1-ийн 1 дэх өгүүлбэр, §118, §119 ба §120-р зүйлийг хэрэглэнэ.

(2)Шүүхийн шийдвэрт давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргах бол үндэслэлийг тусгана. Актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай захирамж(§80,§80а)болонурьдчилсанхамгаалалтынзахирамж(§123),үндсэн маргаан дахь эрх зүйн гол асуудлыг шийдвэрлэсний дараах захирамжуудад (§161.2) ямагт үндэслэлийг заана. Шүүх маргаан бүхий шүүхийн шийдвэрийн үндэслэлд гаргасан давж заалдах гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд давж заалдах буюу хяналтын журмаар гаргасан гомдлын шийдвэрт нэмэлт

тайлбар, үндэслэл тусгах шаардлагагүй.

Арван нэгдүгээр хэсэг.
УРЬДЧИЛСАН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРАМЖ

§123

(1) Хэргийг хянан шийдвэрлэж эхлэхээс өмнө хүсэлт гаргагчийн эрхийг үгүйсгэх эсхүл ноцтой хүндрэл учруулж болзошгүй нөхцөл байдал байгаа бол маргааны зүйлтэй холбоотой урьдчилсан хамгаалалтын захирамжийг хүсэлтийн дагуу шүүх гаргах боломжтой. Явцын захирамжийг маргаантай эрх зүйн харилцааны түр зуурын нөхцөл байдлыг зохицуулах, эрх зүйн харилцаа үргэлжилж байгаа тохиолдолд хохирол үүсэхээс урьдчилан сэргийлэх болон бусад шалтгаанаар зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гаргана.

(2) Урьдчилсан хамгаалалтын захирамж гаргах эрх бүхий шүүх нь хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх байна. Энэ нь анхан шатны шүүх байх бөгөөд хэрэв хэрэг давж заалдах болон хяналтын шатанд хянан шийдвэрлэгдэж байгаа бол давж заалдах болон хяналтын шатны шүүх байна. Энэ тохиолдолд §80.8-ыг хэрэглэнэ.

(3) Урьдчилсан хамгаалалтын захирамж гаргахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §920, §921, §923, §926, §928-932, §938, §939, §941, §945-ыг хэрэглэнэ.

(4) Шүүх захирамж гаргаж шийдвэрлэнэ.

(5) 1-3 дахь хэсгийн заалтуудад §80 болон §80а хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ БА ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ

Арван хоёрдугаар хэсэг. ДАВЖ ЗААЛДАХ ШАТ

§124

(1)Захиргааны хэргийн анхан шатны эсхүл давж заалдах шатны шүүх хүлээж авах үндэслэлтэй гэж үзсэн бол талууд §110-д заасан хэсэгчилсэн шийдвэр, §109, §111-д заасан явцын шийдвэрийн эсрэг давж заалдах эрхтэй.

(2)Зөвхөн дараах тохиолдолд давж заалдах гомдлыг хүлээн авна,

1. шүүхийн шийдвэр үнэн зөв эсэхэд ноцтой эргэлзээ байгаа бол,
2. хэрэг нь үйл баримтын болон эрх зүйн хувьд онцгой төвөгтэй бол,
3. хэрэг нь зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой бол,
4. шүүхийн шийдвэр нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Холбооны захиргааны хэргийн шүүхийн Нэгдсэн Танхим, эсхүл Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс зөрүүтэй бөгөөд энэ нь шийдвэрийн үндэслэл болсон бол, эсхүл
5. давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэх асуудалд хамаарах, шүүхийн шийдвэрт нөлөөлж болохуйц хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчил гаргасан бол.

§124a

(1) Захиргааны хэргийн шүүх §124.2-ын 3, 4 дэх өгүүлбэрт заасан үндэслэл байвал давж заалдах гомдол гаргах эрхтэйг хүлээн зөвшөөрнө. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх гомдлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Давж заалдах гомдлыг зөвшөөрөөгүй шийдвэрт гаргасан гомдлыг Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэх эрхгүй.

(2)Захиргааны хэргийн анхан шатны шүүх давж заалдах гомдол гаргах эрхтэй гэж заасан бол шийдвэрийг бүрэн эхээр нь гардуулснаас хойш нэг сарын дотор давж заалдах гомдол гаргана. Давж заалдах гомдолд эс зөвшөөрсөн шүүхийн шийдвэрийн үйл баримт, хууль зүйн асуудлыг тодорхой заана.

(3)Шийдвэрийг бүрэн эхээр нь гардуулснаас хойш 2 дахь хэсэгт заасан тохиолдолд хамаарах давж заалдах гомдлын үндэслэлийг хоёр сарын дотор гаргана. Давж заалдах гомдлын хамт үндэслэлийг ирүүлээгүй бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд шууд хүргүүлнэ. Үндэслэлийг ирүүлэх эцсийн хугацааг сенатын даргалагчийн хүсэлтийн дагуу сунгаж

болно. Үндэслэлд тодорхой хүсэлт, эс зөвшөөрсөн (давж заалдах гомдлын) үндэслэлүүдийг нэг бүрчлэн зааж тусгасан байна. Эдгээр шаардлагын аль нэгийг хангаагүй бол давж заалдах гомдлыг хүлээн авахгүй.

(4)Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй гэж заасан тохиолдолд шийдвэрийг бүрэн эхээр нь гардуулснаас хойш нэг сарын дотор гомдол хүлээн авах тухай хүсэлт гаргана. Хүсэлтийг захиргааны хэргийн шүүхэд гаргана. Хүсэлтэд холбогдох шүүхийн шийдвэрийг тодорхой зааж өгөх ёстой. Шийдвэрийг бүрэн эхээр нь гардуулснаас хойш давж заалдах гомдлыг хүлээн авбал зохих үндэслэлийг хоёр сарын дотор ирүүлнэ. Хүсэлтийн хамт үндэслэлийг ирүүлээгүй бол захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд шууд хүргүүлнэ. Хүсэлт гаргаснаар шийдвэрийг түдгэлзүүлнэ.

(5)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хүсэлтийг шийдвэрлэхдээ захирамж гаргана. §124.2-т заасан үндэслэлүүдийн аль нэг байгаа бол давж заалдах гомдлыг хүлээн авна. Захирамжид үндэслэлийг товч тусгасан байна. Хүсэлтийг буцааснаар шүүхийн шийдвэр эцсийнх болно. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлыг хүлээн авахаар шийдвэрлэвэл хүсэлт хянан шийдвэрлэх ажиллагааг давж заалдах журмаар үргэлжлүүлэх бөгөөд давж заалдах гомдлыг тусад нь дахин гаргах шаардлагагүй.

(6)5 дахь хэсэгт заасан давж заалдах гомдлыг хүлээн авах тухай хүсэлтийг хангах шийдвэрийг гардуулснаас хойш 1 сарын дотор давж заалдах гомдлын үндэслэлийг гаргана. Үндэслэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ. 3 дахь хэсгийн 3-5 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ.

§125

(1)Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус бүлэгт заасан хэм хэмжээ үйлчилнэ. §84 үүнд хамаарахгүй.

(2)Давж заалдах гомдол зөвшөөрөгдөөгүй бол түүнийг хэрэгсэхгүй болгоно. Шийдвэрийг захирамжаар гаргаж болно. Захирамж гаргахаас өмнө хэргийн оролцогчдын байр суурийг сонсоно. Шүүхийн захирамж гарсан тохиолдолд талууд уг захирамжийг давж заалдах эрхтэй. Давж заалдах эрхийн талаар хэргийн оролцогчдод мэдэгдэнэ.

§126

(1)Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл давж заалдах гомдлоос татгалзаж болно. Аман хэлэлцүүлгийн явцад хүсэлт гаргасны дараа гомдлоос татгалзах тохиолдолд хариуцагчийн зөвшөөрөл, нийтийн

ашиг сонирхлын төлөөлөгч оролцож байгаа бол мөн түүний зөвшөөрөл шаардлагатай.

(2) Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүхийн шаардлагыг үл харгалзан 3 сараас дээш хугацаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй тохиолдолд тус гомдлоо буцаан авсанд тооцно. Үүнд 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэр үйлчилнэ. Шүүх §155.2-ын эхний өгүүлбэрт байх эрх зүйн үр дагаврыг давж заалдах гомдол гаргасан этгээдэд анхааруулна. Шүүхээс давж заалдах гомдлоос татгалзсанд тооцсон тухай захирамж гаргана.

(3) Гомдлоос татгалзсанаар дахин давж заалдах гомдол гаргах эрхээ алдана. Шүүхээс захирамж гарган зардлын үр дагаврыг шийдвэрлэнэ.

§127

(1) Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагч болон бусад хамааралтай этгээдүүд давж заалдах гомдолд нэгдэж болно. Энэ хүсэлтийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргана.

(2) Оролцогч тал давж заалдах гомдлоос татгалзсан эсхүл гомдол гаргах хугацаа, давж заалдах хүсэлт гаргах хугацаа хэтэрсэн ч гомдолд нэгдэх хүсэлт гаргаж болно. Давж заалдах гомдлын үндэслэлийг гардуулснаас хойш нэг сарын дотор тус хүсэлтийг гаргана.

(3) Давж заалдах гомдолд нэгдэх тухай үндэслэлээ хүсэлтэд тусгана. §124.3-ын 2, 4, 5 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ.

(4) Давж заалдах гомдолд нэгдэхэд зөвшөөрөл авах шаардлагагүй.

(5) Давж заалдах гомдлыг эргүүлэн татах эсхүл хүлээн авах боломжгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгосон бол гомдолд нэгдэн орох нь хэрэгсэхгүй болно.

§128

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх маргааныг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн адил хэргийн үйл баримт болон хууль хэрэглээний хүрээнд хянана. Мөн шинээр ирүүлсэн үйл баримт, нотлох баримтыг мөн харгалзан үзнэ.

§128a

(1) Тогтоосон хугацаанаас үл хамааран анхан шатны шүүхэд зохих хугацаанд ирүүлээгүй тайлбар, нотлох баримтыг (§87b-ийн 1, 2 дахь хэсэг) шүүхээс зөвхөн тэдгээр нь маргаан шийдвэрлэх явцыг удаашруулахгүй, эсхүл оролцогч хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзсэн тохиолдолд л гаргахыг зөвшөөрнө. Шүүх шаардвал хүндэтгэн үзэх шалтгаанаа нотлох ёстой. Анхан

шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад §87b.3-ын 3-т зааны дагуу оролцогчид хугацаа хэтрүүлсний үр дагаврын талаар мэдэгдээгүй, эсхүл хэргийн нөхцөл байдлыг оролцогчийн шаардлагагүйгээр тодорхойлох боломжтой бол 1 дэх өгүүлбэр хамаарахгүй.

(2)Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн татгалзсан тайлбар, нотлох баримтыг давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж үл болно.

§129

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг зөвхөн өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргасан тохиолдолд өөрчилж болно.

§130

(1)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авч, өөрийн үзэмжээр шийдвэр гаргана.

(2)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь шүүхийн шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүчингүй болгох замаар маргааныг дахин хэлэлцүүлэх шаардлагатай бол, зөвхөн дараах тохиолдолд Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд буцаана.

1. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой алдаа зөрчил гарсан ба энэхүү алдаа зөрчлөөс үүдэн өргөн цар хүрээтэй, нотлох баримт шинжлэх ажиллагаа хийх шаардлагатай болсон, эсхүл
2. Захиргааны хэргийн анхан шатны шүүх уг маргааныг эцэслэн шийдвэрлээгүй ба холбогдох тал буцаах хүсэлт гаргасан бол.

(3)Захиргааны хэргийн анхан шатны шүүх нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрт заасан эрх зүйн дүгнэлтүүдийг биелүүлэх үүрэгтэй.

§130a

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх санал нэгтэйгээр давж заалдах гомдлыг үндэслэлтэй эсхүл үндэслэлгүй гэж дүгнэн, аман хэлэлцүүлэг хийх шаардлагагүй гэж үзвэл захирамжаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд §125.2-ын 3-5 дахь өгүүлбэрийг хэрэглэнэ.

§130b

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хэвээр үлдээсэн бол, давж заалдах гомдол дахь маргаан бүхий шийдвэрийн бүрэлдэхүүн хэсгийг эшилж болно. Маргаан бүхий шийдвэрийн үндэслэлд тулгуурлан шүүх давж

заалдах гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн бол шийдвэрийн үндэслэлийг дахин тайлбарлах шаардлагагүй.

§131 (хүчингүй болсон)

**Арван гуравдугаар хэсэг.
ХЯНАЛТЫН ШАТ**

§132

(1)Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх эсхүл Холбооны захиргааны хэргийн шүүх хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэргийн оролцогчид Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр (§49.1), ба §47.5-ын 1 дэх өгүүлбэрт заасны дагуу Холбооны захиргааны хэргийн шүүхэд хяналтын гомдол гаргах эрхтэй.

(2)Зөвхөн дараах тохиолдолд хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авна.

1. тус хэрэг зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой,
2. шүүхийн шийдвэр нь Холбооны захиргааны хэргийн шүүх, Холбооны дээд шүүхүүдийн нэгдсэн танхим ба Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс зөрүүтэй бөгөөд энэ нь шийдвэрийн үндэслэл болсон бол, эсхүл
3. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчил нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон бол.

(3)Холбооны захиргааны хэргийн шүүх нь зөвшөөрөгдсөн гомдлыг хянан шийдвэрлэнэ.

§133

(1)Хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээж авахаас татгалзсан шийдвэрт гомдол гаргаж болно.

(2)Магадлалыг бүрэн эхээр нь гардуулснаас хойш 1 сарын дотор тухайн магадлалыг гаргасан шүүхэд хяналтын журмаар гомдол гаргаж болно. Гомдолд маргаж буй шүүхийн магадлалыг тусгана.

(3)Шүүхийн магадлалыг бүрэн эхээр нь гардуулснаас хойш хоёр сарын дотор гомдлын үндэслэлээ гаргана. Тухайн үндэслэлийг магадлалыг гаргасан шүүхэд гаргана. Үндэслэлд хэргийн зарчмын нийтлэг ач холбогдол, магадлал ямар шийдвэрээс зөрүүтэй байгаа эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарсан алдаа зөрчлийг тусгана.

(4)Хяналтын журмаар гомдол гаргаснаар магадлалыг түдгэлзүүлнэ.

(5)Хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн аваагүй бол Холбооны захиргааны хэргийн шүүх захирамж гаргана. Захирамжид товч үндэслэлийг

тусгах ба хяналтын журмаар гомдол гаргах урьдчилсан нөхцөлийг тодруулах боломжгүй бол үндэслэлийг тусгахгүй байж болно. Холбооны захиргааны хэргийн шүүх гомдлыг хэрэгсэхгүй болгосноор магадлал эцсийнх бөгөөд хүчин төгөлдөр болно.

(6)Хэрэв §132.2-ын 3-т заасан нөхцөл хангагдсан бол Холбооны захиргааны хэргийн шүүх магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж болно.

§134

(1)Нэхэмжлэгч, хариуцагч нар давж заалдах шатыг алгасаж шууд хяналтын журмаар гомдол гаргахыг бичгээр зөвшөөрсөн ба Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт энэ төрлийн гомдол гаргахыг дурдсан, мөн хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн бол давж заалдах шатыг алгасаж Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт (§49.2) хяналтын журмаар гомдол гаргаж болно. Хүсэлтийг шийдвэр бүрэн эхээр нь гарснаас хойш нэг сарын дотор бичгээр гаргана. Давж заалдах шатыг алгасаж шууд хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн бичгийг гомдолд хавсаргах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргахыг шүүхийн шийдвэрт зөвшөөрсөн бол гомдолд хавсаргана.

(2)Зөвхөн §132.2-ын 1, 2-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрнө. Гомдлыг Холбооны захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ. Гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэрт гомдол гаргах эрхгүй.

(3)Захиргааны хэргийн анхан шатны шүүх хяналтын журмаар гомдол гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох захирамжийг гардуулснаар давж заалдах гомдол гаргах хугацаа шинээр эхлэх бөгөөд тухайн хүсэлтийг хуульд заасан хугацаанд, хэлбэрийн дагуу гаргаж, хүсэлт гаргахыг зөвшөөрсөн мэдэгдлийг хавсаргасан байна. Харин Захиргааны хэргийн анхан шатны шүүх захирамж гарган, хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн захирамжийг гардуулснаар хяналтын журмаар гомдол гаргах хугацааг тоолж эхэлнэ.

(4)Хэрэг хянан шийдвэрлэх явцад гарсан алдаа зөрчил хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл болохгүй.

(5)Захиргааны хэргийн анхан шатны шүүх хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн бол хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авснаар давж заалдах гомдол гаргахаас татгалзсанд тооцогдоно.

§135

Холбооны хуульд давж заалдах гомдол гаргах эрхгүй гэж заасан бол оролцогчид Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тогтоолд Холбооны

захиргааны хэргийн шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй (§49.2). Зөвхөн Захиргааны хэргийн анхан шатны шүүх хяналтын журмаар гомдол гаргахыг хүлээн зөвшөөрсөн эсхүл Холбооны захиргааны хэргийн шүүхийн зөвшөөрөл өгөөгүй тухай гомдлын дагуу хянаад зөвшөөрсөн тохиолдолд хяналтын журмаар гомдол гаргаж болно. Гомдлыг хүлээн авахад §132, §133-ыг хэрэглэнэ.

§136 (хүчингүй болсон)

§137

(1)Маргаан бүхий шийдвэр нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хяналтын журмаар гаргах гомдлын үндэслэл болно.

1. Холбооны хууль эсхүл
2. Холбооны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийцсэн мужийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалт.

(2)Холбооны захиргааны хэргийн шүүх нь хяналтын журмаар гаргасан гомдолд маргааны үйл баримтын талаар үндэслэл бүхий, хууль ёсны үндэслэл гаргаснаас бусад тохиолдолд маргаан бүхийн шүүхийн шийдвэр дэх дүгнэлтийг баримтална.

(3)Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчилд үндэслэн хяналтын журмаар гаргасан гомдол нь §132.2-ын 1, 2-т заасан алинд ч хамаарахгүй бол зөвхөн маргаан бүхий хэргийг шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчлийн талаар шийдвэр гаргана. Бусад тохиолдолд Холбооны захиргааны хэргийн шүүх зөвхөн хяналтын журмаар гаргасан гомдолд заасан үндэслэлийг баримтлах үүрэг хүлээхгүй.

§138

Дараах тохиолдолд шүүхийн шийдвэр Холбооны хууль, тогтоомжийг зөрчсөн гэж үзнэ.

1. хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг зохих ёсоор бүрдүүлээгүй,
2. шүүгчээр ажиллах эрхийг хуулиар хориглосон эсхүл ашиг сонирхлын зөрчлөөс үүдэн татгалзан гаргасан шүүгч шийдвэр гаргахад оролцсон,
3. хэргийн аль нэг оролцогчийг шүүх хуралдаанд оролцуулахаас татгалзсан,
4. хэргийн аль нэг оролцогчийн төлөөлөл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхой үйлдлээр илэрхийлсэн болон үг дуугүйгээр хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд оролцоогүй бол,
5. аман хэлэлцүүлэг хийж захирамж гаргах, хэрэг хянан шийдвэрлэх

- ажиллагаа нээлттэй байх тухай дүрэм, журмыг зөрчсөн,
6. шийдвэрт үндэслэлийг тусгаагүй.

§139

(1) Шүүхийн магадлалыг бүрэн эхээр нь гардуулсан эсхүл §134.3-ын 2 дахь өгүүлбэрт заасан хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн захирамж гарснаас хойш нэг сарын дотор холбогдох шүүхийн шийдвэрийг гаргасан шүүхэд хяналтын журмаар гомдлыг бичгээр гаргана. Заасан хугацаанд Холбооны захиргааны хэргийн шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд хугацааг биелүүлсэн гэж үзнэ. Хяналтын гомдолд маргаан бүхий шүүхийн шийдвэрийг зааж өгөх ёстой.

(2) Хяналтын журмаар гомдол гаргахаас татгалзсан шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг хангасан, Холбооны захиргааны хэргийн шүүх хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хяналтын журмаар үргэлжилнэ. (Холбооны захиргааны хэргийн шүүх холбогдох магадлалыг §133.6-д заасны дагуу маргаан бүхий шийдвэрийг хүчингүй болгоогүй байна.) Энэ тохиолдолд гомдол гаргагчийн зүгээс хяналтын журмаар гомдол гаргах шаардлагагүй. Үүнийг шүүхийн захирамжид тусгана.

(3) Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэлийг магадлалд бүрэн эхээр нь эсхүл §134.3-ын 2 дахь өгүүлбэрт заасан хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн шийдвэрийг гардуулснаас хойш хоёр сарын дотор шүүхэд гаргана. 2 дахь хэсэгт заасан хяналтын журмаар гомдол гаргахыг зөвшөөрсөн захирамжийг гардуулснаас хойш нэг сарын дотор үндэслэлээ гаргана. Үндэслэлийг Холбооны захиргааны хэргийн шүүхэд гаргана. Шүүх хуралдаан даргалагч үндэслэл гаргах эцсийн хугацааг үндэслэл бүхий өргөдлийг үндэслэн сунгаж болно. Үндэслэлд хүсэлтээ тодорхойлж, зөрчигдсөн хууль тогтоомжийн талаар тусгасан байх ёстой бөгөөд, хэрэв гомдол нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчилтэй холбоотой бол нотлох баримтуудыг тусгасан байх ёстой.

§140

(1) Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө аль ч үед хяналтын журмаар гаргасан гомдлоос татгалзаж болно. Аман хэлэлцүүлэг эхэлснээс хойш гомдлоос татгалзах тохиолдолд хариуцагч, аман хэлэлцүүлэгт Холбооны ашиг сонирхлын төлөөлөгч оролцож байгаа бол тэдгээрийн зөвшөөрөл шаардлагатай.

(2) Гомдлоос татгалзсанаар дахин хяналтын журмаар гомдол гаргах эрхээ алдана. Шүүх захирамж гарган зардлын үр дагаврыг шийдвэрлэнэ.

§141

Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол хяналтын журмаар гомдол гаргахад давж заалдах гомдолд хамаарах хуулийн заалтуудыг хэрэглэнэ. Үүнд 87а, 130а ба 130b хамаарахгүй.

§142

(1)Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэлд өөрчлөлт оруулахыг мөн оролцогч нэмэлтээр татан оролцуулахыг хориглоно. Энэ нь §65.2-т заасан шүүхийн мэдэгдэх хуудаст хамаарахгүй.

(2)Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд §65.2-т заасны дагуу шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудагдан ирсэн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, зөрчлийн талаар гомдол гаргах эрхтэй. Гомдол гаргах эрхийг шүүхийн мэдэгдэх хуудсыг гардуулснаас хойш 2 сарын дотор хэрэгжүүлнэ. Хугацаа сунгах хүсэлтийг хугацаа дуусахаас өмнө гаргах бөгөөд хугацаа сунгах эсэхийг шүүх хуралдаан даргалагч шийдвэрлэнэ.

§143

Холбооны захиргааны хэргийн шүүх хяналтын журмаар гомдлыг хүлээн авах боломжтой эсэх, түүнийг хуульд заасан хэлбэр, хугацааны дотор, үндэслэл бүхий байгаа эсэхийг хянана. Эдгээр шаардлагын аль нэг нь хангагдаагүй бол хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авахгүй.

§144

(1)Хяналтын журмаар гомдлыг хүлээж аваагүй бол Холбооны захиргааны хэргийн шүүх хэрэгсэхгүй болгосон захирамж гаргана.

(2)Хяналтын журмаар гаргасан гомдол үндэслэлгүй бол Холбооны захиргааны хэргийн шүүх гомдлоос татгалзана.

(3)Хяналтын журмаар гаргасан гомдол үндэслэлтэй бол Холбооны захиргааны хэргийн шүүх:

1. хэргийг шийдвэрлэх тухай захирамж гаргана,
2. холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэх болон бусад үндэслэлээр буцааж болно.

Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд §142.1-ийн 2 дахь өгүүлбэрт заасан шүүх хуралдаанд дуудагдан оролцож буй этгээд үндэслэл бүхий ашиг сонирхолтой бол Холбооны захиргааны хэргийн шүүх хэргийг буцаана.

(4)Шийдвэрийн үндэслэл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийг зөрчсөн боловч бусад үндэслэлээр шийдвэрийг зөв гэж үзвэл хяналтын журмаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгоно.

(5) Хэрэв Холбооны захиргааны хэргийн шүүх §49.2, §134-т заасны дагуу давж заалдах шатыг алгасаж шууд хяналтын журмаар гаргасан гомдлыг дахин хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр буцаасан тохиолдолд гомдлыг харьяалан шийдвэрлэх үүрэг бүхий Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд буцааж болно. Үүний дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн маргааныг шийдвэрлэхдээ зохих ёсоор гаргасан гомдлыг хянан хэлэлцэх зарчмуудыг дагаж мөрдөнө.

(6) Маргааныг дахин хэлэлцэж, шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн шүүх нь шийдвэр гаргахдаа хяналтын шатны шүүхийн эрх зүйн дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргана.

(7) Холбооны захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчил нь шийдвэрт ноцтой нөлөөлөөгүй гэж үзсэн бол хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл ач холбогдолгүй гэж үзнэ. Энэ нь §138-д заасан гомдлуудад хамаарахгүй буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, зөрчлийн талаарх гомдол нь хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлд хамаарахгүй.

§145 (хүчингүй болсон)

Арван дөрөвдүгээр хэсэг. ГОМДОЛ, САНУУЛГА БОЛОН СОНСГОЛТОЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ

§146

(1) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хуралдаан даргалагч, илтгэгч шүүгчийн шийдвэр болон хураангуй шийдвэрээс бусад захирамжид хэргийн оролцогчид, эрх ашиг нь хөндөгдсөн этгээд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

(2) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулах, тодруулга хийхийг шаардсан, хуралдаан хойшлуулах эсхүл хугацаа тогтоох, нотлох баримт гаргуулах, нотлох баримт гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх буюу тусгаарлах, шүүхийн ажилтныг татгалзан гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хувь хүнд хувийн болон эдийн засгийн урьдчилсан нөхцөлийг хангаагүй гэж үзэн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын дэмжлэг авах өргөдлийг татгалзсан тухай захирамжуудад гомдол гаргах боломжгүй.

(3) Түүнчлэн хуульд заасан хяналтын журмаар гомдол хүлээн аваагүй шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргах эрхийг эс тооцвол, гомдлын зүйлийн үнэ 200 еврогоос их биш бол зардал, хураамжтай холбоотой асуудлаар гомдол гаргах боломжгүй.

(4)Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны захирамжийн эсрэг (§80, §80а, §123) гаргасан гомдлын үндэслэлийг нэг сарын дотор гаргана. Үндэслэлийг гомдлын хамт гаргаагүй бол үндэслэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргана. Үүнд гомдлын шаардлага, захирамжийг өөрчлөх эсхүл хүчингүй болгуулах үндэслэл, маргаантай шийдвэрийн талаар тусгасан байна. Энэхүү шаардлагын аль нэг нь хангагдаагүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгоно. Захиргааны хэргийн анхан шатны шүүх гомдлыг нэн даруй Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх бөгөөд үүнд §148.1 хамаарахгүй. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх зөвхөн гаргасан үндэслэлийн хүрээнд хянана.

(5)ба (6) (хүчингүй болсон)

§147

(1)Захирамжийг танилцуулснаас хойш 2 долоо хоногийн дотор уг захирамжийг гаргасан шүүхийн захиргааны ажилтанд бичгээр гомдол гаргах бөгөөд бүртгэлд тэмдэглүүлнэ. Энэ тохиолдолд §67.4 үйлчлэхгүй.

(2)Харьяаллын дагуу дээд шатны шүүхэд тогтоосон хугацаанд гомдлыг хүргүүлсэн бол гомдол гаргах хугацааг баримталсанд тооцно.

§148

(1)Холбогдох захирамжийг гаргасан Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл шийдвэрт өөрчлөх оруулах бөгөөд, бусад тохиолдолд нэн даруй Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

(2)Гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлсэн тухай Захиргааны хэргийн анхан шатны шүүх оролцогчдод мэдэгдэнэ.

§149

(1)Гомдлын агуулга нь зөвхөн захиргааны болон албадлагын арга хэмжээ авахтай холбогдолтой тохиолдолд гомдлыг түдгэлзүүлэх үйлчлэлтэй байна. Холбогдох захирамжийг гаргасан шүүх, шүүх хуралдаан даргалагч эсхүл илтгэгч шүүгч уг захирамжийн биелэлтийг түр хугацаагаар түдгэлзүүлэхээр шийдвэрлэж болно.

(2)Шүүхийн тухай хуулийн §178, §181.2 үйлчлэхгүй.

§150

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захирамж гарган гомдлыг шийдвэрлэнэ.

§151

Шүүхийн захирамжийг танилцуулснаас хойш хоёр долоо хоногийн дотор шүүгч, шүүхийн нарийн бичгийн ажилтны шийдвэрийг эс зөвшөөрч хянуулахаар хүсэлт гаргаж болно. Хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд шүүхийн захиргааны ажилтны бүртгэлд бүртгэнэ. §§147-149-р зүйлийг мөн адил хэрэглэнэ.

§152

(1) Энэ хуулийн §99.2 болон §133.1, мөн Шүүхийн тухай хуулийн §17а.4-ийн 4 дэх өгүүлбэрт зааснаас бусад тохиолдолд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн захирамжид Холбооны захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах боломжгүй.

(2) Холбооны захиргааны хэргийн шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс томилогдсон, хуваарилагдсан шүүгчийн болон шүүхийн нарийн бичгийн ажилтны гаргасан захирамжид §151-ийг хэрэглэнэ.

§ 152a

(1) Шүүхийн шийдвэрээр ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд гомдол гаргасан бол дараах нөхцөл байдал хангагдсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

(1) шүүхийн шийдвэрийн эсрэг давж заалдах болон бусад байдлаар гомдол гаргах боломжгүй,

(2) хэргийн оролцогчийн шүүх хуралдаанд оролцох эрхийг шүүхийн шийдвэрт нөлөөлөхүйц хэмжээнд зөрчсөн бол.

Эцсийн шийдвэрийн өмнө гарсан захирамжид гомдол гаргах боломжгүй.

(2) Шүүх хуралдаанд оролцох эрх зөрчигдсөнийг мэдсэнээс хойш 2 долоо хоногийн дотор гомдол гаргах бөгөөд мэдсэн хугацааг өөрөө нотолно. Маргаан бүхий шийдвэрийг танилцуулснаас хойш 1 жилийн хугацаа өнгөрсний дараа гомдол гаргах боломжгүй болно. Албан бусаар мэдэгдсэн шүүхийн шийдвэрийг шууданд хүлээлгэж өгснөөс хойш дөрөв дэх өдрөөс эхлэн мэдэгдсэнд тооцно. Гомдлыг бичгээр гаргах эсхүл шүүхийн захиргааны ажилтны тэмдэглэлд тусгуулна. §67.4 хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ. Гомдолд холбогдох захирамжийг тодорхой заах бөгөөд энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан урьдчилсан нөхцөлд хамаарч буй эсэхийг тодорхойлно.

(3) Шаардлагатай бол бусад оролцогчдод тайлбар гаргах боломж олгоно.

(4) Хэрэв гомдлыг хүлээн авах боломжгүй эсхүл хуульд заасан хэлбэр, хугацаанд гаргаагүй бол гомдлыг хүлээн авахаас татгалзана. Гомдол үндэслэлгүй бол шүүхээс хэрэгсэхгүй болгоно. Захирамж эцсийнх байх бөгөөд түүнд гомдол гаргах боломжгүй. Захирамжид товч үндэслэлийг тусгасан байна.

(5) Гомдол үндэслэлтэй бол түүнд үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг үргэлжлүүлэх замаар өөрчлөлт оруулна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг аман хэлэлцүүлэг дуусахаас өмнөх үе шатанд сэргээнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр явагдаж буй тохиолдолд аман хэлэлцүүлгийн дүгнэлтийг бичгээр мэдүүлэг өгөхөөр орлуулж болно. Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §343-ыг хэрэглэнэ.

(6)§149.1-ийн 2 дахь өгүүлбэрийг мөн адил хэрэглэнэ.

Арван тавдугаар хэсэг. **ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ**

§153

(1)Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасны дагуу дуусгавар болсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж болно.

(2)Холбооны Захиргааны хэргийн анхан шатны болон эцсийн шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нийтийн ашиг сонирхлын төлөөлөгч болон холбооны ашиг сонирхлыг төлөөлөгч этгээд хүчингүй болгох, нөхөн төлбөр олгох тухай нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАРДАЛ БА ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ

Арван зургаадугаар хэсэг. ЗАРДАЛ

§ 154

(1) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг ялагдсан тал хариуцна.

(2) Давж заалдах журмаар гаргасан гомдол хангагдаагүй бол давж заалдах гомдол гаргасан этгээд зардлыг төлнө.

(3) Шүүхэд дуудагдан ирсэн тал нь давж заалдах эсхүл хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд тус хэргийн оролцогч нь зардлыг төлөх бөгөөд §155.4 үйлчлэхгүй.

(4) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээсэн нь аль нэг оролцогчийн буруугаас шалтгаалаагүй бол зардлыг улсын төсвөөс төлж болно.

(5) Энэ хуулийн §80с.2-т заасан үндэслэлээр ялагдсан тохиолдолд шүүхийн зардлыг ялсан тал төлнө. Тус зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй.

§ 155

(1) Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хангаагүй бол зардлыг талууд харилцан нөхөх эсхүл хуваарилж төлнө. Зардлыг талууд харилцан нөхөж төлөх бол хэргийн оролцогчдод тэнцүү хуваарилж төлүүлнэ. Хэрэв нэг талын шаардлагын зарим хэсгийг хангаагүй бол нөгөө тал нь зардлыг бүхэлд нь хариуцаж болно.

(2) Хүсэлт, нэхэмжлэл, давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол эсхүл бусад эрхийг хамгаалах эрх зүйн аргаас татгалзсан этгээд нь зардлыг хариуцна.

(3) Хугацаа сэргээлгэх хүсэлт гаргасан этгээд холбогдох зардлыг хариуцна.

(4) Хэргийн аль нэг оролцогчийн буруутай үйлдлээс шалтгаалан гарсан зардлыг тухайн оролцогчоор төлүүлнэ.

§ 156

Хэрэв хариуцагчийн үйлдэл нэхэмжлэл гаргах үндэслэл болоогүй бөгөөд хариуцагч шаардлагыг нэн даруй хүлээн зөвшөөрсөн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг нэхэмжлэгч хариуцна.

§ 157 (хүчингүй болсонд тооцсон)

§ 158

(1)Маргааны үндэслэлийн талаарх шийдвэрийн эсрэг давж заалдах гомдол гаргахаас бусад тохиолдолд зардлын талаарх шийдвэрт гомдол гаргахгүй.

(2)Маргааны үндэслэлийн талаарх шийдвэр гараагүй бол зардлын талаарх шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

§ 159

Зардал төлөх үүрэг бүхий хэд хэдэн оролцогч байгаа тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §100 -г хэрэглэнэ. . Маргаан бүхий эрх зүйн харилцааг зардал төлөх үүрэг бүхий талын хувьд зөвхөн нэгдсэн журмаар шийдвэрлэх боломжтой бол хэд хэдэн этгээдэд нийт зардлыг төлөх үүрэг хүлээлгэж болно.

§ 160

Талууд эвлэрснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бөгөөд оролцогчид зардлын асуудлаар тохиролцоогүй бол шүүхийн зардлыг тэнцүү хариуцна. Шүүхийн бус зардлыг оролцогч талууд өөрөө хариуцна.

§ 161

(1)Шүүх шийдвэртээ зардлын асуудлыг шийдвэрлэх эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бусад хэлбэрээр дуусгавар болсон бол захирамж гарган зардлын асуудлыг шийдвэрлэнэ.

(2)Хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаа дууссан бол хуулийн §113.1-ийн 4 дэх өгүүлбэрт зааснаас бусад тохиолдолд шүүх үндэслэл бүхий сонгох боломжид үндэслэн шүүхийн зардлыг захирамж гарган шийдвэрлэнэ. Шийдвэр гаргахдаа хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Хариуцагчид эвлэрлийн тухай мэдэгдлийг хүргүүлснээс хойш 2 долоо хоногийн дотор гомдол гаргаагүй бөгөөд үүнээс гарах үр дагаврын талаар шүүх хариуцагчид мэдэгдсэн бол эрх зүйн маргаан нь хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаагаар шийдэгдсэн гэж үзнэ.

(3)Хуулийн §75-т заасан хэргийн хувьд нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргахаас өмнө хариуцагчийн шийдвэрт хууль ёсны итгэл хүлээлгэж байсан бол хариуцагч нь зардлыг хариуцна.

§ 162

(1)Зардалд шүүхийн зардал (улсын тэмдэгтийн хураамж ба бусад зардал) болон урьдчилсан хэлэлцүүлэг зэрэг талуудыг зохих хуулийн дагуу яллах, өмгөөлөхөд шаардагдах зардал орно.

(2)Хуулийн §67.2-ийн 2 дугаар өгүүлбэрийн 3 ба 3а-д заасан этгээдийн өмгөөлөгч эсхүл хуулийн зөвлөхийн хөлс болон бусад зардлыг хэзээд буцаан олгох боломжтой. Урьдчилсан хэлэлцүүлэгт итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулах шаардлагатай гэж шүүх үзсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж болон бусад зардлыг буцаан олгоно. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон төрийн байгууллага шуудан, харилцаа холбооны бодит зардлыг Хуульчийн үйлчилгээний хөлсний тухай хуулийн (Rechtsanwaltsvergütungsgesetz) 1-р хавсралтын № 7002-т заасан дээд дүнгээр нэхэмжилж болно.

(3)Гуравдагч этгээдийн шүүхийн бус зардлыг шүүх ялагдсан тал эсхүл улсын төсвөөс төлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд буцаан олгоно.

§ 163 (хүчингүй болсонд тооцсон)

§ 164

Анхан шатны шүүхийн нарийн бичиг, өргөдөлд үндэслэн буцаан олговол зохих зардлын дүнг тогтооно.

§ 165

Хэргийн оролцогч талууд буцаан олговол зохих дүнгийн талаар гомдол гаргаж болно. Энэ тохиолдолд хуулийн § 151 үйлчилнэ.

§ 165a

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн § 110 -г хэрэглэнэ.

§ 166

(1)Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын дэмжлэг үзүүлэх заалтууд болон тус хуулийн §569.3.2 үйлчилнэ. Татварын зөвлөх, татварын итгэмжлэгдсэн төлөөлөгч, аудитор, мэргэшсэн нягтлан бодогчийг хууль зүйн туслалцааны дэмжлэг авсан этгээдэд мөн томилж болно. Зардлыг Хуульчийн үйлчилгээний хөлсний тухай хууль дахь томилогдсон өмгөөлөгчийн тухай заалтуудыг баримтлан тогтооно.

(2)Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §114-116-т заасан хувь хүний болон санхүүгийн нөхцөл байдлыг (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §118.2-т заасан арга хэмжээ, §118.1-ийн 3 дахь өгүүлбэрт заасан эвлэрлийн баталгаажуулалт, §118.2-н 4-р өгүүлбэрт заасан шийдвэрийг багтаана) шалгах үүргийг, шүүх хуралдаан даргалагч холбогдох үүрэг өгсөн тохиолдолд тухайн шүүхийн захиргааны ажилтан гүйцэтгэнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын дэмжлэг олгох

урьдчилсан нөхцөл бүрдээгүй тохиолдолд шүүхийн захиргааны ажилтан тус хүсэлтэд татгалзсан шийдвэр гаргана. Харин урьдчилсан нөхцөл бүрдсэн тохиолдолд шүүхийн захиргааны ажилтан хүсэлт гаргагчийн хувь хүний болон санхүүгийн нөхцөл байдал, сар бүр хувааж төлөх дүн эсхүл хөрөнгөөс гаргуулах үнийн дүн зэргийг харгалзан, хүсэлт гаргагчид хууль зүйн туслалцаа олгох боломжтой тухай хавтаст хэрэгт тэмдэглэнэ.

(3)Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын дэмжлэг олгох асуудлыг шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн захиргааны ажилтан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §120.3-т заасны дагуу төлөлтийг зогсоох болон дахин эхлүүлэх хугацааг тогтоох мөн хуулийн § 120а болон 124.1.2-124.1.5 т заасны дагуу дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын татаас олгох зөвшөөрлийг өөрчлөх ба хүчингүй болгох үүрэгтэй.

(4)Шүүх хуралдаан даргалагч нь энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан үүргийг аль ч үед өөрөө хэрэгжүүлж болно. Хууль зүйн туслалцааны ажилтны тухай хуулийн (Rechtspflegengesetz) §5.1.1, §6, §7, §8.1-8.4 , §9 -д заасны дагуу хууль зүйн туслалцааны ажилтны үүргийг шүүхийн захиргааны ажилтан гүйцэтгэнэ.

(5)§87а.3 мөн адил үйлчилнэ.

(6)Энэ зүйлийн 2 ба 3 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн захиргааны ажилтны гаргасан шийдвэрийг мэдэгдсэн өдрөөс хойш 2 долоо хоногийн дотор шүүхийн шийдвэр гаргуулахаар хүсэлт гаргаж болно.

(7)Мужийн хуульд энэ зүйлийн 2-6 дахь хэсгийг муж улсын шүүхүүд хэрэглэхгүй гэж хуульчилж болно.

Арван долоодугаар хэсэг. ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ

§ 167

(1)Энэ хуульд өөрөөр заагаагүй бол шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагаа явуулахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн наймдугаар бүлгийн зохицуулалтыг хэрэглэнэ. Шийдвэр гүйцэтгэх шүүх нь анхан шатны шүүх байна.

(2)Хүчингүй болгуулах болон үүрэг хүлээлгэх нэхэмжлэлийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн хувьд зөвхөн зардалтай холбоотой хэсгийг урьдчилан гүйцэтгэх боломжтой гэж зарлаж болно.

§ 168

(1)Дараах шийдвэрийг гүйцэтгэнэ.

1. гүйцэтгэх боломжтой шүүхийн эцсийн болон явцын шийдвэр
2. урьдчилсан хамгаалалтын захирамж
3. шүүх дээр байгуулсан эвлэрлийн гэрээ,
4. зардлын дүнг тогтоосон захирамж,
5. шүүхээс албадан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн эцсийн эсхүл түр гүйцэтгэх боломжтой нийтийн эрх зүйн хүрээний арбитрын шийдвэр

(2) Шийдвэр гүйцэтгэх зорилгоор оролцогч талуудын хүсэлтэд үндэслэн шийдвэрийг тодорхойлох ба үндэслэх хэсэггүйгээр хуулбарласан хувийг гардуулж болно. Ийнхүү гардуулсан нь шийдвэрийг бүрэн эхээр нь гардуулсантай адил эрх зүйн үр дагавартай.

§ 169

(1) Шийдвэр гүйцэтгэл нь Холбоо, муж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нэгдэл, нутгийн өөрөө удирдах ёсны захиргааны нэгж эсхүл гишүүнчлэлтэй болон гишүүнчлэлгүй нийтийн эрх зүйн хуулийн этгээд, сангийн эрх ашгийн тулд явагдах тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийг Захиргааны байгууллагын шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн (Verwaltungsvollstreckungsgesetz) дагуу явуулна.

(2) Захиргааны байгууллагын шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд заасан шийдвэр гүйцэтгэх байгууллага гэдэг нь анхан шатны шүүхийн хуралдаан даргалагч байх бөгөөд шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор бусад шийдвэр гүйцэтгэх байгууллага эсхүл шийдвэр гүйцэтгэгчид үүрэг өгч болно. Муж улсын байгууллага хоорондын харилцан туслалцааны дагуу үйлдэл, эс үйлдэхүй, хorigийг муж улсын байгууллагаар албадан гүйцэтгүүлэх тохиолдолд муж улсын хууль тогтоомж үйлчилнэ.

§ 170

Холбоо, муж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нэгдэл, нутгийн өөрөө удирдах ёсны захиргааны нэгж эсхүл гишүүнчлэлтэй болон гишүүнчлэлгүй нийтийн эрх зүйн хуулийн этгээд, сангаас мөнгө гаргуулах шийдвэрийг гүйцэтгэх бол нэхэмжлэгчийн хүсэлтээр анхан шатны шүүх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах захирамж гаргана. Шүүх авбал зохих шийдвэр гүйцэтгэх арга хэмжээнүүдийг зааж, шийдвэрийг гүйцэтгэхийг холбогдох байгууллагад даалгана. Тус байгууллага нь өгсөн үүрэг, шийдвэр гүйцэтгэхэд баримталбал зохих өөрийн журмын дагуу уг даалгаврыг биелүүлэх үүрэгтэй. (2) Шүүх шийдвэр гүйцэтгэх захирамж гаргахаас өмнө тухайн байгууллага, гишүүнчлэлтэй болон гишүүнчлэлгүй нийтийн эрх зүйн хуулийн этгээд, сан, хууль ёсны төлөөлөгчид төлөвлөгдсөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар мэдэгдэж, шүүхээс тогтоосон хугацаанд шийдвэр

гүйцэтгэх шаардлага хүргүүлнэ. Энэ хугацаа нь 1 сараас илүүгүй байна.

(3) Тухайн зүйл (эд хөрөнгө) нийтийн үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай эсхүл худалдах нь нийтийн ашиг сонирхолд харшлах тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглоно. Шийдвэр гүйцэтгэлийг хянах үүрэг бүхий харьяаллын байгууллага, эсхүл Холбооны болон мужийн дээд байгууллагын шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой гомдол гарвал, шүүх нь харьяалах сайдын саналыг сонссоны дараа шийдвэр гаргана.

(4) Энэ зүйлийн 1-ээс 3 дугаар хэсэг нь нийтийн эрх зүйн санхүүгийн байгууллагын хувьд үйлчлэхгүй.

(5) Урьдчилсан хамгаалалтын захирамжийг гүйцэтгэх тохиолдолд албадан гүйцэтгэх тухай мэдэгдэл болон хугацаа баримтлах шаардлагагүй.

§ 171

Энэ хуулийн §169, 170.1-170.3-ын хувьд албадан гүйцэтгэх тухай заалт шаардлагагүй.

§ 172

Энэ хуулийн §113.1-н 2-р өгүүлбэр 5-р догол мөр мөн §123-т заасан тохиолдолд захиргааны байгууллага шүүхийн шийдвэр, түр хугацааны үйлчлэл бүхий хориглосон захирамжийг биелүүлээгүй бол анхан шатны шүүх хүсэлтэд үндэслэн хугацаа тогтоож, 10000 евро хүртэлх дүнгээр торгохыг сануулж болох бөгөөд тогтоосон хугацаа үр дүнгүй өнгөрвөл чиг үүргийн дагуу шийдвэр гүйцэтгэнэ. Торгуулийг хэд хэдэн удаа сануулж, тогтоож, шийдвэр гүйцэтгэж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН БА ШИЛЖИЛТИЙН ЗААЛТУУД

§173

Энэхүү хуульд тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх тодорхой заалт байхгүй тохиолдолд Шүүхийн тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, ялангуяа §278.5 болон §278a зүйлийг, тухайн хоёр процессын зарчмын ялгаа нь тухайн асуудлыг үгүйсгэхгүй бол хэрэглэнэ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §552b, §565-д заасан хууль хэрэглээний чиг хандлагыг тодорхойлох журмыг үл хэрэглэнэ. Шүүхийн тухай хуулийн арван долоодугаар бүлэгт заасан муж улсын давж заалдах шатны шүүхийг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр, Холбооны дээд шүүхийг Холбооны захиргааны хэргийн шүүхтэй дүйцүүлэн хэрэглэнэ. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тохируулан хэрэглэнэ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §1062-т заасан шүүх гэдэгт холбогдох захиргааны хэргийн анхан шатны шүүхийг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §1065-д заасан шүүх гэдэгт захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг тус тус ойлгоно.

§174

(1) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх этгээдийн хувьд, Германы Шүүгчийн тухай хуульд заасан шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлагатай адилаар их дээд сургуульд хууль эрх зүйн чиглэлээр дор хаяж гурван жилийн хугацаанд суралцаж, гурван жил дадлагажсаны дараа хуульд заасан шалгалтыг өгч мэргэшсэн байна.

(2) Дайнд оролцогчид үйлчлэх тусгайлсан шаардлагыг хангасан бол 1 дэх хэсэгт заасан урьдчилсан нөхцөл хангагдсанд тооцогдоно.

§175

Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн §43-ыг мөн адил хэрэглэгдэнэ.

§176

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, Германы шүүгчийн тухай хуулийн §29.1-д заасныг үл харгалзан захиргааны хэргийн анхан шатны

шүүхэд шүүхийн шийдвэр гаргахад дараах этгээд мөн оролцох эрхтэй:

1. Бүх насаар томилогдсон хоёр шүүгч, эсхүл
2. Бүх насаар томилогдсон нэг шүүгч, түр томилогдсон нэг шүүгч эсхүл томилолтын нэг шүүгч.

§177

(1)Холбооны засгийн газар эсхүл муж улсын нууцлалын журмын дагуу “Зөвхөн албан хэрэгцээнд” гэх ангиллаас дээгүүр ангилалтай бичиг баримт, хавтаст хэргийн материалыг 2035 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, §§55a-55d-д заасныг үл харгалзан цаасан хэлбэрээр үйлдэж, хөтөлж, дамжуулж болно. Холбооны засгийн газар эсхүл муж улсын нууцлалын журмын дагуу “Зөвхөн албан хэрэгцээнд” гэх ангиллаас дээгүүр ангилалтай бичиг баримт, хавтаст хэргийн материалыг, 2035 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, §§55a-55d-д зааснаас өөрөөр, цаасан хэлбэрээр дамжуулж болно. Нууц бичиг баримт ашиглах хүчин төгөлдөр үйлчилж байсан нууцлалын журам хүчин төгөлдөр хэвээр байна.

(2)Холбооны болон муж улсын засгийн газар өөрийн эрх мэдлийн хүрээнд, §55b-д заасныг үл харгалзан, цахимаар нээсэн хавтаст хэргийг тодорхой үйл явдлаас хойш 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл цаасан хэлбэрээр хөтлөхийг журмаар тогтоож болно. Цаасан хэлбэрээр хөтлөх зөвшөөрлийг тодорхой шүүх эсхүл тодорхой ажиллагаагаар хязгаарлана. Хэрэв энэ сонголтыг хийсэн бол тухайн журамд ямар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хавтаст хэргийг цахим хэлбэрээр хөтлөхийг захиргааны журамд зааж, нийтэд мэдэгдэх ёстой. Холбооны Засгийн газрын журам гаргахад Бундесратын зөвшөөрөл шаардлагагүй. Энэхүү эрхийг хуулийн дагуу Холбооны улсын холбогдох дээд шатны байгууллага эсхүл муж улсын дээд шатны байгууллагад шилжүүлж болно.

§178 and §179 ----

(Нэмэлт, өөрчлөлт оруулах заалтууд)

§180

Захиргааны хэргийн анхан шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Нийгмийн хамгааллын тухай хуулийн аравдугаар бүлэгт заасны дагуу гэрч эсхүл шинжээчээс мэдүүлэг авах, тэдгээрийг тангараг өргүүлэх ажиллагааг захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хуваарилалтын төлөвлөгөөнд заасан шүүгч хариуцаж явуулна. Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд мэдүүлэг өгөхөөс, шинжээчийн дүгнэлт гаргах болон тангараг өргөхөөс татгалзсан нь Захиргааны хэрэг

шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Нийгмийн хамгааллын тухай хуулийн аравдугаар бүлэгт заасны дагуу хуульд нийцэж буй эсэхийг хянаж шийдвэр гаргана.

§§181 and 182 ----

(Нэмэлт, өөрчлөлт оруулах заалтууд)

§183

Муж улсын Үндсэн хуулийн шүүх муж улсын хууль болон хуулийн зохицуулалтыг хүчингүй болсонд тооцсон нь тус хууль, журамд үндэслэн гаргасан, гомдол гаргах боломжгүй болсон шүүхийн шийдвэрүүд хүчинтэй хэвээр үлдэнэ. Энэхүү шийдвэрийг гүйцэтгэх нь муж улсын тусгай хуулийн дагуу зөвшөөрөгдөхгүй байж болно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §767-г тохируулан хэрэглэнэ.

§184

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг цаашид ч “Захиргааны харьяаллын шүүх” гэсэн хуучин нэрээр нэрлэж байхаар муж улс тогтоож болно.

§185

(1)Берлин ба Хамбург муж улсад §28-д заасан дүүрэг (Kreise) гэх үгийг дүүрэг (Bezirke) гэх үгээр орлуулан хэрэглэнэ.

(2)Берлин, Бранденбург, Бремен, Гамбург, Мекленбург-Форпоммерн, Сарланд болон Шлезвиг-Хольштайн муж улсууд нь §73.1-ийн 2 дахь өгүүлбэрээс зөрүүтэй хэрэглэхийг зөвшөөрнө.

(3)Берлин, Бремен муж улсуудад §48.1-ийн 1 дэх өгүүлбэрийн 8-д заасан муж улсын авто зам гэх ойлголтыг Берлиний Нийтийн эзэмшлийн замын тухай хуулийн §20.1-д заасан 1 дүгээр зэрэглэлийн зам, Бремен муж улсын нийтийн эзэмшлийн замын тухай хуулийн §3.1-ийн 1-д заасан А бүлгийн замаар тус тус орлуулан хэрэглэнэ.

§186

Хуулийн §22.3 нь Берлин, Бремен, Хамбург муж улсуудад мөн адил хэрэгжинэ, гэхдээ төрийн захиргааны байгууллагад сайн дураар ажилладаг этгээдийг иргэдийн төлөөлөгчөөр томилж үл болно. Шүүхийн тухай хуулийн танилцуулга хуулийн §6 мөн адил үйлчилнэ.

§187

(1)Муж улсууд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд хоорондын сахилгын

болон арбитрын харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх зорилгоор эд хөрөнгийн маргааныг шилжүүлж болох бөгөөд, захиргааны шүүхэд мэргэжлийн шүүхэд нэгтгэж, тэдгээрийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааг зохицуулж болно.

(2)Түүнчлэн муж улсууд хүний нөөцийн төлөөллийн эрх зүйн асуудлын хүрээнд захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдолтой, энэ хуулиас зөрүүтэй журмууд баталж болно.

(3)(хүчингүй болсон)

§188

Нийгмийн халамж, орогнол хүсэгчийн тэтгэмжийн тухай хууль, хүүхэд залуучуудад өгөх тусламж, дайнд нэрвэгдэгсдийн халамж, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж болон мэргэжлийн сургалтын дэмжлэгээс бусад халамжийн асуудлыг нэг танхим эсхүл нэг сенатад нэгтгэх ёстой. Энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн зардал (улсын тэмдэгтийн хураамж ба бусад зардал) авахгүй. Энэ нь нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага хоорондын нөхөн төлбөрийн маргаанд үл хамаарна.

§188a

Эдийн засгийн захиргааны эрх зүйн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгайлсан танхим эсхүл сенат байгуулж болно (Эдийн засгийн хэргийн танхим, эдийн засгийн хэргийн сенат). Үндсэн хуулийн эдийн засаг, эдийн засгийн удирдлага, зах зээлийн зохицуулалт ба гадаад худалдаа, худалдаа, шуудан, харилцаа холбооны эрх зүйн салбарыг арилжааны танхим эсхүл сенатад нэгтгэнэ. Түүнчлэн эдийн засгийн хэргийн танхим эсхүл сенатад эдийн засгийн захиргааны эрх зүйд хамааралтай бусад маргааныг шилжүүлж болно.

§188b

Төлөвлөлтийн эрх зүйн асуудлыг хариуцсан тусгайлсан танхим эсхүл сенат байгуулна. Тухайн танхим, сенатад төлөвлөлтийн эрх зүйн асуудлыг тусгайлан хариуцуулж болно.

§189

Хуулийн §99.2-т заасны дагуу шийдвэр гаргах зорилгоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Холбооны захиргааны хэргийн шүүхэд мэргэжлийн сенатуудыг байгуулна.

§190

(1) Энэ хуулиас зөрүүтэй дараах хуулиуд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ:

1. 1952 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн Дайны ачааллыг тэнцвэржүүлэх тухай хуулийн (Холбооны хуулийн мэдээ I, 446 дахь тал) нэмэлт өөрчлөлт тусгасан найруулга,
2. 1951 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн Даатгал болон хадгаламжийн банкны асуудлаарх Холбооны хяналтын алба байгуулах тухай хууль (Холбооны хуулийн мэдээ I, 480 дахь тал), мөн 1954 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Даатгал болон хадгаламжийн банкны асуудлаарх Холбооны хяналтын алба байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (Холбооны хуулийн мэдээ I, 501 дэх тал),
3. (хүчингүй болсон)
4. 1953 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг дахин хуваарилах тухай хууль (Холбооны хуулийн мэдээ I, 591 дэх тал),
5. 1955 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Хүний нөөцийн төлөөллийн тухай хууль (Холбооны хуулийн мэдээ I, 477 дахь тал),
6. 1956 оны 12-р сарын 23-ны өдрийн Зэвсэгт хүчинд гомдол гаргах журам (Холбооны хуулийн мэдээ I, 1066 дахь тал),
7. 1956 оны 12-р сарын 08-ны өдрийн Дайнд олзлогдогсдын нөхөн олговрын тухай хууль (Холбооны хуулийн мэдээ I, 908-р тал),
8. Патентын тухай хуулийн §13.2 ба Германы патентын албанд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтууд.

(2) (хүчингүй болсон)

(3) (хүчингүй болсон)

§191

(1) (Нэмэлт, өөрчлөлт оруулах заалтууд)

(2) Төрийн албаны эрх зүйн орчны тухай хуулийн §127 ба Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §54 хэвээр үйлчилнэ.

§192

(Нэмэлт, өөрчлөлт оруулах заалтууд)

§ 193

Үндсэн хуулийн шүүх байхгүй муж улсын хувьд, Үндсэн хуулийн шүүх байгуулагдах хүртэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд шилжүүлсэн муж улс доторх үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэх чиг үүрэг хэвээр үлдэнэ.

§194

(1) Давж заалдах гомдлыг хүлээн авах боломж нь 2001 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр хуульд нийцсэн байх ёстой. Хэрэв 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө бол:

1. маргаж буй шүүхийн шийдвэрийг гаргах аман хуралдааныг хаалттай явуулсан бол,
2. аман хэлэлцүүлэггүйгээр явагдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн захиргаанаас талуудад үйлчлэх зорилгоор маргаан бүхий захирамж гаргасан бол.

(2) Түүнчлэн шүүхийн шийдвэрийг 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө зарласан, уншиж танилцуулсан, албан ёсоор гардуулсан бол давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрх нь 2001 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл мөрдөгдөж байсан хуулиар зохицуулагдана.

(3) 2002 оны 01 дүгээр сарын 01-ээс өмнө хууль зүйн туслалцаатай холбоотой шийдвэрийн эсрэг давж заалдах гомдлыг хугацаанд нь гаргасан бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хүлээн авна.

(4) 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ өдрөөс өмнө нэхэмжлэл гаргах хугацааг тоолж эхэлсэн, 2002 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнө нийтэлсэн, уншиж танилцуулсан, албан ёсоор гардуулсан шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахтай холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын төлөөлөлд энэ өдөр хүртэл мөрдөгдөж байсан хуулийн зохицуулалт үйлчилнэ.

(5) 2002 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн тохиолдолд §40.2-ын 1 дэх өгүүлбэр, §154.3, §162.2-ын 3 дахь өгүүлбэр болон §188-ын 2 дахь өгүүлбэрийг энэ өдөр хүртэл мөрдөгдөж байгаа агуулгаар тус тус хэрэглэнэ.

(6) 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй байсан дайны хохирогчдын нийгмийн халамжтай холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мөрдөгдөж буй §67.2-ын 2 дахь өгүүлбэрийн 6-д заасан найруулга үргэлжлэн үйлчилнэ.

§195

(1) (Хүчин төгөлдөр болох)

(2)- (6) хүртэл (хүчингүй болсон, өөрчлөлт оруулсан болон хугацаа нь дууссан заалтууд)

(7) 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үйлчилж байсан хуулийн §47.2-т заасан хугацаа нь 2007 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнөх §47 дугаар зүйлд бүрэн хамаарна.

НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГА

Герман хэл	Англи хэл	Монгол хэл
Klage	Action	Нэхэмжлэл
Verwaltungsakt	Administrative act	Захиргааны акт
Verwaltungsgericht	Administrative Court	Захиргааны хэргийн анхан шатны шүүх
Verwaltungsverfahren	Administrative procedure	Захиргааны үйл ажиллагаа
Anlage	Annex	Хавсралт
Berufung	Appeal on points of fact and law	Давж заалдах шат
Revision	Appeal on points of law	Хяналтын шат
Antrag	Application	Гомдол, Өргөдөл
Begründung	Reasoning	Үндэслэл
Vorstände	Board	ТУЗ
Kammer	Chamber	Танхим
Bewürdigung	Conviction	Итгэл үнэмшил
Widerklage	Counteraction	Сөрөг нэхэмжлэл
Gerichtsverfassungsgesetzes	Courts Constitution Act	Шүүхийн тухай хууль
Erklärungen	declaration	мэдүүлэг
Beschluss	Decree	Тогтоол
Streitsache	Dispute	Хэрэг, маргаан
Gerichtsbezirke	district	Дүүрэг
Entwürfe zu Urteilen	Draft judgment	Шүүхийн шийдвэрийн төсөл
Verpflichtungsklage	Enforcement action	Үүрэг хүлээлгэх нэхэмжлэл
Reminder	Erinnerung	Сануулга
Beweismittel	Evidence	Нотлох баримт
Ausschließung	Exclusion	Шүүгч өөрөө татгалзан гарах
Sachverständige	Expert witness	Шинжээч
Bundesverwaltungsgericht	Federal Administrative Court	Холбооны захиргааны хэргийн шүүх
ordentliche Professoren	Full professors	Хууль зүйн их сургуулийн орон тооны профессор
Großer Senat	Grand senate	Их сенат
Oberverwaltungsgericht	Higher Administrative Court	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
ehrenamtliche Richter	Honorary judge	Иргэдийн төлөөлөгч шүүгч
Identifizierungsverfahren	Identification procedure	Таньж тогтоох ажиллагаа
Zwischenurteil	Interim judgment	Явцын шийдвэр
Urteile	Judgments	Шүүхийн шийдвэр
Ein gerichtlicher Vergleich	Judicial settlement	Эвлэрэл
Vertreter	Legal representative	Хууль ёсны төлөөлөгч
Rechtsnachfolger	Legal successor	Хууль ёсны өв залгамжлагч
Mitglied des Gerichts	Member of the court	Шүүхийн гишүүн буюу шүүгч зэрэг албан тушаалтнууд
entsprechend anzuwenden	mutatis mutandis	-р зүйлийг хэрэглэнэ
Wiedereinsetzungsantrag	Omitted legal act	Эс үйлдэхүй

mündliche Verhandlung	Oral hearing	Аман хэлэлцүүлэг /хуралдаан/
Verfügungen	Order	Захирамж
Teilurteil	Partial judgment	Хэсэгчилсэн шийдвэр
Beteiligten	Party	Хэргийн оролцогч
Vorbereitende Schriftsätze	Preparatory documents	Урьдчилсан мэдүүлэг
Präsident	President	Ерөнхий шүүгч
Vorsitzende	Presiding judge	Шүүх хуралдаан даргалагч (Байнгын шинжтэй байдгаараа Монгол Улсаас ялгаатай)
Ablehnung	rejection	Шүүгчээс татгалзах
Gutachten	report	тайлан
Der Berichterstatter	Reporting judge	Илтгэгч шүүгч
Antrag	Request	Хүсэлт
Wiederaufnahme des Verfahrens	Resumption of the proceedings	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх
Fällen	Section	Зүйл
Aussagen	Statement	Мэдэгдэл
	Subpoena	Мэдэгдэх хуудас
	subpoena others ex officio	Албан ёсоор дуудан ирүүлэх
Richter auf Zeit	Temporary judge	Хугацаат шүүгч
der Verwaltungsakt	The administrative act	Захиргааны акт
die Prozessakten	The case files	Хавтаст хэрэг
der Beklagte	The defendant	хариуцагч
den Tatbestand	The facts	Хэргийн үйл баримт
der Kläger	The plaintiff	нэхэмжлэгч
die Entscheidungsgründe	The reasoning for the ruling	Үндэслэх хэсэг
der Vertreter des öffentlichen Interesses	The representative of the public interest	Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөгч
die Urteilsformel	The ruling	Тогтоох хэсэг
der Beigeladene	The subpoenaed party	Гуравдагч этгээд
Bei Kriegsteilnehmern	War participants	Дайнд оролцогчид
Zeugen	Witness	Гэрч

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БҮТЭЦ, ХЭЛЛЭГИЙН ОРЧУУЛГА

Герман	Англи	Монгол	Хууль зүйн утга, үүрэг	Жишээ	Монгол хэлэнд буулгасан жишээ
Teil	Part	Бүлэг	Хуулийн үндсэн хэсэг, тодорхой сэдвийн хүрээтэй бүлэг	Part I	1-р бүлэг
Abschnitt	Chapter	Хэсэг	Нэг бүлгийн доторх дэд ангилал, нарийвчилсан бүлэг	1st Chapter	1-р хэсэг
§ (Fällen)	Section	Зүйл	Хуулийн үндсэн нэгж; тодорхой зохицуулалт бүхий нэг заалт	§ 80	§80
Absatz	subsection	Хэсэг	Нэг зүйлийн доторх хэсэг	§ 80 (2)	§80.2
Satz	Sentence	Өгүүлбэр	Нэг зүйл, хэсэг доторх өгүүлбэр	§ 80 (2) Sentence 1	§80.2-ын 1 дэх өгүүлбэр
Nummer (Nr.)	Number №	Дэх/дахь	Хэсэг доторх өгүүлбэрийн дугаар	§ 80 (2) Sentence 1 No. 1	§80.2-ын өгүүлбэрийн 1-т

